



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**ӨГӨГДЛИЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА**

**2026 он**

## АГУУЛГА

<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>4</b>
<b>ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>4</b>
<b>I. УДИРТГАЛ</b> .....	<b>5</b>
<b>II. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ</b> .....	<b>9</b>
2.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал .....	9
2.2 Эрх ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд .....	16
2.3 Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан .....	16
2.4. Монгол Улсын цахим шилжилтийн өнөөгийн нөхцөл байдал .....	18
2.5. Монгол Улсын өгөгдлийн бодлого, зохицуулалтын орчныг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин .....	22
<b>III. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ</b> .....	<b>27</b>
<b>IV. ТУХАЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ</b> .....	<b>28</b>
<b>V. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ</b> .....	<b>30</b>
5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө .....	30
5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө .....	32
5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө .....	33
5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө .....	35
5.5. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх .....	35
<b>VI. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ</b> .....	<b>36</b>
6.1. Өгөгдлийн зах зээл болон олон улсын туршлага .....	36
6.2. Олон улсын өгөгдлийн чиглэлийн бодлого, зохицуулалтын орчин .....	36
6.3. Улс орны өгөгдлийн ангиллын тогтолцоо .....	43
6.5. Улс орны өгөгдлийн чиглэлийн байгууллагын бүтэц, хуулийн хэрэгжилт .....	50
6.6. Улс орны дата төвийн бодлого, урамшуулал .....	53
<b>VII. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b> .....	<b>63</b>
<b>НОМ ЗҮЙ</b> .....	<b>67</b>
<b>ХАВСРАЛТ</b> .....	<b>71</b>

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

<b>БНЭсУ</b>	Бүгд Найрамдах Эстони Улс
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>ЦХИХХЯ</b>	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
<b>ЗГ</b>	Засгийн Газар
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ЮНЕСКО</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>GDPR</b>	General Data Protection Regulation
<b>AI</b>	Artificial intelligence
<b>GPU</b>	Graphics processing unit
<b>WIPO</b>	World Intellectual Property Organization

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. НҮБ-ын эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газрын өгөгдлийн засаглалын үзэл баримтлал.....	10
Зураг 2. Key Hyperscaler буюу дэлхийн томоохон hyperscale cloud үйлчилгээ үзүүлэгчид, Colocation Leaders буюу colocation дата төвийн зах зээлийн тэргүүлэгч компаниуд.....	55
Зураг 3. Дэлхийн дата төвүүдийн эрчим хүчний хэрэглээний өсөлт .....	56
Зураг 4. Дэлхийн дата төвийн колокейшн (colocation) зах зээлийн хэмжээ бүс нутгаар хэрхэн өсөж байгааг харуулсан.....	57
Зураг 5. Дэлхийн дата төвийн колокейшн (colocation) зах зээлийн хэмжээг бүс нутгаар харуулсан.....	57
Зураг 6. Хиймэл оюун болон уламжлалт дата төвийн эзлэх хувь.....	58
Зураг 7. Сэргээгдэх эрчим хүчний хангамж ба 2030 оны зорилт.....	58

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэр томъёо.....	11
Хүснэгт 2. Олон улсын эрх зүйн баримт бичиг дахь өгөгдлийн тодорхойлолт.....	13
Хүснэгт 3. Монгол Улсын төрийн үйлчилгээг цахимаар хүргэж буй томоохон систем.....	19
Хүснэгт 4. Монгол Улсын Цахим засаглалын хөгжлийн индекс 2003-2024 (E-Government Development Index, EGDI).....	21
Хүснэгт 5. Монгол Улсын бодлогын баримт бичигт их өгөгдлийн талаар тусгагдсан байдал.....	23
Хүснэгт 6. Монгол Улсын хууль тогтоомжид их өгөгдлийн талаар тусгагдсан байдал.....	25
Хүснэгт 7. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал.....	28
Хүснэгт 8. Эстонийн өгөгдлийн бодлогын үр дүнг, үзүүлэлтийн зарим жишээ.....	37
Хүснэгт 9. БНСУ-ын өгөгдлийн бодлогын үр дүнг, үзүүлэлтийн зарим жишээ.....	39
Хүснэгт 10. Сингапурын өгөгдлийн бодлогын үр дүнг, үзүүлэлтийн зарим жишээ.....	41
Хүснэгт 11. Олон улсын өгөгдлийн хууль, эрх зүй, бодлого зохицуулалтын харьцуулсан судалгаа.....	43

## I. УДИРТГАЛ

Дэлхий нийт жинхэнэ утгаараа дижитал нийгэм болох чиглэл рүү улам бүр ойртсоор байна. Дэлхийн хэмжээнд нийт өгөгдлийн хэмжээ 2020 онд 64 зеттабайт байсан бол 2024 онд 149 зеттабайтад хүрсэн бөгөөд 2028 онд дэлхий даяар үүсгэгдэж, хадгалагдаж буй өгөгдлийн хэмжээ 394 зеттабайтад хүрэх төлөвтэй байна. Мөн нийт өгөгдлийн бараг тал хувь нь нийтийн үүлэн системд хадгалагдаж, хиймэл оюун, юмсын интернэт, үүлэн тооцоолол болон дижитал үйлчилгээний хэрэглээ огцом өсөж байгаа нь энэхүү өсөлтийн гол хүчин зүйл болж байна.

Аливаа улс орны хувьд төрийн гол үүрэг нь хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, боловсролын чанарыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах баталгааг хангах, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг сайжруулах байдаг. Эдгээр үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нөхцөл байдлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, үр нөлөөг үнэлэх бөгөөд үүнд нөлөөлөх гол хүчин зүйл нь өгөгдөл юм. Дэлхийн улс орнууд хөгжлийн бодлогын баримт бичигтээ өгөгдлийн тогтолцоо, засаглалыг хөгжүүлэх зорилтуудыг цогцоор нь тавьж, ирээдүйд өрсөлдөх чадвар, төрийн шийдвэр гаргалт, үйлчилгээг сайжруулахыг зорьж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн 5.3 дугаар зорилтод “Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинэ” гэж, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно” гэж, 7.5 дугаар зорилтод “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно” гэж, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлнэ” гэж тус тус заасан. Энэхүү бодлогын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны явцад бүрдүүлэн ашиглаж байгаа өгөгдөл, мэдээллийг нэгтгэн, нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээний үр дүнд их өгөгдөл бий болгоход шаардлагатай арга, хэрэгслийг тодорхойлох зорилгоор “Их өгөгдлийн сан” үүсгэх тухай шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоолоор баталж, хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг дээрх өгөгдлийн санд нийлүүлж байхыг төрийн байгууллагуудад зөвлөсөн байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2021 онд Цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг баталсан нь өгөгдөлтэй холбоотой харилцааг зохицуулах суурь орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон бөгөөд эдгээр хуулиар өгөгдлийг цуглуулах, боловсруулах, дамжуулах, ашиглах, түүнчлэн мэдээллийн аюулгүй байдал, цахим үйлчилгээний үндсэн зарчим, шаардлагыг тодорхой хэмжээнд тусгасан боловч практик хэрэгжилтийн түвшинд, төрийн байгууллагуудын хооронд өгөгдөл солилцох, нэгтгэх, ашиглах, хадгалах үйл ажиллагаанд нэгдсэн бодлого, стандарт, зохицуулалт дутагдалтай, технологийн болон институцийн уялдаа хангалтгүй хэвээр байна. Өгөгдлийн засаглалыг үндэсний хэмжээнд цогц байдлаар

зохицуулах буюу өгөгдөл солилцох, цуглуулах, ашиглах, дахин ашиглах бүх үе шатыг хамарсан эрх зүйн нэгдсэн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Өнөөгийн эрх зүйн орчинд өгөгдөлтэй холбоотой харилцааг хэсэгчлэн зохицуулсан хэд хэдэн хууль үйлчилж байгаа боловч эдгээр нь өгөгдлийн амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамарсан, нэгдсэн бодлого, зохицуулалтыг бүрдүүлж чадахгүй байна.

Цахим шилжилт хурдацтай хөгжиж, хиймэл оюуны хэрэглээ улам бүр нэмэгдэж байгаа манай улсад салбар бүрд үүсэж, хадгалагдаж байгаа өгөгдлийг боловсруулж, төр, бизнесийн байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад ашиглах нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улс эдийн засгийн өсөлтийг хангах, үндэсний өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд дижитал дэд бүтцийг хөгжүүлэх, өгөгдлийг хэрэглээнд нэвтрүүлэх, төр хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох замаар өгөгдөлд суурилсан инновацыг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Энэхүү зорилгод хүрэхийн тулд итгэлцлийг бий болгох, хил дамнасан өгөгдлийн урсгалыг бий болгох, хөрөнгө оруулалт татахуйц өгөгдлийн зохицуулалт, бодлогын тогтолцоо шаардлагатай юм.

### **Судлагдсан байдал**

Одоогийн байдлаар Монгол Улсад өгөгдлийн бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах, өгөгдлийн замын зураглал гаргах, үндэсний өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх хүрээнд тодорхой хэмжээний судалгаа, шинжилгээ хийгдээд байна. Тухайлбал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа 2025”, “Үндэсний өгөгдлийн стратеги боловсруулах бодлогын судалгаа, 2025”, “Нээлттэй өгөгдөл, түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах нь бодлогын судалгаа, зөвлөмж, 2023”, Үндэсний статистикийн хороо болон Азийн хөгжлийн банк хамтран “Үндэсний өгөгдлийн засаглалын замын зураглал, 2024”, “Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн байдлын үнэлгээний тайлан, 2024” зэрэг бодлогын чанартай судалгааг хийсэн байна.

Дээрх судалгааны ажлууд нь Монгол Улсад өгөгдөлтэй холбоотой бодлого, эрх зүй, нийгмийн харилцааны асуудлыг авч үзсэн боловч их өгөгдлийг цогцоор нь эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлага, боломж, хамрах хүрээг нэгдсэн байдлаар үнэлсэн судалгаа хязгаарлагдмал хэвээр байна.

Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас өгөгдлийн бодлого, зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн 75 байгууллагаас судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн дүгнэвэл:

1. Өгөгдөл солилцох, хуваалцах, ашиглах, дахин ашиглах харилцааны хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг;
2. Өгөгдлийн давтамж, ангилал, код зөрүүтэй;

3. Төрийн байгууллагууд ижил төрлийн мэдээллийг давхардуулан цуглуулах, өгөгдлийг шинэчлэх давтамж зөрүүтэй;
4. Өгөгдлийн чанар ба стандартын асуудал хангалтгүй;
5. Өгөгдлийн талаарх нэгдсэн нэр томьёо байхгүй;
6. Өгөгдлийн засаглал ба хариуцлагын асуудал тодорхойгүй буюу өгөгдлийг амьдралын бүрэн мөчлөгөөр (үүсэх, цуглуулах, дамжуулах, хадгалах, ашиглах, архивлах, устгах) удирддаггүй;
7. Хиймэл оюуныг сургах өгөгдөл бүрдээгүй;
8. Судалгааны зорилгоор өгөгдөл ашиглах зөвшөөрлийн процесс тодорхойгүй, олон улсын хамтарсан судалгаа хийхэд хүндрэлтэй;
9. Өгөгдөл солилцооны дэд бүтэц (техник, технологи, программ хангамж), стандарт, мета өгөгдлийн нэгдсэн орчин бүрдээгүй;
10. Хандалт, ашиглалтын харилцааны эрх зүйн орчин бүрдээгүй, төрийн мэдээллийн санд байгаа өгөгдлийн аюулгүй байдал хангагдсан талаар иргэд, байгууллагуудын итгэл сул;
11. Кибер халдлага болон бусад аюулд өртөх эрсдлийн удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн тогтолцоо дутмаг;
12. Өгөгдөл боловсруулах техникийн чадавх, мэргэшсэн боловсон хүчний дутагдалтай зэрэг болно.

### **Судалгааны зорилго, зорилт**

Энэхүү тандан судалгааны зорилго нь өгөгдлийг цуглуулах, солилцох, ашиглах, дахин ашиглах, өгөгдлийн дэд бүтэц түүний чанар, аюулгүй байдлыг хангах, хамгаалах эрх зүйн орчны хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оршино. Тус зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- Өгөгдлийн хууль, зохицуулалт хэрэгжиж буй 3-4 (Европын холбоо, БНЭсУ, БНСУ, Сингапур) улсын жишээг (эрх зүйн соёл, түүх, газар зүйн байршил; эрх зүйн эх сурвалжийн ангиллыг үндэслэн харьцуулалт хийх улсыг) сонгон судалж, зохицуулалтын хамрах хүрээ, сүүлийн үеийн чиг хандлага, үндэсний эрх зүйн тогтолцоо, анхаарах чиглэл, зохицуулалтын түвшинг Монголын нөхцөлд холбогдуулан шинжлэх, дагалдах дүрэм, журмын талаар судалгаа хийнэ;
- Судалсан хууль тогтоомж, судалгаанд үндэслэн тулгамдаж буй асуудлыг тодорхойлон зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
- Өгөгдлийг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс санал авах;
- Судалсан хууль, тогтоомж, судалгаа, зөвлөлдөх уулзалтаас гарсан санал зөвлөмжид тулгуурлан өгөгдлийн засаглалыг бий болгохтой холбоотой Монгол Улсад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох.

### **Судалгааны аргачлал, арга зүй**

Тус судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу дараах 7 үе шаттай хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. асуудалд дүн шинжилгээ хийх;
2. асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүйн хувьд баримт бичгийн шинжилгээний аргыг өгөгдөл болон салбарын эрх зүйн сорилтыг тодруулах, өгөгдлийн амьдралын мөчлөг буюу өгөгдлийг цуглуулах, боловсруулах, солилцох, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой онол болон зарчмын асуудлыг тодорхойлох зорилгоор гадаадын болон үндэсний хэмжээнд хийгдсэн хууль зүйн ном, эрдэм шинжилгээний бүтээлийг судлахад ашиглав.

Түүнчлэн харьцуулсан судалгааны аргыг Европын Холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Сингапур Улсын өгөгдлийн тогтолцоог зохицуулж буй хууль тогтоомжийг судлах, салбар эрх зүйн онол, зарчим өгөгдлийг хэрхэн зохицуулж буй талаар эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудыг судлахад тус тус ашигласан.

### **Судалгааны ажлын бүтэц**

Судалгааны ажил нь нийт 7 бүлэг, ном зүй, хавсралт хэсгээс бүрдэнэ.

### **Судалгааны ажлын хүлээгдэж буй үр дүн**

Өнөөгийн эрх зүйн орчинд өгөгдөлтэй холбоотой харилцааг хэсэгчлэн зохицуулсан хэд хэдэн хууль үйлчилж байгаа боловч эдгээр нь өгөгдлийн амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамарсан, нэгдсэн бодлого, зохицуулалтыг бүрдүүлж чадаагүй байна. Үүний улмаас өгөгдөлтэй холбоотой зохицуулалт нь салангид, давхардсан, уялдаа холбоо хангалтгүй, өгөгдлийн өмчлөл, хариуцлагын асуудал тодорхой бус, байгууллагуудын хооронд өгөгдөл солилцох эрх зүйн зохицуулалт тодорхой бус, өгөгдлийн ашиглалт, хамгаалалтын нэгдсэн стандартгүй байна. Иймд өгөгдлийг цуглуулах, солилцох, ашиглах, дахин ашиглах, өгөгдлийн дэд бүтэц түүний чанар, аюулгүй байдлыг хангах, хамгаалах эрх зүйн орчны хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг өгөгдлийн бодлого, зохицуулалтын орчныг хөгжүүлэхтэй холбоотой гаргасан бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомжид өгөгдлийн талаар тусгасан зохицуулалтууд, цахим шилжилтийн өнөөгийн байдал, төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудаас ирүүлсэн санал, өгөгдлийн орчинд өмнө хийсэн судалгааны ажлууд, олон улсын туршлагад тулгуурлан гаргаж ирэх юм.

## II. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

### 2.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Өнөө үед дата/өгөгдөл нь чухал хөрөнгө, үнэт баялгийн нэг болон хувирч байгаа тул түүнийг хэрхэн удирдаж, яаж зохицуулах вэ гэдэг асуудал улс үндэстэн бүрийн өмнө тулгарч байна. Дэлхий нийтээр их хэмжээний өгөгдлийн урсгалыг хариуцлагатайгаар удирдах хэрэгцээ, түүнчлэн өгөгдлөөс үүсэх боломжууд болон тулгарах эрсдэлийг тэнцвэртэйгээр хангаж байх, өгөгдлийн засаглалын тогтолцоог бий болгох уриалга улам бүр нэмэгдсээр байна (Marcucci, S., Alarcón, N.G., et al. 2023:7). Дэлхийн банкны (World Bank 2021, 297) үзэж байгаагаар өгөгдлийн засаглалын нийтлэг үзэл баримтлалтай болох нь “бизнесийн хувьд ч, нийтийн сайн сайхны төлөө аль алинд нь өгөгдлөө хоорондоо солилцох суурь дүрэмтэй болгох” ач холбогдолтой юм. Мөн “Дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөхүйц тохиролцоонд хүрсэн тохиолдолд өгөгдлийг хаана цуглуулж, хаана ашиглаж байгаагаас үл хамааран ямар ч хувь хүн, аж ахуйн нэгжүүд тэдгээрийг ашиглах итгэл үнэмшилтэй болно. Учир нь тэдэнд хамаатай ямар ч өгөгдөл, яг адилхан хамгаалалттай, яг адилхан үүрэгтэй гэсэн итгэл үнэмшил бий болно” гэжээ.

“Өгөгдлийн засаглал” гэсэн нэр томъёо нь сүүлийн арван жилийн хугацаанд судалгаа болон бодлогын үгсийн санд өргөнөөр нэвтэрч орж ирсэн ба “Датасфер санаачилга” сангийн тоолсноор өнөөдрийн байдлаар өгөгдлийн засаглалын чиглэлд ажилладаг нийт 261 төрлийн байгууллага байна (Datasphere Initiative, 2022). Энэхүү нэр томъёог академик өгүүлэл, судалгаанд ашиглах явдал зөвхөн 2015-2021 оны хооронд гэхэд бараг тав дахин өссөн ба цаашид улам өсөх хандлагатай байна. Ийнхүү өгөгдлийн засаглал нь нэгэнт энэ цаг үе болоод ирээдүйн хэрэгцээ болоод байна.


Өгөгдлийн засаглалын тухай ойлголтыг олон улсын байгууллагууд хэрхэн тодорхойлж байгааг авч үзвэл, юуны өмнө Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан комисс (ESCAP) - “Өгөгдлийн засаглал гэдэг нь өгөгдөл хэмээх баялгийн/хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, өгөгдөлтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор өгөгдлийг удирдах, түүнийг өөрчлөх эрх мэдлийг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа” гэж тодорхойлсон (National Data Forum, 24th May 2024, Data Governance across Asia and the Pacific). Писа (Pisa et al. 2020, in Datasphere Initiative, p.7) хэлснээр, өгөгдлийн засаглалын үзэл баримтлал нь “иргэд өгөгдлийг зүй бусаар ашиглахаас хамгаалахын зэрэгцээ инновац, хөгжил болон хүртээмжтэй өсөлтийг дэмжих байдлаар өгөгдлийг хэрхэн цуглуулах, шинжлэх, ашиглах, хуваалцахтай холбоотой дүрэм журмыг боловсруулах”-д оршдог гэж тодорхойлжээ.

Эндээс дүгнэхэд, өгөгдлийн засаглал гэдэг нь нэгдүгээрт, өгөгдлийг үнэт баялаг, хөрөнгө гэж үзэж, хоёрдугаарт, өгөгдлийг удирдах бодлого, дүрэм журам, үүрэг хариуцлагыг нарийвчлан тогтооход гол анхаарлаа төвлөрүүлэхийг хэлдэг байна. Үүний тулд өгөгдлийн засаглал нь өгөгдөл бодитой, алдаа мадаггүй, хүртээмжтэй, аюулгүй, үр дүнтэй ашиглахад чиглэсэн зохицуулалтын нөхцөл бүрдүүлэхийг зорьдог. Цар хүрээний хувьд өгөгдлийн засаглал нь өгөгдлийг удирдах үйл ажиллагаанд чиглэсэн үзэл баримтлалыг, удирдамжийг буй болгодог байна (Үндэсний статистик сэтгүүл, 2024).

UNDESA-гийн өгөгдлийн засаглалын үзэл баримтлалын зураглалыг дараах Зураг 1-д харуулж байна. Энэхүү үзэл баримтлал нь гурван зарчимд суурилсан (3 Principle- based),

дөрвөн тулгуурт (4 pillars-supported), зургаан төрлийн элементийг хангасан (6 across different elements) байх зорилгыг агуулж байна.

Зураг 1. НҮБ-ын эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газрын өгөгдлийн засаглалын үзэл баримтлал



Эх сурвалж: Wai Min Kwok, 2023, Mongolia National Workshop: UN DESA National Data Governance Framework for Sustainable Development, Ulaanbaatar

Дээрх зургаас харахад дөрвөн тулгуур нь:

1. Бодлого - Өгөгдлийн засаглалыг хууль ёсны болгох арга хэрэгсэл (хууль ёс, зохицуулалт) “Өгөгдлийг зөвхөн нэг удаа” эсвэл “зөвхөн нэг удаа” гэсэн зарчмыг хэрэгжүүлэх. Ингэснээр хувь хүн, бизнес эрхлэгчид нь төрийн байгууллагуудад өгөгдлөө зөвхөн нэг удаа өгөх боломжийг баталгаажуулж, төрийн байгууллагууд хүсэлт хүлээн авсан тохиолдолд л холбогдох дүрэм журмын дагуу өгөгдлийг солилцдог болох;

2. Институци - Өгөгдлийн засаглалыг эрх мэдэлжүүлэх болон байгууллагын тогтолцоонд суулгах арга хэрэгсэл (манлайлал; байгууллагын). Үүнд өгөгдлийн манлайлалд өгөгдөл эрхлэгч нар чухал үүрэгтэй;

3. Процесс - Өгөгдлийн засаглалыг идэвхжүүлэх болон үйл ажиллагаанд оруулах арга хэрэгсэл (шахах/татах хүчин зүйлс). Өгөгдлийн тус тусдаа салангид байгаа байдлаас өгөгдлийн платформ, өгөгдлийн экосистем рүү шилжихэд чиглүүлэх;

4. Хүний нөөц – Өгөгдлийн засаглалыг чадавхжуулах болон дэмжих арга хэрэгсэл (чадавх, чадамж) багтаж байна. Өгөгдөл хариуцах бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч албан тушаалтнууд, бодлогын шинжээч, өгөгдөл судлаач, эрдэмтэд, төрийн албан хаагчид болон өгөгдөл эрхлэгч нарт шаардагдах ажил үүрэг, ур чадварыг тодорхойлох.

Өгөгдлийн засаглалын дөрвөн тулгуурт суурилсан үндсэн зургаан өгөгдлийн элементэд дараах хэсгүүд багтаж байна. Үүнд:

1. Өгөгдлийн стандарт, ангилал
2. Өгөгдөл хуваалцах, солилцох, харилцан холболт
3. Өгөгдлийн аюулгүй байдал (хамгаалах)
4. Өгөгдлийн нууцлал (ёс зүй)
5. Өгөгдлийн дэд бүтэц
6. Цахим түлхүүр үзүүлэлт зэрэг хэсгүүд багтаж байна.

Улсын хэмжээнд эдгээр шаардлагуудыг хангаж чадахуйц өгөгдлийн засаглалын үзэл баримтлал буй болгох нь цахим шилжилтийг үр өгөөжтэй хэрэгжүүлэх үндэс нь болно (Үндэсний статистик сэтгүүл, 2024).

“Үндэсний өгөгдлийн стратеги боловсруулах бодлогын судалгаа”-нд өгөгдөлтэй холбоотой нэр томъёог дараах байдлаар тайлбарласан байна.

### Хүснэгт 1. Нэр томъёо

Ойлголт	Тодорхойлолт
Өгөгдөл (Data)	Юм эсхүл үзэгдлээс үүсдэг, хүн мэдрэхүйн эрхтнээрээ эсхүл техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэдрэх, бүртгэх, ангилах, боловсруулах замаар тодорхой утга, ойлголт руу хөрвүүлэх боломжтой дохио, текст, тэмдэгтүүд
Өгөгдлийн багц (Dataset)	Тодорхой зохион байгуулалттай байдлаар цуглуулсан, ихэвчлэн мөр, баганад эсвэл дүн шинжилгээ хийх тусгай ажиглалт болгон тохируулдаг өгөгдлийн цуглуулга
Өгөгдлийн сан (Database)	Өгөгдлийг үр дүнтэй хадгалах, удирдах, сэргээх боломжтой цахим хэлбэрээр хадгалагдсан зохион байгуулалттай өгөгдлийн цуглуулга
Нээлттэй өгөгдөл (Open data)	Хууль эрх зүйн болон техникийн хязгаарлалтгүй, нийтэд нээлттэй платформд нийтлэгдсэн, хэн ч хандах, ашиглах, дахин ашиглах, түгээх, хуваалцах боломжтой өгөгдөл
Эмзэг өгөгдөл (Sensitive data)	Хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, санхүү, худалдаа, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцаа зэрэг үндэслэлгүй задлахаас хамгаалагдсан өгөгдөл
Их өгөгдөл (Big data)	Өнгөрсөн хугацааны үйл явдлуудаас үүсэн бий болсон, боловсруулахад тусгай техник хэрэгсэл шаарддаг, юмс үзэгдлийн боломжит зүй тогтлыг танин мэдэхэд ашиглагддаг өгөгдлийн сан.

Ораклын тодорхойлсноор Их өгөгдөл (Big Data) гэдэг нь уламжлалт өгөгдөл боловсруулах хэрэгслүүд, ялангуяа хүснэгтэн программ (spreadsheet)-аар хялбар удирдах, боловсруулах, шинжлэх боломжгүй маш их хэмжээний, нарийн төвөгтэй өгөгдлийн цогцыг хэлнэ (Oracle, 2024).

### Өгөгдлийн судалгаа ба хэрэглээний хөгжлийн үе шат

Өгөгдөл гэх ойлголт харьцангуй шинэ хэдий ч их хэмжээний өгөгдлийн тухай ойлголт 1960-1970 оны үеэс эхтэй юм. Тухайн үед анхны өгөгдлийн төвүүд, өгөгдлийн бааз

хөгжүүлэлт эхэлж байсан түүхтэй. Харин “Их өгөгдөл” гэх нэршлийн хувьд 1990-ээд оны эхээр хэрэглэгдэж эхэлсэн байна. Анх 1989-1990 оны хооронд Тим Бернерс-Ли (Tim Berners-Lee), Роберт Кайо (Robert Cailliau) нар World Wide Web платформыг бүтээж, улмаар HTML, URL, HTTP-г хөгжүүлсэн бөгөөд интернэтийн эрин үетэй зэрэгцэн 1996 оноос өгөгдлийг цаасаар бус электрон хэлбэрээр хадгалах нь илүү зардал багатай болж, тэрхүү мэдээлэл рүү хандахад ч хялбар болсон байна.

Улмаар 1998 оноос [www.google.com](http://www.google.com) домайн үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд тус онд Карл Стрози “NoSQL” өгөгдлийн сангийн хэлийг хөгжүүлсэн түүхтэй. Улмаар 1999 онд Хэл Р.Вэриан (Hal R. Varian), Питер Лайман (Peter Lyman) нар “How much information” номынхоо анхны хувилбарыг бичиж, тус номдоо дэлхий дээрх нийт дижитал мэдээллийн хэмжээг тодорхойлохыг оролдож байв.

Түүний дараагаар 2000 оноос хойш интернэт болон вебийн тусламжтайгаар өмнө нь байгаагүй их хэмжээний мэдээллийг цуглуулах, шинжлэх боломж нээгджээ. Тухайлбал, вебийн ачаалал, онлайн дэлгүүрийн тоо нэмэгдсэний дээр Yahoo, Amazon, eBay зэрэг томоохон компаниуд үйл ажиллагаа эхэлж, цаашлаад хэрэглэгчдийнхээ зан төлөвийг даралтын хувьд, байршил, хайлтын түүх зэргээс нь шинжиж мэдэхээр ажилласан. Энэ нь цаашлаад өгөгдлийн шинэ ертөнцийг бидэнд нээн өгч байна.

Их өгөгдлийн өсөлт хөгжил нь “Hadoop” зэрэг нээлттэй эхийн технологийн хөгжилтэй салшгүй холбоотой юм. Facebook, YouTube болон бусад онлайн платформ өөрсдийн хэрэглэгчдийн талаар маш их хэмжээний өгөгдөл үйлдвэрлэж байгаа нь олны анхаарлыг татах болов. Улмаар 2005 онд “Hadoop” технологийн хөгжүүлэлт дуусаж, олон нийтэд танилцуулагдаж, “NoSQL” хэл нэрд гарч эхлэв. Эдгээр технологийн тусламжтайгаар өгөгдлийг хямд зардлаар хадгалах боломжтой болсон. Улмаар сүүлийн хэдэн жилд их өгөгдлийн хэмжээ асар хурдтай нэмэгдсэн бөгөөд хэрэглэгчид одоо ч их хэмжээний өгөгдлийг тасралтгүй үйлдвэрлэж байна.

Компьютерын хүчин чадал хурдтай нэмэгдэж буй энэ үед “их өгөгдөл” гэх ойлголтыг тоон утгаар илэрхийлж, хязгаар тогтоох боломжгүй юм. Анх 1965 онд Гордон Мүүр (Gordon Moore) нэг чипт багтаах транзиторын тоо буюу компьютерын хүчин чадал 2 жил тутамд 2 дахин нэмэгдэх таамаглал дэвшүүлсэн нь биеллээ олж хожмоо Мүүрийн хууль хэмээн алдаршсан байдаг. Сүүлийн 60 орчим жилийн тооцоогоор компьютерын хүчин чадал 18 сар тутамд 2 дахин нэмэгджээ. Гэсэн хэдий ч Гордон Мүүрийн үзэж буйгаар нэг чипт багтаах транзиторын тоог хязгааргүй ихэсгэх боломжгүй бөгөөд компьютерын хүчин чадлын өсөлтийн хурд цаашид саарч болзошгүй байна.

Өдгөө өгөгдөл хөрөнгийн нэг хэлбэр болж хувирч байна. Дэлхийн томоохон технологийн компаниудын хувьд тэдний бүрдүүлсэн өгөгдөл нь байгууллагын үнэ цэнийг тодорхойлох томоохон хүчин зүйл болохын зэрэгцээ шинэ бүтээгдэхүүн боловсруулах гол орц болж байна. Өгөгдлийн хэмжээ нэмэгдэж, хадгалах зардал буурахын хэрээр оновчтой бизнесийн эсвэл бодлогын шийдвэрт ашиглаж байна. Их өгөгдлийн үнэ цэн нь танд хэр их өгөгдөл байгаагаас бус байгаа өгөгдлийг хэрхэн ашиглаж байгаагаас хамаарна. Өгөгдлийг цэгцлэх, шинжилгээнд тохируулж бэлдэх нь ихээхэн цаг шаардах бөгөөд өгөгдлийг шинжилдэг хүмүүс нийт ажлын цагийнхаа 50-аас 80 хувийг зөвхөн өгөгдлийг цэгцэлж бэлдэхэд зарцуулдаг гэх тооцоо бий. Олон улсын өгөгдлийн корпорацаас (IDC) гаргасан тооцоогоор дэлхий нийтээр бизнесийн зорилгоор цуглуулсан бүтэцгүй өгөгдлийн 90 хувьд огт шинжилгээ хийж чадахгүй байна. Шинэ технологи гарч ирснээр өгөгдлийг хадгалах

Боломж нэмэгдэж байгаа ч өгөгдлийн хэмжээ хоёр жил тутамд хоёр дахин нэмэгдэж байгаа гэдгийг санах нь зүйтэй юм. Тиймээс байгууллагууд тэр их мэдээллийг зохицуулах үр дүнтэй арга хайсан хэвээр л байна.

*Хүснэгт 2. Олон улсын эрх зүйн баримт бичиг дахь өгөгдлийн тодорхойлолт*

Баримт бичгийн нэр	Зүйл заалт	Тодорхойлолт
Европын холбооны <a href="#">EU Data Act (Өгөгдлийн тухай хууль)</a>	<b>2 дугаар зүйл</b>	<p><b>Өгөгдөл (data):</b> Үйлдэл, баримт, мэдээллийн аливаа дижитал илэрхийлэл, мөн тэдгээрийн эмхэтгэл, үүнд дуу, дүрс болон дуу-дүрсний бичлэгийн хэлбэрийг багтаасан мэдээллийг хэлнэ;</p> <p><b>Хувийн өгөгдөл (personal data):</b> Хувь хүнийг шууд эсвэл шууд бусаар таних боломжтой мэдээллийг;</p> <p><b>Хувийн бус өгөгдөл (non personal data):</b> Хувийн мэдээллээс бусад бүх мэдээлэл;</p> <p><b>Хэрэглэгч (user):</b> “Хэрэглэгч” гэж холбогдсон бүтээгдэхүүнийг өмчилж байгаа, эсхүл тухайн бүтээгдэхүүнийг ашиглах түр эрхийг гэрээгээр шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээд, мөн холбогдох үйлчилгээ авч байгаа этгээдийг хэлнэ.</p> <p><b>Өгөгдөл эзэмшигч (Data holder):</b> Хууль тогтоомжийн дагуу өгөгдлийг ашиглах болон бусдад нээлттэй болгох эрх буюу үүрэгтэй хувь хүн эсвэл хуулийн этгээдийг хэлнэ. Үүнд гэрээгээр тохирсон тохиолдолд бүтээгдэхүүний өгөгдөл болон холбогдох үйлчилгээ үзүүлэх явцад цуглуулсан эсвэл үүсгэсэн үйлчилгээний өгөгдөл багтана.</p> <p><b>Өгөгдөл хүлээн авагч (data recipient):</b> “Өгөгдөл хүлээн авагч” гэж өөрийн худалдаа, бизнес, мэргэжлийн үйл ажиллагааны зорилгоор үйл ажиллагаа явуулдаг бөгөөд</p>

		<p>холбогдсон бүтээгдэхүүн эсвэл холбогдох үйлчилгээний хэрэглэгчээс бусад, өгөгдөл эзэмшигчээс өгөгдөл хүлээн авч буй хувь хүн эсвэл хуулийн этгээдийг хэлнэ</p> <p><b>Холбогдсон бүтээгдэхүүн (connected product):</b> “Холбогдсон бүтээгдэхүүн” гэж өөрийн ашиглалт эсвэл орчны талаарх өгөгдлийг олж авах, үүсгэх эсвэл цуглуулах чадвартай бөгөөд тухайн өгөгдлийг цахим харилцаа холбооны үйлчилгээ, физик холболт эсвэл төхөөрөмж дээрх хандалтаар дамжуулан дамжуулах боломжтой, мөн үндсэн зориулалт нь хэрэглэгчээс бусад этгээдийн өмнөөс өгөгдөл хадгалах, боловсруулах, дамжуулах биш бүтээгдэхүүнийг хэлнэ.</p> <p><b>Боловсруулалт (Processing):</b> “Боловсруулалт” гэж хувийн өгөгдөлд эсхүл хувийн өгөгдлийн багцад автоматжуулсан эсэхээс үл хамааран хийгдэж буй аливаа ажиллагаа буюу ажиллагааны нийлбэрийг хэлэх бөгөөд үүнд цуглуулах, бүртгэх, зохион байгуулах, бүтэцжүүлэх, хадгалах, өөрчлөх, сэргээх, ашиглах, дамжуулах, түгээх, нээлттэй болгох, нэгтгэх, хязгаарлах, устгах зэрэг ажиллагаа багтана.</p> <p><b>Харилцан ажиллах чадвар (Interoperability):</b> “Харилцан ажиллах чадвар” гэж хоёр буюу түүнээс дээш өгөгдлийн орчин, холбооны сүлжээ, систем, холбогдсон бүтээгдэхүүн, хэрэглээний програм, өгөгдөл боловсруулах үйлчилгээ эсвэл бүрэлдэхүүн хэсгүүд нь өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор</p>
--	--	--

		өгөгдөл солилцох болон ашиглах чадварыг хэлнэ.
(Бүгд Найрамдах Солонгос Улс) Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль (Personal Information Protection Act - PIPA)	<b>2 дугаар зүйлийн 1 дэх заалт</b>	"Өгөгдөл" буюу "Хувь хүний мэдээлэл (personal information)" гэдэг нь дараах байдлаар тодорхойлогддог. "Хувь хүний мэдээлэл" гэдэг нь хувь хүнд хамаарах мэдээлэл бөгөөд дараах аль нэгийг хангасан мэдээллийг хэлнэ 1.Нэр, оршин суугчийн бүртгэлийн дугаар (RRN), зураг (видео) гэх мэтээр тухайн хүнийг шууд тодорхойлох боломжтой мэдээлэл. 2.Өөрөө дангаараа тодорхойлохгүй ч бусад мэдээлэлтэй хялбархан хослуулбал (нэгтгэх, холбох) тухайн хүнийг тодорхойлох боломжтой мэдээлэл. (Хослуулахад шаардагдах цаг, зардал, технологи, бусад мэдээлэл авах боломж зэргийг харгалзан үздэг.) Дээрх 1 эсвэл 2-р заалтад хамаарах мэдээллийг нэрийг нууцалсан (pseudonymised) байдалд оруулснаар нэмэлт мэдээлэлгүйгээр тухайн хүнийг тодорхойлох боломжгүй болсон мэдээлэл (pseudonymised information).
Сингапурын Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль (Personal Data Protection Act - PDPA)	<b>(Хуулийн 2-р зүйлийн 1-р заалт):</b>	"Өгөгдөл" буюу "Хувь хүний мэдээлэл (personal data)" гэдгийг дараах байдлаар тодорхойлдог "Хувь хүний мэдээлэл" гэдэг нь үндэн эсвэл худал байж болох, тухайн хувь хүний тухай мэдээлэл бөгөөд дараах аль нэгийг хангасан мэдээллийг хэлнэ: <ul style="list-style-type: none"> <li>Тухайн мэдээллээс тухайн хүнийг тодорхойлох боломжтой; эсвэл</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн мэдээлэл + байгууллагад байгаа эсвэл байх магадлалтай бусад мэдээлэлтэй хослуулбал тухайн хүнийг тодорхойлох боломжтой.</li> </ul>
--	--	--

## 2.2 Эрх ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

	Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг	Нөлөөлж байгаа хэлбэр
1.	Иргэн	Өгөгдлийн хууль, эрх зүйн орчныг бий болгож, сонирхогч этгээдүүдэд нээлттэй өгөгдөл ашиглуулахдаа хувь хүний талаарх мэдээллийг нэргүй болгох буюу тухайн хүнийг тодорхойлох боломжгүй байдлаар, эрх, ашиг сонирхлыг нь хөндөхгүй хэлбэрээр иргэн хуулийн этгээдэд нээлттэй ашиглуулна. Өөрөөр хэлбэл сөргөөр нөлөөлөхгүй.
2.	Төрийн байгууллага	Бүрдүүлсэн мэдээллийн сангаасаа боловсруулалт хийж, стандартын дагуу өгөгдөл нийтэлж, шинэчлэх шаардлагыг хуулиар тавих нь төрийн байгууллагуудад ачаалал нэмэгдүүлж болох ч төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал болон шийдвэр гаргалт, удирдлагын төвшинд эерэгээр нөлөөлнө.
3.	Хувийн хэвшил	Өгөгдөлд шинжилгээ, дүгнэлт хийх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх, байгаль орчин, эдийн засгийн эрсдэлээс сэргийлэх, зардал хэмнэх, өгөгдөлд тулгуурласан үйлчилгээ шинээр бий болгох боломж бүрдэх эерэг нөлөөтэй.
4.	Монгол Улс	НҮБ-аас баталсан тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын суурь үзүүлэлтүүдийг хангасан байдлыг хэмжих, нэгдэн орсон Нээлттэй засгийн түншлэл (Open Government Partnership)-ээр олон улсад хүлээсэн үүргээ биелүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

## 2.3 Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан

Одоогийн байдлаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргээр өгөгдлийг тодорхой хэмжээнд зохицуулж байна. Тухайлбал, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар, улс, орон нутгийн төсвийн зарцуулалт, удирдлагын талаарх мэдээллийг Шилэн дансны тухай хуулиар, хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар, Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг Төрийн болон албаны нууцын тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Өмнөх хэсэгт дурдсан Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтцийг бий болгох, их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгохоор тусгасан. Энэхүү бодлогын хүрээнд Үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтанд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Их өгөгдлийн (big data) сан” үүсгэхийг Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоолоор баталж, мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн үйл ажиллагааны явцад бий болгосон мэдээллийг өөрийн хэрэгцээнд ашиглах, мэдээллийн сан үүсгэх, хязгаарлалттай мэдээллийг нээлттэй өгөгдөл болгон боловсруулж, бусдад ашиглуулах нөхцөлийг бүрдүүлсэн боловч мэдээллийн сангуудыг хувь хүн, хуулийн этгээдийн түвшинд ашиглахад шаардлагатай эрх зүйн болон нууцлал, аюулгүй байдлын нэгдсэн зохицуулалт бүрэн бий болоогүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага хооронд, төрийн байгууллага хувийн хэвшил хооронд, төрийн байгууллага иргэд хооронд, хувийн хэвشلүүд хоорондоо мэдээлэл солилцох, хуваалцах, улмаар хувь хүн, хуулийн этгээдийг таних боломжгүй болгон хөрвүүлэх талаар нэгдсэн төлөвлөлт, технологийн шийдэл бүрдээгүй байна. Мөн төрд байгаа их хэмжээний өгөгдөл, мэдээллийн санг боловсруулах хүний нөөц, үүнийг хариуцах байгууллага бэлэн бус байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.8 болон 27.9 дэх заалтуудад суурь болон төрөлжсөн мэдээллийн санг бүртгүүлэх тухай заасан. Үүний дагуу Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолоор “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”-ыг баталж, үүний дагуу Үндэсний Статистикийн Хороо болон ЦХИХХЯ хамтран “Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан”-г үүсгэж, 2024 оны 5 дугаар сард ашиглалтад оруулсан. Ингэснээр төрийн байгууллагуудын өгөгдөл, мэдээллийн сангийн үзүүлэлтүүдийг хайх, танилцах орчин бүрдсэн.

Монгол Улсад их өгөгдлийн сан цогц байдлаар байгуулагдаагүйгээс хувийн хэвшлийн компаниуд дата сангийн өгөгдлөө хууль бус аргаар цуцлуулах эрсдэл байна. Жишээлбэл, Сошиал медиа болон нээлттэй эх сурвалжаас иргэдийн зураг, дуу хоолойг "Public" тохиргоотой гэдэг үндэслэлээр зөвшөөрөлгүй татаж авах, эсвэл хувь хүмүүсээс баталгаагүй дата буюу албан бус худалдан авалт хийх гэх мэт зөрчлүүд байна. Иймд зөвхөн программын кодонд "Эмзэг мэдээллийг харуулж болохгүй" гэсэн хязгаарлалтын давхарга (англ. Restriction Layer) бичих нь хангалтгүй. Prompt Injection зэрэг халдлагын үед энэ хамгаалалт эвдэрч, хиймэл оюун нь өөрийн санах ойд буй эмзэг мэдээллээ (иргэний регистр, утас, гэрийн хаяг) шууд задруулах өндөр эрсдэлтэй юм.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл (Нийтийн мэдээллийн ангилал) болон 12 дугаар зүйлд (Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох) үндэслэн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай өгөгдөл гэж ангилсан. Мэдээлэл гэдэг аль хэдийнэ боловсруулсан өгөгдлийг ойлгох бөгөөд өгөгдлийг ангилаагүй, боловсруулахаас өмнөх хүний эрхийг хангаагүй байгаа нь эрсдэл дагуулж байна. Нээлттэй мэдээлэл гэдэг нь хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулсан (англ. anonymized) өгөгдлийг ойлгоно. Жишээ нь, нийтийн эрх ашигт нийцсэн статистик, орчны мэдээлэл, замын хөдөлгөөний ачаалал, цаг агаарын түүхэн өгөгдөл, төсвийн зарцуулалт, нэр хаяггүй эрүүл мэндийн

статистик гэх мэт мэдээллийг хиймэл оюуны гарааны бизнес эрхлэгчид, судлаачдад үнэ төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлж байна.

Хязгаарлалттай мэдээлэл гэдгийг хүний хувийн мэдээлэл, байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр эсвэл гэрээний үндсэн дээр ашиглахыг ойлгоно. Жишээ нь, бизнесийн өндөр үнэ цэнтэй, хязгаарлагдмал хүрээнд ашиглах боломжтой дата байж болох бөгөөд үүнд хөдөө аж ахуйн хөрсний нарийвчилсан дата, салбарын эрсдэлийн үнэлгээ хамаарна. Үүнийг төрөөс тусгай зөвшөөрөл авсан, "мэдээлэл боловсруулах гэрээ" байгуулсан компаниуд ашиглах боломжтой.

Хаалттай мэдээлэлд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 10-р зүйл (Төрийн нууц) болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн "Эмзэг мэдээлэл" хамаарна. Жишээ нь төрийн маш нууц болон хүний биометрийн мэдээлэл: Хурууны хээ, царайны төрх (Face ID), нүдний солонго, Эрүүл мэндийн мэдээлэл: Генетик, өвчний түүх, Хаалттай мэдээлэл: Төрийн нууцад хамаарах мэдээлэл (10.1.1). Тус мэдээлэл нь төрийн хамгаалалттай серверээс гарах ёсгүй, хувийн хэвшилд өгөх хориотой бөгөөд зөвхөн төрийн тусгай байгууллага ашиглана. Энэ төрлийн өгөгдөл дээр хиймэл оюун сургах шаардлагатай бол "Federated Learning" (Өгөгдлийг зөөхгүйгээр загварыг серверт аваачиж сургах) зарчмыг баримтлах нь оновчтой боловч аль хэдийн боловсруулсан өгөгдлийн тухайд энэ шаардлагыг хангах боломжгүй байна.

#### **2.4. Монгол Улсын цахим шилжилтийн өнөөгийн нөхцөл байдал**

2025 оны байдлаар Монгол Улсын 18-с дээш настай иргэдийн 87.2% нь төрийн цахим үйлчилгээний систем E-Mongolia-г ашиглаж үйлчилгээг цахимаар авч хэвшсэн байна.<sup>1</sup> Түүнчлэн төрийн үйлчилгээний 90 хувийг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар "Цахимаар нэн тэргүүнд (Digital First)" бодлогын зөвлөмж батлагдсан. Тус зөвлөмж нь хүн төвтэй үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр нэн тэргүүнд санал болгож, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, өгөгдөлд суурилсан бодлого, шийдвэр гаргалтыг төлөвшүүлэх, хувийн хэвшлийн цахим инновацыг дэмжих замаар улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд баримтлах зарчмыг<sup>2</sup> тусгасан.

2026 оны байдлаар дараах системээр иргэд төрийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон байна.

---

<sup>1</sup> Мэдээ: И-Монгол академи, 2025.03.31,

<https://www.facebook.com/emongolia.academy/posts/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-18-%D1%81-%D0%B4%D1%8D%D1%8D%D1%88-%D0%BD%D0%B0%D1%81%D1%82%D0%B0%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-872-%D0%BD%D1%8C-%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%86%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%81%D0%B8%D1%81%D1%82%D0%B5%D0%BC-e/634150246042093/>

<sup>2</sup> "Цахимаар нэн тэргүүнд (Digital first)" бодлогын зөвлөмж, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралт, 1.1 дүгээр зүйл.

Хүснэгт 3. Монгол Улсын төрийн үйлчилгээг цахимаар хүргэж буй томоохон систем

№	Систем	Тайлбар
1	e-Mongolia.mn	<p><i>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем v0.5</i></p> <p>Төрийн үйлчилгээг цахимжуулж буй E-Mongolia төслийг 2019 онд санаачлан хэрэгжүүлж, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр 23 байгууллагын 181 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн албан ёсоор иргэдэд үйлчилж эхэлсэн. Уг төслийг амжилттай болгох суурь анх 2013 онд тавигдсан бөгөөд төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаас иргэд 10 төрлийн үйлчилгээ авах боломжтой байсан. И-Монгол систем нь Монгол Улсын төрийн бүх цахим үйлчилгээг нэг цонхоор үзүүлэх зорилготой нэгдсэн платформ юм. ХУР&amp;ДАН системийн тусламжтайгаар хувь хүн болон хуулийн этгээд e-Mongolia вэб болон аппликейшнаар дамжуулан өдгөө 1200 гаруй төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой. 2025 онд 5.0 хувилбарт шилжсэн байна.</p>
2	<p>developer.xyp.gov.mn</p> <p><a href="https://sso.gov.mn/">https://sso.gov.mn/</a></p>	<p><i>ХУР&amp;ДАН систем</i></p> <p>“ХУР” систем нь анх 2017 онд төрийн мэдээлэл солилцооны систем хэмээн олон нийтэд танилцуулагдаж, төрийн үйлчилгээг цахимаар авах суурь нөхцөлийг бүрдүүлсэн билээ. Өөрөөр хэлбэл, иргэд төрийн үйлчилгээг ТҮЦ машин эсвэл E-Mongolia системээр дамжуулан цахимаар авдаг бөгөөд тэдгээр системийн ард нь “ХУР” гэх систем ажиллаж байдаг. Үйлчилгээнүүд цахимжихийн хэрээр цахим орчинд иргэнийг таньж баталгаажуулах шаардлага тулгардаг. Үүнийг танилт нэвтрэлтийн “ДАН” системийн тусламжтайгаар шийдэж байгаа бөгөөд “ДАН” системийг 2018 онд иргэдийн хэрэглээнд нэвтрүүлсэн. ХУР систем нь Монгол Улсын төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг аюулгүй, найдвартай, хурдан шуурхай холбож, цахим хэлбэрээр мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн үндсэн дэд бүтэц юм. ДАН систем нь төр болон хувийн байгууллагуудын цахим үйлчилгээ авахад хэрэглэгчийг баталгаажуулах, нэвтрүүлэх зориулалттай дэд бүтэц бөгөөд олон системд давхардсан бүртгэл үүсгэхгүйгээр нэг бүртгэлээр нэвтрэх боломжоор хангадаг.</p>
3	d.parliament.mn	<p><i>Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах систем</i></p> <p>Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох, хуулийн төсөлд санал авах, иргэд өөрсдөө хууль санаачлах болон өргөдөл гаргах боломжийг олгосон цахим платформ юм. Иргэд энэхүү системээр дамжуулан гишүүдийн ирц, хэлэлцэж буй асуудалтай танилцдаг.</p>
4	Petition.parliament.mn	<p><i>Нийтийн өргөдөл гаргах цахим систем</i></p> <p>Иргэд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар УИХ-д өргөдөл, гомдол гаргах систем юм. Хэрэв иргэний гаргасан өргөдөл тодорхой тооны (33,000-аас дээш) дэмжлэг авбал УИХ-ын түвшинд албан ёсоор хэлэлцэх эрх зүйн зохицуулалттай.</p>
5	Legalinfo.mn	<p><i>Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем</i></p> <p>Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх шатны хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын</p>

		тогтоол, яам агентлагийн тушаал, шийдвэрийг нэг дороос харах, хайх боломжтой албан ёсны сан юм.
6	eBarimt.mn	<i>Цахим төлбөрийн баримтын систем</i> Татварын албанаас хэрэгжүүлж буй, иргэдэд төлбөрийн баримтаа бүртгүүлж НӨАТ-ын буцаан олголт болон сугалаанд оролцох боломж олгодог систем. Энэ нь далд эдийн засгийг бууруулах, татварын ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
7	e-Business.mn	<i>Бизнес эрхлэгчдэд зориулсан нэгдсэн платформ</i> Хуулийн этгээд шинээр байгуулах, нэр авах, тусгай зөвшөөрөл сунгах, аж ахуйн нэгжийн бүртгэлтэй холбоотой төрийн үйлчилгээг цогцоор нь үзүүлдэг. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хүнд суртлыг халах зорилготой.
8	egazar.gov.mn/	<i>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн систем</i> Газрын харилцаатай холбоотой бүх төрлийн үйлчилгээг (газар өмчлөх, эзэмших, ашиглах хүсэлт, төлбөр төлөх, кадастрын зураг харах) цахимаар үзүүлдэг. Иргэд өөрийн эзэмшлийн газрын мэдээллийг хянах боломжтой.
9	portal.ndaatgal.mn	<i>Даатгалын нэгдсэн систем</i> Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөө хянах, дэвтрээ баталгаажуулах, эмнэлгийн хуудас авах зэрэг нийгмийн хамгааллын үйлчилгээнүүдийг иргэдэд хүргэдэг. Мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал зэргийг шалгах боломжтой.
10	Gaali.mn	<i>Гаалийн цахим үйлчилгээний систем</i> 2021 онд үүсгэн байгуулагдсан Гаалийн бүрдүүлэлт, төлбөр тооцоо, лавлагаа, тодорхойлолт, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл, барааны ангилал, тарифын мэдээлэл болон тусгай зөвшөөрөл зэрэг иргэнд зориулсан 12 төрлийн үйлчилгээ, аж ахуй нэгжид зориулсан 33 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой.
11	itax.mta.mn, etax.mta.mn	<i>Цахим татварын нэгдсэн систем v0.2</i> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 177 дугаар тогтоолын хүрээнд татварын албанаас авах бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах, татвар төлөгчдийн тайлан илгээхтэй холбоотой хүндрэл бэрхшээлийг багасгах, шинэ хуулийн өөрчлөлтийн дагуу татварын тайлан хүлээн авах, санхүүгийн программаасаа хялбар шийдлээр илгээх боломжийг бүрдүүлэх, татварын албатай холбоотой хүсэлт, тодорхойлолтыг цахимаар хүлээн авах, хөндлөнгийн системүүдтэй уялдаа холбоог сайжруулах зорилготой уг төслийг хэрэгжүүлсэн. Тус системийг ашиглан иргэн, хуулийн этгээд бүх төрлийн татвараа цахимаар тайлагнах, төлөх, тодорхойлолт авах боломжтой юм.
12	e-geree.mn	<i>Цахим баримт бичгийн нэгдсэн систем v2.0</i> 2023 онд үүсгэн байгуулагдсан E-Geree Блокчэйн цахим баримт бичгийн системийг Засгийн газар, бизнес болон иргэдэд зориулсан бүх төрлийн баримт бичгийн харилцааг зохицуулахаар бүтээсэн. Өдгөө v2.0 хувилбар нэвтэрсэн байна.
13	ehalamj.mn	<i>Халамжийн нэгдсэн систем</i> 2020 онд үүсгэн байгуулагдсан Халамжийн нэгдсэн системийг

		ашиглан 18 бүлгийн 426 үйлчилгээг цахимаар авах боломжтой.
14	e-police app	<i>Цагдаагийн байгууллагын цахим үйлчилгээний систем</i> Иргэд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн үйлдлийг мэдээлэх, торгуулиа шалгах, төлөх, мөн гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийг цахимаар илгээх зориулалттай аппликейшн юм.
15	Medle.mn	<i>Боловсролын салбарын цахим сургалтын систем</i> Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан цахим хичээлийн сан бөгөөд сурагчид хаанаас ч чанартай боловсрол авах, багш нар туршлага солилцох боломжтой платформ.
16	UBTraffic.mn	<i>Нийслэлийн авто замын хөдөлгөөний удирдлагын систем</i> Улаанбаатар хотын авто замын ачаалал, түгжрэлийн мэдээллийг бодит хугацаанд харах, замын хөдөлгөөний хязгаарлалт болон төлөвлөлтийг хянахад зориулагдсан систем.
17	service.ulaanbatar.mn	<i>Нийслэлийн нэгдсэн үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем</i> <i>“Онлайн бизнес төв”</i> 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 9 дүүргийн ЗДТГ-ын худалдаа, үйлчилгээний хэлтсээс иргэн, хуулийн этгээдэд 74 төрлийн зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг, шат дамжлагыг багасгах зорилгоор хэрэглээнд нэвтрүүлсэн систем. Нийслэлд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл авах болон хувийн хэвшил-төрийн байгууллагуудын хариуцлага, хамтын ажиллагаа, хяналтыг сайжруулах нэгдсэн мэдээллийн систем юм. “Онлайн бизнес төв”-өөр дамжуулан 146 үйлчилгээг цахимаар авах боломжтой байна.

НҮБ-ын гишүүн орнуудын цахим засаглалын хөгжлийн өнөөгийн түвшнийг харуулдаг цахим засаглалын хөгжлийн индекс (E-Government Development Index, EGDI) нь тухайн улсын цахим хуудасны хөгжлийн хэв шинжийг үнэлэхийн зэрэгцээ дэд бүтэц, боловсролын түвшин зэрэг хүртээмжийн үзүүлэлтийг хамруулан авч үздэг. Тус үзүүлэлтээр Монгол Улсын индекс 2016 оноос хойш тогтмол өсөж, 2024 онд 193 орноос 46 дугаар байранд орсон нь 2022 онд 74 дүгээр байр, 2020 онд 92 дугаар байрт орж байсантай харьцуулахад мэдэгдэхүйц үсрэлт хийсэн байна.

*Хүснэгт 4. Монгол Улсын Цахим засаглалын хөгжлийн индекс 2003-2024 (E-Government Development Index, EGDI)*

Монгол Улсын цахим засаглалын хөгжлийн индекс (UN EGDI)		
Он	Ранк (Rank)	Оноо (Value)
2003 он	103	0.34
2004 он	75	0.42
2005 он	93	0.4
2008 он	82	0.47
2010 он	53	0.52

2012 он	76	0.54
2014 он	65	0.56
2016 он	84	0.52
2018 он	92	0.58
2020 он	92	0.65
2022 он	74	0.72
2024 он	46	0.85

Эх сурвалж: <https://publicadministration.un.org>

Дээрх байдлаар Монгол Улс Цахим засаглалын индексээр сайжирч буй цахим шилжилтийн гол цөм нь төрийн 1170 гаруй үйлчилгээг цахимаар 1.7 сая гаруй иргэндээ цогцоор үзүүлж буй E-Mongolia платформ юм. Энэхүү платформ нь газар зүйн алслагдмал байршлаас улбаалсан саад бэрхшээл, засаг захиргааны болон логистикийн хүнд суртлын сорилтуудыг даван туулж, төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэйгээр, цаг тухайд нь, зардал чирэгдэл багатай хүргэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн.<sup>3</sup> Үүнээс гадна Хүснэгт 2-д заасан 17 төрлийн төрийн цахим үйлчилгээний систем нь цахим хөгжлийн үсрэлтэд эерэг нөлөө үзүүлсэн.

Дүгнэвэл, сүүлийн жилүүдэд иргэд төрийн үйлчилгээг цахимаар түргэн, шуурхай авах (e-mongolia, e-tax, e-barimt зэрэг платформыг ашиглан) боломж бүрдсэнээр НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индексээр Монгол Улс жил ирэх тусам өсч 2024 онд 0.85 оноотойгоор 193 орноос 46 дугаар байранд орж дэлхийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй явж байна. Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар “Цахимаар нэн тэргүүнд (Digital First)” бодлогын зөвлөмж батлуулсан нь цахим засаглалын хөгжлийн суурийг бэхжүүлэх томоохон алхам болсон байна.

## 2.5. Монгол Улсын өгөгдлийн бодлого, зохицуулалтын орчныг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 6 дугаар зүйлд зааснаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий урт хугацааны, дунд хугацааны, богино хугацааны гэсэн төрөлтэй байна.

<sup>3</sup> Мэдээ: Далайд гарцгүй Монгол Улсын Цахим Үндэстэн болох замнал: Ахиц дэвшил, сорилтууд, 2024.10.07, <https://mongolia.un.org/mn/280629-%D0%B1%D0%BB%D0%BE%D0%B3-%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B0%D0%B9%D0%B4-%D0%B3%D0%B0%D1%80%D1%86%D0%B3%D2%AF%D0%B9-%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-%D1%86%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D1%82%D1%8D%D0%BD-%D0%B1%D0%BE%D0%BB%D0%BE%D1%85-%D0%B7%D0%B0%D0%BC%D0%BD%D0%B0%D0%BB-%D0%B0%D1%85%D0%B8%D1%86-%D0%B4%D1%8D%D0%B2%D1%88%D0%B8%D0%BB-%D1%81%D0%BE%D1%80%D0%B8%D0%BB%D1%82%D1%83%D1%83%D0%B4>

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хиймэл оюун, их өгөгдөл, дэвшилтэт технологид тулгуурласан улс орны хөгжлийн нэгдсэн шилжилт тодорхой тусгагдсан байна. Уг бодлогын хүрээнд хот байгуулалт, нийгмийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, эдийн засаг, уул уурхай, инновац, төрийн удирдлага, кибер аюулгүй байдлыг уялдаа холбоотойгоор шинэчилж, төрийн үйл ажиллагааны үр ашиг, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхийг зорьж байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд хиймэл оюун, их өгөгдөл, орон зайн мэдээлэл (GIS), блокчейн зэрэг дэвшилтэт технологид тулгуурлан төрийн удирдлага, эдийн засаг, аюулгүй байдал, хууль сахиулах болон шүүхийн тогтолцоог бүхэлд нь шинэчлэх бодлогын цогц чиглэл тодорхой тусгагдсан байна. Энэхүү бодлого нь орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод, үр ашигтай байдлыг дээшлүүлэх, үндэсний аюулгүй байдал болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилготой.

Тухайлбал, их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан орон зайн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, удирдлагын нэгдсэн платформ хөгжүүлэх замаар бүсчилсэн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын шийдвэрийг нотолгоонд суурилан боловсруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах дижитал дэд бүтцийг бүрдүүлэхээр тусгасан. Үүний зэрэгцээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хиймэл оюуныг нэвтрүүлж, тендерийн оролцогчдын давхцал, хуурамч материал, ашиг сонирхлын зөрчлийг өгөгдөлд суурилан илрүүлэх замаар авлига, үр ашиггүй зардлыг бууруулах зорилт дэвшүүлжээ.

Мөн Үндэсний их өгөгдлийг зах зээлийн зарчимд суурилан эдийн засгийн эргэлтэд оруулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

*Хүснэгт 5. Монгол Улсын бодлогын баримт бичигт их өгөгдлийн талаар тусгагдсан байдал*

<p><b>“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого</b> (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт)</p>	<p><b>Ухаалаг санхүүгийн зах зээл</b> 4.3.21.Их өгөгдөлд суурилсан, алгоритмын болон өндөр давтамжтай арилжааны платформыг нэвтрүүлэн хөрөнгийн зах зээл дэх технологийн дэвшлийг тогтмол хөгжүүлнэ 4.3.22.Технологийн дэвшил, их өгөгдөлд суурилсан хяналт шалгалтын технологи болон зохицуулалтын технологийг зохицуулалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. <b>Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)</b> 5.3.5.Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.</p>
<p><b>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр</b></p>	<p><b>1.1.5.Олон төрөлт нийтийн тээвэр, авто зам</b> 1.1.5.5.Улаанбаатар хотод тойрог замын зохион байгуулалт хийж, замын хөдөлгөөний эрчмийг 30 хувиар нэмэгдүүлж, их өгөгдөлд үндэслэн автобусны сүлжээ, чиглэлийг оновчилж, төлбөрийн системийг хялбарчилж, хүн амын нягтаршилд тохируулж нийтийн тээврийн хэрэгслийг оршин суугчдад хүртээмжтэй байдлаар дахин төлөвлөнө.</p>

<p>(Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт)</p>	<p><b>2.1.2.Хөдөлмөр эрхлэлт</b>  2.1.2.6. Ядуурал, ажилгүйдэл болон хүн амын амьжиргааны түвшнийг тооцох аргачлалыг үндэсний онцлогт нийцүүлж, их өгөгдөл, хиймэл оюунд суурилан шинэчилнэ.</p> <p><b>2.1.3.Нийгмийн баталгаа</b>  2.1.3.2.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.</p> <p><b>2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол</b>  2.2.1.3.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ.</p> <p><b>2.2.4.Цахимжсан боловсрол</b>  2.2.4.1.Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зай, их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюуныг ашиглах замаар үр ашиг, оновчтой байдлыг сайжруулна.</p> <p><b>2.3.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж</b>  2.3.2.7.Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын стандартын дагуу бүрдүүлж, их өгөгдөл үүсгэнэ.</p> <p><b>3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин</b>  3.2.2.14.Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө.</p> <p><b>4.3.2.Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи</b>  4.3.2.4.Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, блокчейн, юмсын интернэтийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэж болох чиглэлүүдийг тодорхойлж, судалгааны ажлуудыг санхүүжүүлж, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлнэ. Төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ. тогтолцоог оновчтой болгож, хиймэл оюуныг ашиглана.</p> <p><b>4.3.3.Цахим орчин дахь хүний эрх, кибер аюулгүй байдал</b>  4.3.3.1.Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, зохистой хэрэглээний талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.  4.3.3.2.Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлнэ. Их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилан кибер аюулгүй байдлын тогтолцоог олон улсын түвшинд хүргэн бэхжүүлнэ.</p>
<p><b>Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги</b>  (Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолын хавсралт)</p>	<p>3.2. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:  3.2.5.их өгөгдөл, хиймэл оюун, зүйлсийн интернэт, үүлэн технологи, машин сургалт зэрэг дэвшилтэт технологийн хэрэглээнээс үүдэн гарах эмзэг байдал, аюул заналыг таних, эрсдэлийг бууруулах боломжийг сайжруулах.</p>
<p><b>Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө<sup>4</sup></b>  <b>Монгол Улсын хөгжлийн 2026 онд</b></p>	<p><b>2.1."Эрдэм боловсролтой Монгол хүн"-ийг хөгжүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлнэ:</b>  2.1.11.Их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан цахимжсан боловсролын тогтолцоог тогтвортой хөгжүүлнэ.</p>

<sup>4</sup> Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай, Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол, 2025.05.29, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432520199262>

баримтлах бодлогын чиглэл	<b>2.3.Хүн төвтэй нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ:</b> 2.3.1.Гэр бүлд ээлтэй, хүн төвтэй, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээний тогтолцооны цогц шинэчлэл хийж, их өгөгдөл, хиймэл оюуныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг үе шаттай нэвтрүүлнэ.
Их өгөгдлийн (big data) сан" үүсгэх тухай (Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоол	1. Үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Их өгөгдлийн (big data) сан"-г үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх

Хүснэгт 6. Монгол Улсын хууль тогтоомжид их өгөгдлийн талаар тусгагдсан байдал

Хууль	Зохицуулалт
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021)	<p>12.1.Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, нээлттэй өгөгдөл болгож болно.</p> <p>31.1.1.нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл бий болгох, төрийн цахим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэх, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шинэчлэл хийх, хүний нөөцийн хөгжлийн төсөл, хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;</p>
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (2024)	<p><b>6 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газрын бүрэн эрх</b></p> <p>6.1.Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.6.хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксыг байгуулж, холбогдох журам батлах.</p> <p><b>13 дугаар зүйл.Татварын болон татварын бус дэмжлэг</b></p> <p>13.3. Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх дараах татварын бус дэмжлэг үзүүлнэ:</p> <p>13.3.4.хиймэл оюунд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох;</p>
Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль (2025)	<p><b>11 дүгээр зүйл.Хархорум хотын хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах</b></p> <p>11.2.Ухаалаг хот төлөвлөлт нь инновац, их өгөгдөл, хиймэл оюун, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг ашиглах бөгөөд дараах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ:</p>

	<p>11.2.1.эрүүл мэнд, боловсрол, соёлын зэрэг нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хотод тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх;</p> <p>11.2.2.их өгөгдөлд суурилан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж, үр дүнг тооцоолох;</p> <p>11.2.3.мэдээлэл солилцох системийг үүсгэх, түүний тасралтгүй, найдвартай байдал болон кибер аюулгүй байдлыг хангаж, хүний хувийн мэдээллийг хамгаалах, мэдээллийг саадгүй солилцох нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>11.2.4.хотоос үзүүлэх үйлчилгээг цахим, ухаалаг системээр авах нөхцөлийг бий болгох;</p> <p>11.2.5.оршин суугч болон иргэнд мэдээллийг нээлттэй, ил тод хүргэх, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>11.2.6.хотын инженерийн дэд бүтэц, замын хөдөлгөөний нөхцөл байдал, нийтийн тээврийн удирдлага, орчны аюулгүй байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх, агаарын чанарын болон орчны бохирдол, чийгшил, байгаль орчны стандартыг хэмжих, хянах, мэдээлэх нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>11.2.7.оршин суугчийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах, хотын үйл ажиллагаатай холбоотой санал асуулга зохион байгуулах цахим оролцооны систем ажиллуулах;</p> <p>11.2.8.харилцаа холбооны сүлжээг сайжруулж хотын интернэт хэрэглээний хүртээмжийг нэмэгдүүлэх;</p> <p>11.2.9.тоон гарын үсгийн хэрэглээг дэмжих;</p> <p>11.2.10.оршин суугчийн цахим ур чадвар, чадамжийг нэмэгдүүлэх, цахим орчинд хүүхэд хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>
<p>Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай (2024)</p>	<p><b>14 дүгээр зүйл.Хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглах</b></p> <p>14.1.Хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг дараах хэлбэрээр ашиглана:</p> <p>14.1.1.инновац, их өгөгдөл, хиймэл оюун, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;</p>
<p><b>Хэм хэмжээний акт</b></p>	<p><b>Зохицуулалт</b></p>
<p>Цахим технологийн шинжилгээ хийх журам (Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/315, А/91 дугаар хамтарсан тушаалын хавсралт)</p>	<p><b>Нэг.Нийтлэг үндэслэл</b></p> <p>1.1.Энэхүү журмын зорилго нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх явцад цахим технологийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p><b>Хоёр.Цахим технологийн шинжилгээний ангилал, төрөл</b></p> <p>2.2.8."Цахим технологийн зарим төрлийн шинжилгээ" нь хиймэл оюун болон интеграцлагдсан (IoT) бүтэцтэй технологи, төхөөрөмжийг шинжилж, дүгнэлт гаргах ажиллагаа</p>

### III. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ

Аргачлалын 4.1-д бичсэнээр зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байдлаар томьёолох хэрэгтэй юм. Монгол Улсад өгөгдөл, өгөгдлийн бүтээгдэхүүн, түүнийг хариуцлагатай ашиглах, хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох хүрээнд тулгамдаж буй асуудлын цар хүрээг авч үзсэн. Асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар томьёолов. Үүнд:

- 1) Өгөгдлийн амьдралын мөчлөг (үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, хадгалах, солилцох, дамжуулах, ашиглах, дахин ашиглах, нөөцлөх, устгах)-ийг бүхэлд нь хамарсан өгөгдөл үүсэх, солилцох, хуваалцах, ашиглах, дахин ашиглах, устгах харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- 2) Өгөгдлийн дэд бүтэц, өгөгдлийн сан, мета өгөгдлийн зохицуулалт, стандартын орчныг бий болгох;
- 3) Кибер халдлага болон бусад аюулд өртөх эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт;
- 4) Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, өгөгдөлд суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, шинэ бизнес хөгжүүлэх, баялаг бүтээж бодит хэрэглээг бий болгох;
- 5) Өгөгдлийн засаглалыг бий болгох, өгөгдөл эзэмшигчийн эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг бий болгох;

Дээрх зорилтыг хэрэгжүүлснээр Монгол Улсад өгөгдөл, түүнтэй харьцах харилцаа, үйл ажиллагааг ёс зүйтэй, хүн төвтэй, хариуцлагатай байдлаар хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзлээ.

#### IV. ТУХАЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдлыг хангаж чадах бусад хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

*Хүснэгт 7. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал*

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	“Тэг” хувилбар Өгөгдөл, өгөгдлийн бүтээгдэхүүн, түүнийг солилцох мэдээллийн систем, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, үнэ цэнэ, хяналт зохицуулалтгүй хэвээр байна. Зорилгод хүрэх боломжгүй	Зардал байхгүй.
2	Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх Төрөөс өөртөө байгаа өгөгдөл, мэдээллээ ашиглуулах, дамжуулах, боловсруулах, бусад оролцогчдоос аюулгүй байх эрхийг хангах, хууль ёсны үйл ажиллагаа явуулахыг шаардах талаар мэдээлэлтэй болгох давуу талтай байна. Гэхдээ бодитоор эрх, ашиг сонирхол нь зөрчигдсэн тохиолдолд харицлага тооцох, хохирол гаргуулах эрх зүйн орчин дутмаг байна.	Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх Төрөөс санхүүгийн интервенц хийх нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал зөрчигдөх эрсдэл, ёс зүйн болон бусад эрсдэлийг даван туулах арга болж чадахгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой. Төр, хувийн хэвшлийн түншлэл нь инновацийг хөгжүүлэх, шинэ хэрэглээний програмуудыг хөгжүүлэх, нээлттэй мэдээллийн санаачилгын тогтвортой байдлыг хангахад тусална. Асуудлыг дангаараа шийдвэрлэх хувилбар байж чадахгүй юм.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.
6	Захиргааны шийдвэр гаргах Өгөгдлийг нийтийн сайн сайхны төлөө ашиглаж, үнэ цэнэ бий болгох, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах боломжтой хэдий ч хуульд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх хэмжээ олгосон заалт байхгүй тул хууль зүйн үндэслэлгүй юм.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах Өгөгдлийн эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, өгөгдлийн ангилал, засаглал, хамгаалалт, солилцоо болон эдийн засгийн эргэлтийн зохицуулалтыг хуульчлах шаардлагатай тул Өгөгдлийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах, бусад салбар эрх зүйн хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зохимжтой байна.	Төрөөс хууль батлагдах болон үйл ажиллагаатай холбоотой зардал гарах бөгөөд ингэснээр тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна.

Дээрх хувилбаруудыг харьцуулахад Монгол Улсын хэмжээнд баримтлах өгөгдлийн тогтолцоог бэхжүүлэх, салбар бүрт баримтлах өгөгдлийн засаглалын зарчмыг тодорхойлох, өгөгдөлд суурилсан бодлого, төлөвлөлтийг бэхжүүлэхэд шаардлагатай чадавх, хүчин зүйлсийг хөгжүүлэх, богино, үндэсний хэмжээнд өгөгдөл ашиглалт, солилцоог дэмжихэд шаардлагатай орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Цаашилбал, дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Үндэсний өгөгдлийн тогтолцоо бүрдэж, боловронгуй болох
  - өгөгдлийн экосистем,
  - өгөгдлийн засаглал,
  - өгөгдлийн архитектур
2. Бүх түвшинд өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт хэрэгжиж, төлөвших
  - Засгийн газрын шийдвэр гаргалт
  - Төрийн байгууллагын шийдвэр гаргалт
  - Хувийн хэвшлийн шийдвэр гаргалт
3. Цахим болон өгөгдлийн эдийн засгийн хөгжил, дэвшилд хүрэх
  - Судалгаа шинжилгээ, инновац
  - Хиймэл оюун ухаан, машин сургалт
  - Өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ
4. Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ахиц гарах, шинэчлэл хийгдэх
  - Статистикийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, баталгаажуулалт хийх
  - Өгөгдлийн чанар, хүртээмж нэмэгдэх
  - Шинэ статистик бий болох

Иймд асуудлыг шийдвэрлэхэд оновчтой шийдэл нь хууль тогтоомжийн төсөл боловсруулж, эрх зүйн суурийг бэлдэх нь чухал байна.

## **V. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

### **5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн Монгол улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалахад чиглэдэг учир асуудлыг зохицуулахаар сонгож буй хувилбар нь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн, хууль бусаар хязгаарласан байх ёсгүй ба тухайн хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө аливаа хэлбэрээр зөрчигдөх ёсгүй. Иймд үүнийг урьдчилан шалгасан байх шаардлагатай.

Цахим технологийн хөгжил харилцаа холбооны хувьсгал хийж, мэдлэгийг “ардчилж”, бүтээмжийг дээшлүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах төдийгүй хүн төрөлхтний энх тогтвортой орших найдвар, шийдэл болж байна. Гэвч мэдээлэл, өгөгдлийг их хэмжээгээр цуглуулж, боловсруулах нь хүний эрх, эрх чөлөөний эрсдэлийг дагуулдаг бөгөөд хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзлээ.

#### **1) Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**

Энэ хэсэгт хүний бүхий л эрх, эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар гадуурхах, хязгаарлах буюу дорд үзэхийг хориглосон заалт, агуулгыг зохицуулалтын хувилбаруудад тусгасан эсэхийг шалгана.

Хамгийн өргөн хүрээний ойлголтоороо өгөгдөлд ялгаварлан гадуурхалтгүйгээр хандах гэдэг нь хэн ч, ямар ч нөхцөлд өөрийгөө таниулах, өгөгдлийг ашиглахтай холбоотой шалтгаан, үндэслэл тавих шаардлагагүйгээр хандах боломжийг хэлнэ.

Орчин үеийн өгөгдөл боловсруулах технологи, хиймэл оюун ухаан, алгоритмд суурилсан шийдвэр гаргалт нь иргэдийг нас, хүйс, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, орлого, байршил зэрэг үзүүлэлтээр шууд болон шууд бусаар ялгаварлах эрсдэлийг бий болгож байна

Зохицуулалтын хувилбарт “ялгаварлан гадуурхахгүй байх” болон “тэгш эрхийг хангах” зарчмыг бие даасан суурь зарчим болгон тусгах нь зүйтэй. Өөрөө хэлбэл хиймэл оюуны ашиг тус, эрсдэл болон зардлыг тэгш бөгөөд шударга хуваарилахыг хангах, аливаа хэлбэрийн хазайлтаас урьдчилан шударга байдлыг дэмжихийг эрмэлзэх ёстой.

#### **2) Оролцоог хангах**

Зохицуулалтын хувилбар нь иргэд өгөгдлөө боловруулахаас татгалзах, өөрчлөх устгах эрхийг хангах зайлшгүй шаардлагатай. Мөн өгөгдөл хамгаалахтай холбоотой ажиллагааны талаар эерэг болон сөрөг тал, бүхий л эрдсдэлийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж байх хэрэгтэй.

Өөрсдийн ашиглаж буй өгөгдөл, хиймэл оюуны системийн амьдралын мөчлөгийн бүх үе шатанд, мөн хиймэл оюуны систем оролцсон шийдвэр гаргалтын үйл явцад ил тод байдал болон тайлбарлагдах боломжийг хангах ёстой. Шийдвэртэй холбоотой мэдээлэл, үндэслэл нь тухайн хүнд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр танилцуулагдах ёстой. Ингэснээр тухайн хууль тогтоомж нь хиймэл оюуныг ёс зүйтэй хэрэглэх үндэс бүрдэх ач холбогдолтой байна.

Хүний үндсэн эрх, эрх чөлөө, эдлэх эрх, үйлчилгээ авах эрх ашигт нөлөөлөх магадлалтай, эсхүл нөлөөлсөн шийдвэр нь хиймэл оюун алгоритмаар дэмжигдсэн, эсхүл түүний үндсэн дээр гарсан тохиолдолд тухайн хүмүүсийг утга учиртай, бодит мэдээллээр хангах ёстой бөгөөд шийдвэрийн үндэслэл, ашигласан логиктой танилцах боломжийг олгох шаардлагатай.

### **3)Хууль дээдлэх зарчим ба хариуцлага**

Зохицуулалтын хувилбар нь техникийн болон эрх зүйн механизмыг хослуулах ёстой бөгөөд өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалтын ёс зүй, хууль зүйн хариуцлагын тогтолцоог олон улсын түвшинд хатуу тогтоож, үйл ажиллагааныхаа бүх шатанд тусгах хэрэгтэй.

Түүнчлэн зохицуулалтын хувилбартай холбоотой ёс зүйн болон хууль зүйн хариуцлага, тайлагналтыг амьдралын мөчлөгийн аль ч үе шатанд хүн эсхүл хуулийн этгээдэд оногдуулах боломжтой засаглалын зохистой бүтэц, тогтолцоог бий болгох, эсхүл сайжруулах шаардлагатай. Түүнээс дамжин учирсан хор хохирлыг шалган тогтоож, холбогдох зохих арга хэмжээг авах ёстой. Ингэснээр өгөгдөл хамгаалахтай холбоотой хууль тогтоомж нь харилцан уялдаатай бодитой хэрэгжих нөхцөл бүрдэхээр байна.

### **4)Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх**

Хувь хүний мэдээллийг хамгаалах зорилготой тодорхой бус, өргөн хүрээтэй зохицуулалт нь хүний эрхийг хэт хязгаарлах эрсдэл үүсгэж болзошгүй юм. Ялангуяа өгөгдөл цуглуулах, боловсруулах, дамжуулах болон хяналт тавих ажиллагаанд төрийн байгууллагын эрх хэмжээг өргөн хүрээнд тодорхойлсон тохиолдолд хүний хувийн нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрх, мэдээлэл хамгаалуулах эрхэд нөлөөлөх боломжтой.

Иймээс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгааг илүү тодорхой, хэрэгжихүйц байдлаар тусгах мөн төлөвлөсөн болон төлөвлөөгүй нөлөөллийг хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчих зэрэг хор хөнөөл үүсгэхээс зайлсхийхийн тулд тасралтгүй хянаж, үнэлж байх нь чухал юм.

### **5)Эрх агуулагч**

Эрхээ хэрэгжүүлэх бодит механизм, гомдол шийдвэрлэх тогтолцоо, байгууллагын хариуцлагыг тодорхой тусгаснаар иргэний мэдээлэл хамгаалагдах эрх зүйн баталгаа сайжрах юм. Мөн ерөнхий зарчмын хувьд, амь нас, үхэлтэй холбоотой шийдвэр болон хүний үндсэн эрхэд нөлөөх бусад аливаа шийдвэрүүдийг өгөгдөл дээр үндэслэн шууд шилжүүлж болохгүй бөгөөд ийм шийдвэрүүд нь заавал хүний оролцоо, хяналтан дор байх ёстой.

Хүний хяналт нь хиймэл оюуны системийн нийт үйл ажиллагаанд хүний зүгээс хяналт тавих чадавхтай байх, мөн тухайн нөхцөл байдал бүрд уг системийг ашиглах эсэх, хэрхэн ашиглахыг шийдвэрлэх боломжийг, үүнд хиймэл оюуны системийн гаргасан шийдвэрийг хүчингүй болгох эрхийг багтаасан байх ёстой.

### **6) Үүрэг хүлээгч**

Төр болон өгөгдөл эзэмшигч нь өгөгдлийг хамгаалах, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх үүргийг хүлээдэг байх шаардлагатай юм. Тодруулбал, хувийн өгөгдлийг хууль ёсны, шударга зорилгоор, ил тод байдлаар цуглуулах, боловсруулах, хадгалах, аюулгүй байдлыг хангах, тэдгээрийг өөрөө нотлох, хариуцлага хүлээх үүргийг хууль тогтоомжид тусгах шаардлагатай юм.

### **5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний үнэлгээний зорилго нь тухайн зохицуулалтын хувилбар нь өсөлт, ажил эрхлэлт, бизнес, өрсөлдөх чадвар болон нийтийн баялагт хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тогтооход оршино. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг шууд болон шууд бус үр нөлөө гэж ангилах боломжтой. Шууд үр нөлөөний энгийн жишээ бол зохицуулалтын хувилбарын улмаас улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт зардал үүсэх, аж ахуйн үйл ажиллагааны татварын хэмжээг өөрчлөх зэрэг байж болно.

Өгөгдөл хамгаалалт, хиймэл оюуны ёс зүй, хариуцлагатай хэрэглээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох эсэх асуудал нь эдийн засагтай шууд хамаарал багатай. Зохицуулалтын хувилбар нь инновац болон судалгаа шинжилгээ, өмчлөх эрх, хэрэглэгч болон гэр бүлийн төсөв, дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна. Мөн мэдээлэх үүргийн улмаас хуулийн этгээдэд захиргааны зардлын ачаалал үүсэхгүй.

Зохицуулалтын хувилбар нь хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зардлыг улсын төсвөөс шийдвэрлэх учир сөрөг үр нөлөөтэй гэж үзэж болох юм. Гэвч үүгээр тус хувилбарыг эдийн засагт сөрөг үр нөлөөтэй гэж үзэж болохгүй. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлээгүй тохиолдолд дунд, урт хугацаанд эрх зүйн тодорхой бус байдал хадгалагдах ба энэ нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийн үнэлгээг нэмэгдүүлэх, инновац, өндөр технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт татах боломжийг хязгаарлах сөрөг талтай.

Харин зохицуулалтын хувилбар нь эхний үед тодорхой хэмжээний зардал шаардах боловч дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих боломж илүү өндөр гэж үзэж байна.

Хэрэглэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээ, өгөгдлийг зөв зохистой хэрэглэж байгаа байдал, ёс зүйн зарчмын хэрэгжилтийг хангуулах, тавих хяналтыг тодорхойлон хуульчлах нь зах зээлд эрх зүйн тодорхой байдал бий болгож, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ. Ил тод, хариуцлагатай, урьдчилан таамаглах боломжтой зохицуулалтын орчин нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлнө.

Мөн хууль ёсны байдал, хяналт сайжирснаар хүний эрхийн баталгаа бэхжиж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилт хангагдах нь олон улсын зах зээл дэх нэр хүнд, эдийн засгийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үүний үр дүнд санхүүгийн урсгал тогтвортой болж, инновац, өндөр нэмүү өртөг шингэсэн салбарууд хөгжих нөхцөл бүрдэж, макро эдийн засгийн түвшинд эдийн засгийн өсөлтийг дэмжих боломж нэмэгдэнэ.

Иймд эдийн засгийн талаас дүгнэхэд төрийн байгууллагуудад үүссэн мэдээллийн санг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу хүн хувь, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийн заавал мэдээллийн эзний зөвшөөрөл эсвэл хуульд заасан үндэслэлээр мэдээллийн эзэнд мэдэгдсэний дагуу ашиглах зохицуулалт үйлчилж байна. Тэгвэл төрийн аливаа шийдвэр гаргалтад хувь хүн, хуулийн этгээдийн түвшинд нэгтгэсэн мэдээллийн сан шаардлагатай болохын хэрээр мэдээллийн санг ямар түвшинд хэрхэн нэгтгэх, хадгалах, ашиглах асуудлаар зохицуулалт шаардлагатай болж байна. Иймд уг асуудлаар нэгдсэн шийдэл, зохицуулалт бий болгох хэрэгцээ байна

### **5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Энэ хэсэгт зохицуулалтын нийгэмд үзүүлэх үр нөлөөг авч үзсэн болно. Нийгэмд үзүүлэх үр нөлөө нь үндсэн шинжийн хувьд олон хэлбэрийг агуулдаг бөгөөд өөр хоорондоо болон бусад төрлийн үр нөлөөтэй давхцах нь бий.

Зохицуулалтын хувилбар нь соёл, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг болоод эерэг нөлөөллийг дээрх байдлаар үзүүлэхээр байна.

#### **1) Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл**

Хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөг ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлтийн үндсэн дээр үнэлнэ. Өгөгдөл, хиймэл оюунтай холбоотой салбар эрх зүйн зохицуулалтыг бий болгохтой холбоотой сонгосон зохицуулалтын хувилбар нь хөдөлмөрийн зах зээлд шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой бөгөөд энэ нөлөө нь мэргэжил, ур чадвар, байгууллагын төрөл, бүс нутаг зэргээс хамааран ялгаатай илэрч болзошгүй.

Зохицуулалтын хувилбар нь шинэ чиг үүрэг, хяналт, нийцэл, аудит, эрсдэлийн үнэлгээ зэрэг үйл ажиллагааг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ нь хиймэл оюуны нийцэл, ёс зүй, өгөгдөл хамгаалалт, хяналтын чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн эрэлтийг нэмэгдүүлж, тодорхой хүрээнд шинээр ажлын байр бий болгох боломжтой. Гэсэн хэдий ч уг нөлөө нь нийт хөдөлмөрийн зах зээлийг хамарсан бус, харин тодорхой мэргэжил, ур чадвар шаардсан салбарт төвлөрөх шинжтэй байна.

Мөн өгөгдөлд суурилсан үйлчилгээ, бүтээгдэхүүн ашигладаг мэргэжил, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагаанд тодорхой зохицуулалтын шаардлага бий болгох боломжтой боловч энэ нь ерөнхий хориг, нас, хүйс зэрэг шалгуураар ялгаварлах шинжтэй биш байна.

## **2) Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх**

Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрхэд үзүүлэх нөлөөг ажлын чанар, стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилчдын эрх, үүргийн өөрчлөлтийн хүрээнд үнэлнэ.

Зохицуулалтын хувилбар нь өгөгдөл боловсруулах, хиймэл оюуны хэрэглээнд тавих хяналтыг хуульчлах замаар ажлын стандарт, ажлын чанар, хариуцлагын шалгуурт тодорхой өөрчлөлт авчрах боломжтой. Ялангуяа хиймэл оюунд суурилсан ажлын орчинд ил тод байдал, хүний оролцоо, эрсдэлийн удирдлагатай холбоотой шинэ стандарт, журам боловсруулах шаардлага үүсэж болзошгүй. Энэ нь ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн эерэг нөлөөтэй байж болох ч хэрэгжилтийн арга хэлбэрээс хамааран тодорхой зохицуулалтын ачаалал бий болгох боломжтой.

## **3) Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал**

Зохицуулалтын хувилбар нь ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, хүний эрхийг хамгаалах зарчмыг хангаж, шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсэх эрсдэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Түүнчлэн энэ хувилбар нь тодорхой бүлэгт сөрөг нөлөө үзүүлэх бус, харин эрх нь зөрчигдөх эрсдэлтэй бүлгүүдэд хамгаалалтын механизм бий болгох шинжтэй байна.

## **4) Төрийн удирдлага, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун**

Зохицуулалтын хувилбар нь хиймэл оюунд тавих хяналтыг хуульчлах замаар төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд тодорхой өөрчлөлт авчирч, ил тод байдал, хариуцлага, шүүхийн хяналтын баталгааг бэхжүүлэх боломжтой. Энэ нь иргэдийн шүүхэд хандах, эрхээ хамгаалуулах боломжийг өргөжүүлж, улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд ил тод, шударга орчныг бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

#### 5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Өгөгдлийг улам нээлттэй болгосноос хамгийн их ашиг тусыг хүртэгч нь хэрэглэгчид юм. Үүний нэг жишээ гэвэл бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээллийг, жишээлбэл нийтийн тээврийн маршрут, байрлалын бодит цагийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн тусламжтайгаар авч чаддаг байснаар, эсвэл ямар нэгэн үйлдвэрлэгч компани, байгууллагын хөдөлмөр хамгаалал, байгаль орчны талаар авдаг арга хэмжээний мэдээлэл зэргийг нээлттэй өгөгдлийн тусламжтайгаар хугацаа алдалгүй авч чаддаг байснаар хэрэглэгчид өөрсдийн үнэт зүйл, таалалд хамгийн сайн тохирох бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох боломжийг эдлэж эхлэх ба энэ нь эдийн засгийн оролцогч талуудын дунд болон зах зээл дээр итгэлцлийг бий болгон, дэмжих нөлөөтэй байна.

#### 5.5. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх

Монгол Улс нь НҮБ-ын болон түүний төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО-гийн бүрэн эрхт гишүүн орны хувьд тус байгууллагаас баталсан конвенц, тунхаглал, зөвлөмжийн зорилго, зарчим, чиглэлийг хүндэтгэн дагаж мөрдөх, үндэсний хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.<sup>5</sup>

2022 оны 5 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон [Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль](#) (PDPL), [Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль](#), [Кибер аюулгүй байдлын тухай хууль](#) нь олон улсын өгөгдөл хамгааллын зарчмуудтай нийцүүлэн боловсруулагдсан.

Хүний хувийн мэдээллийг субъектийн зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилээс гаргахыг хориглосон бөгөөд гагцхүү хууль эсхүл Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд олон улсын гэрээгээр зохицуулагдана.

Өгөгдлийн тухайд олон улсын стандарт, гэрээ хэлэлцээрүүдтэй нийцэж байгаа боловч хил дамнансан харилцааны хувьд өгөгдлийн солилцоо болон кибер аюулгүй байдлын нэмэлт аудит, хамгаалалтыг олон улсын түвшинд тогтмол барьж ажиллах шаардлагатай байна.

---

<sup>5</sup> НҮБ-ийн дүрэм, 56 дугаар зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн 55 дугаар зүйлд заасан зорилгыг биелүүлэхийн тулд хамтарсан буюу бие даасан арга хэмжээг Байгууллагатай хамтран хэрэгжүүлж байх үүрэгтэй., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1211>

## VI. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

### 6.1. Өгөгдлийн зах зээл болон олон улсын туршлага

Дэлхийн хэмжээнд өгөгдлийн хурдацтай өсөлт болон технологийн дэвшил нь өгөгдлийн төвүүдийн дэд бүтцийг өргөжүүлэх, их өгөгдлийн зах зээлийг эрчимтэй хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байна. Тодруулбал, өгөгдлийн урсгалын хэмжээ 2024 онд 149 зеттабайт байсан бол 2028 онд 394 зеттабайт болж өсөх төлөвтэй байгаа нь өгөгдөл хадгалах, боловсруулах эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, одоогоор үйл ажиллагаа явуулж буй 11,000 гаруй өгөгдлийн төвийг улам өргөжүүлэхэд хүргэж байна.

Энэхүү өсөлтөд хиймэл оюуны хөгжил чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд ирэх 5-10 жилийн хугацаанд үүлэн технологид суурилсан өгөгдлийн төвүүдийн хүчин чадлыг 200 гигаваттаас давуулахад түлхэц болно.

Эдийн засгийн хувьд, энэхүү хандлагыг дэлхийн их өгөгдлийн зах зээл тодорхой харуулж байгаа бөгөөд тус зах зээл 2023 онд 327.26 тэрбум ам.доллараар үнэлэгдсэн ба 2024-2030 оны хооронд жилд дунджаар 14.9 хувиар өсөхөөр тооцоологджээ. Иймд өгөгдлийн өсөлт, хиймэл оюуны дэвшил, зах зээлийн тэлэлт хоорондоо нягт уялдаатайгаар өгөгдлийн дэд бүтцийн хөгжлийг шинэ шатанд гаргаж байна.

### 6.2. Олон улсын өгөгдлийн чиглэлийн бодлого, зохицуулалтын орчин

Судалгааны хүрээнд Европын Холбоо, Бүгд Найрамдах Эстони улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Сингапур зэрэг улсуудын өгөгдлийн засаглалыг өнөөгийн нөхцөл байдал, SWOT шинжилгээ болон өгөгдлийн бодлогод туссан үр дүн, үзүүлэлтийг жишээ болгон судалж, үр дүнг тоймлон орууллаа.

**ЕВРОПЫН ХОЛБОО (ЕХ):** Өгөгдлийн зохицуулалт нь 2018 оноос хэрэгжиж эхэлсэн Мэдээлэл хамгаалах ерөнхий зохицуулалт (GDPR)-ад тулгуурладаг. GDPR болон түүнтэй холбоотой ЕХ-ны зохицуулалтууд нь хувийн мэдээллийг хамгаалах тогтолцоо бүрдүүлж, дижитал зах зээлийг идэвхжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ, ЕХ-ны гишүүн орнууд болон байгууллагууд нь төрийн эмзэг мэдээллийн ангиллын тогтолцоог баримталдаг ба өгөгдлийн эдийн засгийг дэмжих стратегийг (жишээ нь: нээлттэй өгөгдлийн бодлого болон шинээр гарч буй ЕХ-ны Өгөгдлийн стратеги) хэрэгжүүлж байна. ЕХ-ны өгөгдлийн засаглалын гол онцлогууд нь:

- **GDPR:** Европын холбооны өгөгдлийн засаглалын хүрээ нь хувийн мэдээллийг хамгаалах хатуу стандартыг тогтоодог.
- **Дижитал нэгдсэн зах зээл:** Европын эдийн засгийн бүсэд өгөгдөл чөлөөтэй урсдаг, инновац, эдийн засгийн өсөлтийг дэмждэг нэгдмэл дижитал зах зээлийг бий болгохыг зорьдог.
- **Өгөгдлийн стратеги:** GDPR-ийн хамт Европын Холбоо нь эдийн засаг, нийгмийн ашиг тусын тулд хувийн бус өгөгдлийг оруулаад өгөгдлийн бүрэн боломжийг нээх зорилготой илүү өргөн хүрээтэй "Өгөгдлийн стратеги"-ийг дэмждэг.

- **Нээлттэй өгөгдлийн санаачилга:** Төрийн секторын өгөгдлийг дахин ашиглах боломжтой болгох.
- **Өгөгдлийн засаглалын тухай хууль (DGA):** Өгөгдөл дамжуулагчид болон өгөгдөл хуваалцахыг дэмжих "өгөгдлийн альтруизм"-д зориулсан дүрмийг бий болгох.
- **Өгөгдлийн тухай хууль:** Холбогдсон төхөөрөмжүүдээс үүсгэсэн өгөгдөлд хандах, ашиглахтай холбоотой эрх, үүргийг тодорхойлох.

**ЭСТОНИ УЛС:** БНЭсУ нь “Дижитал үндэстэн” хэмээн нэрлэгддэг дэлхийн тэргүүлэгч орны нэг бөгөөд 1991 онд тусгаар тогтнолоо сэргээснээс хойш цахим засаглалын тогтолцоог бүрэн төлөвшүүлсэн юм. Ердөө 1.3 сая хүн амтай хэдий ч улс төрийн тодорхой зорилт, хүсэл эрмэлзлийн үр дүнд төрийн үйлчилгээг богино хугацаанд цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн аюулгүй солилцоог хангах X-Road платформ болон нээлттэй өгөгдлийн соёлыг амжилттай хөгжүүлсэн. Эстонийн загвар нь “Дижитал бүрэн эрх”-ийг эрхэмлэж, төрийн мэдээлэл, үйлчилгээг тасралтгүй, тасалдалгүй ажиллагаатай байлгах (гадаадад байршуулсан “өгөгдлийн элчин сайдын яам”-аар дамжуулан ч хэрэгжих боломжтой) нөхцөлийг бүрдүүлж, иргэн төвтэй, саадгүй цахим хэрэглээг дэмждэгээрээ онцлог юм. Эстони улсын өгөгдлийн засаглалын гол онцлогууд нь:

- **Дижитал нийгэм:** Эстони нь дэвшилтэт дижитал нийгэм, цахим засаглалын санаачилгаараа алдартай.
- **Ил тод байдал:** Эстони нь өгөгдлийг нээлттэй, хязгаарлагдмал, нууц гэсэн ангилалд хуваасан өгөгдлийн ил тод хууль эрх зүйн орчинтой. Гол хууль тогтоомжид Нийтийн мэдээллийн тухай хууль орно.
- **Өгөгдлийн бие даасан байдал:** Эстони нь өгөгдлийн бүрэн эрхт байдлыг нэн тэргүүнд тавьж, кибер халдлага, бусад тасалдал гарсан ч өгөгдөл, үйлчилгээ нь хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг. Үүнд бусад улс орнууд дахь өгөгдлийн Элчин сайдын яамд багтана.
- **Хил дамнасан өгөгдлийн урсгал:** Европын холбооны гишүүний хувьд Эстони улс өгөгдлийг хил дамнан дамжуулахад GDPR-ийг дагаж мөрддөг.
- **Нээлттэй өгөгдөл:** Эстони улс нээлттэй өгөгдлийг идэвхтэй дэмжиж, иргэдийг өөрсдийн өгөгдөлд нэвтрэх боломжоор хангадаг.

*Хүснэгт 8. Эстонийн өгөгдлийн бодлогын үр дүнг, үзүүлэлтийн зарим жишээ*

№	Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	Үр дүн
1	Дижитал Засгийн газрын төлөвшил	Цахим оршин суугчийн бүртгэл	Ойролцоогоор 70,000 гаруй цахим оршин суугчид дэлхий даяар бүртгэлтэй (хамгийн сүүлийн үеийн мэдээгээр), олон улсын дижитал бизнес эрхлэлтийг хөнгөвчилж байна.

		Дижитал үйлчилгээний хэрэглээ	Төрийн үйлчилгээг бараг 100 хувь онлайнгаар ашиглах боломжтой нь иргэдийн харилцааг хялбаршуулж байна.
		Дижитал ID хэрэглээ	Баталгаажуулалт, дижитал гарын үсэг зурахын тулд дижитал ID-г өргөнөөр ашиглаж байна.
2	Мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал	GDPR-ын дагаж мөрдөлт, нууцлалын индекс	Эстони нь Европын Холбооны нууцлал, мэдээлэл хамгааллын стандартуудад өндөр байр суурь эзэлдэг бөгөөд итгэлийн хүчтэй түвшнийг хадгалж байна.
		Кибер аюулгүй байдлын хэмжүүр	Кибер халдлагын тохиолдол харьцангуй бага байдаг. Эстони нь Европын холбооны кибер аюулгүй байдлыг тэргүүлэгч гэж тооцогддог.
3	Инновац ба Дижитал эдийн засаг	Дижитал эдийн засгийн хувь нэмэр	Дижитал үйлчилгээ, цахим худалдаа, засгийн газрын онлайн үйл ажиллагаагаар ДНБ-ий чухал хэсгийг бүрдүүлж байна.
		Блокчэйн нэвтрүүлэлт	Эстони нь эрүүл мэнд, хууль, санхүүгийн салбарт блокчэйн технологийг нэвтрүүлж, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг сайжруулсан.

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ):** Дижитал дэд бүтэц, технологийн хэрэглээний өндөр чадавхаараа дэлхийн дижитал эдийн засгийн тэргүүлэгч орнуудын нэг болсон. Хэдий тийм ч өгөгдлийн бодлогын түүхэн хөгжлийн хувьд тус улс нь хувийн нууцын хамгаалалтыг онцгойлон эрхэмлэж ирсэн бөгөөд дижитал эдийн засгийн өсөлт, өгөгдлийн бүрэн эрхийг хадгалах шаардлагын хоорондын тэнцвэрийг эрэлхийлэх стратеги баримталсаар ирсэн. Түүхэн хөгжлийн явцад БНСУ нь өгөгдөл дотооддоо хадгалах хатуу шаардлага тавьдаг байсан ч сүүлийн жилүүдэд зохицуулалтаа уян хатан болгож, инновацыг дэмжих чиглэлд шилжжээ. Тодруулбал, нэр нь нууцлагдсан өгөгдлийг судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглахыг зөвшөөрөх, хил дамнасан өгөгдөл дамжуулах дүрмийг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээг авснаар өгөгдлийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж байна.

БНСУ-ын туршлага нь олон улсын GDPR зэрэг жишгийг дотоод нөхцөлдөө аажмаар нийцүүлэн нутагшуулах, хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хадгалах замаар инновацын хөгжлийг хаахгүй байх, мөн өгөгдөл, хиймэл оюунд суурилсан үйлчилгээний өсөлтийг зохицуулалтын шинэчлэлээр хөшүүрэглэх стратегийн ач холбогдлыг харуулж байна. Монгол Улс хиймэл оюуны хөгжилд анхаарч буй энэ үед, БНСУ-ын энэхүү тэнцвэртэй, үе шаттай хандлага нь бодлого боловсруулахад үнэтэй сургамж болох юм. Өмнөд Солонгосын өгөгдлийн засаглалын гол онцлогууд нь:

- **Ухаалаг зохицуулалт:** Өмнөд Солонгос нь хуурамч өгөгдлийг ашиглах, хил дамнасан өгөгдөл дамжуулахад хязгаарлалтыг багасгах замаар өгөгдөл хамгаалах, инновацыг тэнцвэржүүлэх "ухаалаг зохицуулалт"-ын арга барилыг баримталдаг.
- **Хувийн мэдээллийн хамгаалах тухай хууль (PIPA):** Өгөгдөл хамгаалах гол хууль болох PIPA нь аюулгүй байдлын арга хэмжээ, хэрэглэгчийн зөвшөөрлийг онцолдог.
- **Өвөрмөц таних өгөгдөл:** Өмнөд Солонгос улс тусгай хамгаалалт шаарддаг "Өвөрмөц таних өгөгдөл"-ийн тусгай ангилалтай.
- **Нээлттэй өгөгдөл ба өгөгдлийн альтруизм:** Өмнөд Солонгос нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн олон нийтэд зориулсан өгөгдөлд нээлттэй хандахыг дэмжиж, нийтийн ашиг тусын төлөө өгөгдөл хуваалцахыг дэмжих "өгөгдлийн альтруизм"-ийн санаачилгыг ашигладаг.
- **Үндэсний өгөгдлийн нэгтгэл, удирдлага:** Жишээлбэл, өгөгдлийг холбох замаар хиймэл оюун ухааны алгоритмын хөгжил.

*Хүснэгт 9.БНСУ-ын өгөгдлийн бодлогын үр дүнг, үзүүлэлтийн зарим жишээ*

№	Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	Үр дүн
1	Дижитал Засгийн газар ба платформ төлөвшил	Цахим засаглалын хөгжлийн индекс	Өмнөд Солонгос дэлхийн шилдэг орнуудын тоонд тогтмол ордог. Жишээлбэл, 2022 оны НҮБ-ын Цахим засгийн газрын судалгаанд 1-р байранд орсон.
		Дижитал хандалтын хүртээмжтэй байдал	Интернэтийн нэвтрэлт 96 хувиас дээш байгаа нь цахим үйлчилгээнд өргөн хүрээтэй хандах боломжийг баталгаажуулж байна.
		Ухаалаг хот ба дижитал платформын нэвтрүүлэлт	Их өгөгдөл, IoT ашиглан ухаалаг хотын шийдлүүдийг өргөнөөр хэрэгжүүлж байна.
2	Мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал	Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль (PIPA)	Хууль эрх зүйн хүчтэй тогтолцоо нь GDPR-тай төстэй, нийцтэй байдлын өндөр түвшинтэй.
		Кибер халдлагад хариу өгөх	Кибер аюулын эсрэг үндэсний хүчин чармайлтыг зохицуулан шуурхай хариу арга хэмжээ авдаг.
		Кибер аюулгүй байдлын баталгаа	Кибер аюулгүй байдлын дэвшилтэт чадавх, уян хатан байдал, халдлагад хариу өгөх дундаж хугацааг багасгасан; Солонгос улс KISA (Солонгосын интернэт ба аюулгүй байдлын агентлаг)

			зэрэг тусгай байгууллагуудыг байгуулсан.
3	Өгөгдлийн ашиглалт ба инновац	Их өгөгдөл ба хиймэл оюунд оруулсан хөрөнгө оруулалт	Солонгос улс хиймэл оюун, их өгөгдөл, дижитал эрүүл мэндийн салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд санхүү, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдал зэрэг салбаруудад хэмжигдэхүйц сайжруулалт хийж байна.
		Дижитал эдийн засгийн өсөлт	ДНБ-д өгөгдөлд суурилсан үйлчилгээний хувь нэмрийг нэмэгдүүлэх, өгөгдөл хуваалцах, стандартчиллыг дэмжих бодлоготой.

**СИНГАПУР УЛС:** Сингапур улс нь Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн дата төвийн гол зангилаа болон төлөвшсөн, дэлхийн бизнесийн чухал төвүүдийн нэг юм. Газар нутгийн хэмжээний хувьд жижиг улс боловч тогтвортой засаглал, эрх зүйн сахилга баттай орчин, өндөр хурдны дэд бүтцээрээ давуу талыг бүрдүүлж, 2020 оны байдлаар 70 гаруй дата төвтэй болсон. Сингапурын өгөгдлийн бодлого, зохицуулалтын хандлага нь “зөөлөн боловч үр дүнтэй” зарчимд тулгуурладаг. Энэ нь нэг талаас суурь хамгаалалт, итгэлцлийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, нөгөө талаас инновац, өгөгдлийн идэвхтэй хэрэглээг хязгаарлахгүй байхад чиглэдэг.

Сингапурын онцлог нь өгөгдлийн зохицуулалтыг хатуу хуульчлахаас илүүтэй хамтран зохицуулалт, удирдамж, салбар хоорондын зөвлөмжүүдийн үндсэн дээр хэрэгжүүлдэг явдал юм. Энэ нь төр ба хувийн хэвшлийн хоорондын итгэлцэл, уян хатан ажиллагааг хангадаг. Хот-муж улсын хувьд Сингапурын Засгийн газар нь дата дэд бүтцийн төлөвлөлтөд шууд оролцож, стратегийн газар олголт, бодлогын урамшууллаар салбарын өсөлтийг удирдан чиглүүлдэг. Түүнчлэн сүүлийн жилүүдэд тус улс дата төвүүдийн байгаль орчны нөлөөг бууруулах, эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөгжлийг хангахад илүү анхаарах болсон нь Сингапурын дата бодлогын чиг хандлага байгаль орчинтой уялдсан шинэ шатанд гарч буйг илтгэнэ. Сингапур улсын өгөгдлийн засаглалын гол онцлогууд нь:

- **Бүс нутгийн төв:** Сингапур нь АСЕАН бүс нутагт өгөгдлийн төв болон өөрийгөө бий болгосон.
- **"Зөөлөн гэвч үр дүнтэй" арга барил:** Сингапурын өгөгдлийн засаглалын арга барилыг итгэлд суурилсан системтэй инновацыг тэнцвэржүүлж "зөөлөн гэвч үр дүнтэй" гэж тодорхойлдог.
- **Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (PDPA):** PDPA нь Хувийн Мэдээлэл Хамгаалах Комисс (PDPC)-оор дамжуулан хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулах дүрмийг тогтоодог.

- **Өгөгдөл зөөвөрлөх:** Өгөгдөл хуваалцах, хил дамнасан өгөгдлийн урсгалыг дэмжих, Сингапур хэрэглэгчид болон бизнесүүдийн хооронд өгөгдөл хуваалцах арга замыг хөгжүүлж байна.

Хүснэгт 10. Сингапурын өгөгдлийн бодлогын үр дүнг, үзүүлэлтийн зарим жишээ

№	Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	Үр дүн
1	Дижитал Засгийн газар ба үйлчилгээний төлөвшил	Цахим засаглалын хөгжлийн индекс	Дэлхийн шилдэг орнуудын тоонд орсон, жишээлбэл, 2022 оны НҮБ-ын Цахим засгийн газрын судалгаанд 2-р байранд орсон.
		Дижитал үйлчилгээний нэвтрүүлэлт	Засгийн газрын үйлчилгээний 80 гаруй хувь нь онлайнаар ашиглах боломжтой, иргэдийн сэтгэл ханамжийн өндөр түвшинтэй байна.
		Ухаалаг үндэстний санаачилга	Ухаалаг хотын мэдрэгч, цахим төлбөр, дижитал ID системийг өргөнөөр нэвтрүүлсэн.
2	Мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал	Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль (PDPA)	Хууль эрх зүйн хүчтэй тогтолцоо нь нийцтэй хэрэгжиж, байнга хянагдаж, шинэчлэгддэг.
		Кибер аюулгүй байдлын бэлэн байдал	Кибер аюулгүй байдлын бат бөх арга хэмжээнүүдээрээ хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд Кибер аюулгүй байдлын агентлаг удирдаж байна.
		Тохиолдолд хариу өгөх ба уян хатан байдал	Томоохон зөрчлүүдийн тохиолдол бага, сэргээх чадвар хурдан.
3	Өгөгдлийн ашиглалт ба эдийн засгийн нөлөөлөл	Өгөгдөл солилцох ба инновац	Төрийн болон хувийн хэвшлийн хооронд өгөгдөл солилцохыг идэвхтэй дэмжиж, инновац, шинэ үйлчилгээг хөгжүүлж байна.
		Хиймэл оюун ба өгөгдлийн шинжилгээг нэвтрүүлэх	Нийтийн эрүүл мэнд, хот төлөвлөлт, санхүүгийн салбарт өргөнөөр ашиглаж байгаа нь үр ашгийг дээшлүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулж байна.
		Дижитал эдийн засгийн хувь нэмэр	ДНБ-д финтек, эрүүл мэндийн технологи, логистик зэрэг өгөгдөлд

			суурилсан салбарууд томоохон хувь хэмжээг эзэлж байна.
--	--	--	--

Хүснэгт 11. Олон улсын өгөгдлийн хууль, эрх зүй, бодлого зохицуулалтын харьцуулсан судалгаа

Улсын нэр	Хууль, эрх зүйн орчин	Өгөгдлийн стандарт, шаардлага	Өгөгдөл нэгтгэх технологи, дэд бүтэц	Өгөгдлийн аюулгүй байдал	Хүний нөөцийн чадавх
<b>Европын холбоо</b>	Өгөгдлийн засаглалын хууль, Өгөгдөл хамгаалах ерөнхий журам (GDPR), Нээлттэй өгөгдөл болон нийтийн мэдээллийн дахин ашиглах тогтоол, Европын холбооны өгөгдлийн стратеги	Дундын төв нь өгөгдлийн бүх удирдлагыг хийх бөгөөд европын өгөгдлийн стандартыг давхар мөрдөнө.	Дундын төв байгуулагдаж замаар дэд бүтцийг бий болгоно. Мөн шаардлагатай технологийн судалгаанд хөрөнгө оруулалт хийдэг байна.	Өгөгдөл хамгаалах ерөнхий журам болон бусад хууль эрх зүйн хүрээнд өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.	Өгөгдлийн чадвар олгох, иргэдээ хувийн мэдээллээ хамгаалах, захиран зарцуулах чадвар олгох ажлуудад хөрөнгө оруулалт хийх замаар хүний нөөцөө бэлдэнэ гэсэн байна.
<b>Эстони</b>	1990-ээд оны сүүлээс эхлэн цахим засаглалын суурь хууль эрхзүйн орчныг бүрдүүлсэн. Хувийн мэдээллийн хамгааллын хууль, Улсын мэдээллийн сангуудын тухай хууль, Кибер аюулгүй байдлын хууль	Дижитал нийгмийн санаачилгыг эхлүүлснээр дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн.	Байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх дундын тооцоолох төв ашиглах	Байгууллага бүр өгөгдлийн аюулгүй байдлаа хангана.	Дэд бүтэц болон хүний нөөцийн сургалтад хөрөнгө оруулалт хийнэ.
<b>БНСУ</b>	Нээлттэй өгөгдлийн хууль, Өгөгдөл хамгаалах хууль, Хувийн мэдээллийг хамгаалах хууль (Personal Information	Өгөгдөл бүрт стандарт боловсруулан мөрдүүлсээр ирсэн, PIPA	Нэгдсэн платформ үүсгэх замаар дэд бүтцийг бий болгосон	Хууль, стандартын хүрээнд байгууллага бүр хангаж ажилладаг	Өгөгдлийн чадваруудыг тодорхойлж бүх түвшний сургалтын байгууллагаар өгөгдлийн чадвар олгох сургалт

	Protection Act, PIPA)				явуулахад дэмжлэг үзүүлнэ.
<b>Сингапур</b>	Public Sector (Governance) Act, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (Personal Data Protection Act, PDPA)	Хууль эрх зүйн хүчтэй тогтолцоо нь нийцтэй хэрэгжиж, байнга хянагдаж, шинэчлэгддэг.	Өгөгдөл авах, боловсруулах платформ бий болгох	Төрийн бүх байгууллага мөрдөх өгөгдлийн аюулгүй байдлын стандарт бий болгох	Өгөгдлийн удирдлагын оффис төрийн албан хаагчдад зориулсан сургалт хийх туслалцааг үзүүлнэ.

### 6.3. Улс орны өгөгдлийн ангиллын тогтолцоо

**ЕВРОПЫН ХОЛБОО** нь хувийн мэдээллийг GDPR-ийн хүрээнд өргөн хүрээтэй тодорхойлж, үүн дотроос эмзэг мэдээллийг (жишээлбэл, үндэс угсаа, арьсны өнгө, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, эрүүл мэнд, биометр гэх мэт) өндөр хамгаалалт шаардсан тусгай ангилалд хамааруулдаг. Эдгээр мэдээллийг зөвхөн тодорхой нөхцөл, зөвшөөрлийн дагуу боловсруулахыг зөвшөөрдөг<sup>6</sup>.

Мөн ЕХ болон гишүүн орнууд нь төрийн мэдээллийг аюулгүй байдлын түвшнээр нь шатлалтайгаар ангилдаг. ЕХ-ны байгууллагууд “EU Classified Information” (EUCI) нэртэй дөрвөн түвшний нууцлалын ангилал (Онц чухал нууц, Маш нууц, Нууц, Хязгаарлагдмал) ашигладаг бөгөөд тухайн мэдээллийг задруулах нь учруулж болзошгүй хохирлын түвшнээр хэмжигддэг<sup>7</sup>. Харин ангилагдаагүй мэдээлэл нь хуулиар хориглоогүй бол нийтэд нээлттэй байх зарчимтай.

Энэхүү тогтолцоо нь олон нийтэд нээлттэй мэдээлэл, дотоод/хязгаарлагдмал ашиглалтад хамаарах өгөгдөл, түүнчлэн нууцын зэрэглэлтэй мэдээллийг түвшин бүрээр нь ялган ангилж, тухайн мэдээллийн эмзэг байдлын зэрэгт тохирсон хамгаалалтын арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлдэг.

**ЭСТОНИ УЛС** мэдээллийг олон нийтэд нээлттэй, хязгаарлагдмал, нууц зэрэглэлтэй гэж тодорхой түвшинд ангилан, хууль эрх зүйн зохицуулалтаар нарийвчлан зохицуулдаг.

<sup>6</sup> Европын парламент ба Европын холбооны зөвлөл. (2016). *Европын парламент болон зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн (ЕХ) 2016/679 журам — Хувийн өгөгдлийг боловсруулахтай холбоотой хувь хүний хамгаалал болон эдгээр өгөгдлийг чөлөөтэй шилжүүлэх тухай (Өгөгдөл хамгаалах ерөнхий журам)*

<sup>7</sup> Европын парламент ба Европын холбооны зөвлөл. (2018). *Европын парламент болон зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн (ЕХ) 2018/1807 журам — Европын Холбооны хүрээнд хувийн шинжгүй өгөгдлийн чөлөөтэй урсгалын үндсэн зохицуулалт.*

Энэхүү ангилал нь ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал, хувийн нууцын хамгааллыг тэнцвэртэй хангах замаар өгөгдлийн засаглалын тогтолцоог бүрдүүлдэг.

1. Нээлттэй мэдээлэл: “Олон нийтийн мэдээллийн тухай хууль” нь төрийн байгууллагын мэдэлд буй мэдээллийг ил тод, идэвхтэй нийтлэхийг хуульчилсан. Тухайлбал статистик, төсөв, судалгаа, хууль тогтоомжийн төсөл, төрийн албан хаагчийн цалин зэрэг олон мэдээллийг иргэдэд нээлттэй болгодог. Эстони Улс нээлттэй өгөгдлийн үзүүлэлтээр ЕХ-нд тэргүүлдэг бөгөөд өгөгдлийг вэбсайт болон төвлөрсөн өгөгдлийн порталуудаар түгээдэг.
2. Хязгаарлагдмал мэдээлэл: Нээлттэй биш боловч төрийн нууцад хамаарахгүй мэдээллийг “дотоод хэрэглээнд” хэмээн ангилдаг. Үүнд мөрдөн байцаалт, захиргааны хяналт, гадаад харилцаанд сөрөг нөлөөтэй мэдээлэл, хувь хүний хувийн мэдээлэл зэрэг багтана. Энэ мэдээллийг байгууллагын түвшинд зохих үндэслэлээр ангилж, гуравдагч этгээдтэй гэрээний үндсэн дээр хуваалцах боломжтой. Зарим тохиолдолд 5–75 жилийн хугацаанд хадгалагдана.
1. Төрийн нууц: “Төрийн нууц болон гадаад улсын нууц мэдээллийн тухай хууль”-аар мэдээллийг НАТО, ЕХ-ны жишгээр Хязгаарлагдмал, Нууцалсан, Нууц, Онц чухал нууц гэсэн дөрвөн түвшинд ангилна. Үүнд тагнуул, батлан хамгаалах, олон улсын тагнуулын хамтын ажиллагааны мэдээлэл хамаардаг ба эдгээр мэдээлэлд зөвшөөрөлгүй хандвал эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.
2. Хувийн мэдээлэл: Эстони улс GDPR-ийг үндэсний хуульд бүрэн шингээсэн бөгөөд Өгөгдөл хамгаалах газар хувийн болон эмзэг мэдээллийг хамгаалах үүргийг хариуцан хэрэгжүүлдэг. Хувийн мэдээлэл нь нууц ангилалд багтахгүй ч тусгай хамгаалалттай тооцогддог. Төрийн баримт бичигт багтсан хувийн мэдээллийг дотоод хэрэглээний ангилалд хамааруулан 75 жил хүртэлх хугацаанд нууцалж хадгалах зохицуулалттай.

**БНСУ** өгөгдлийн ангиллын тогтолцоо нь олон түвшний нарийвчилсан бүтэцтэй бөгөөд мэдээллийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэн зохицуулалт хийх боломжийг бүрдүүлдэг. Хувийн мэдээллийн хамгаалалтад чиглэсэн суурь хууль болох “Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль” (PIPA) нь хувийн мэдээллийг ердийн, эмзэг, шууд таних боломжтой мэдээлэл гэсэн гурван үндсэн ангилалд хуваадаг. Энэ нь Европын холбооны GDPR-тэй нийцтэй бөгөөд иргэний бүртгэлийн дугаар зэрэг өндөр эрсдэлтэй мэдээлэлд тусгай хязгаарлалт тогтоодог. Тус хуульд 2020 онд орсон нэмэлтээр “нэршлийг нууцалсан өгөгдөл” гэсэн шинэ ангиллыг тусгаж, уг өгөгдлийг зөвшөөрөлгүйгээр тодорхой нөхцөлд (жишээлбэл, судалгаа ба хөгжүүлэлт, хиймэл оюун сургалт) ашиглахыг зөвшөөрсөн нь өгөгдлийн хоёрдогч хэрэглээг дэмжих, инновацад суурь бүрдүүлэх оновчтой зохицуулалт болжээ.

БНСУ төрийн мэдээллийн ангиллыг тусгай хуулиар зохицуулдаг бөгөөд үндэсний аюулгүй байдал, цэргийн мэдээлэл, бодлогын баримт бичиг зэрэг мэдээллийг хамгаалалтын зэрэглэлээр ангилдаг. Үүний зэрэгцээ, “Албан ёсны мэдээллийг олон нийтэд

мэдээлэх тухай хууль"-ийн хүрээнд төрийн ихэнх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах зарчмыг баримталж, иргэдийн мэдээлэлд хандах эрхийг баталгаажуулдаг. Энэ зохицуулалт нь мэдээллийн ил тод байдал, төрийн хариуцлагын тогтолцоог хангахын зэрэгцээ үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тэнцвэртэй эрх зүйн орчныг бүрдүүлдэг.

Нийтийн, нээлттэй өгөгдлийн талаарх зохицуулалт нь тус улсын мэдээллийн бодлогын стратегийн нэг тулгуур болсон. “Нийтийн өгөгдөл ба идэвхжүүлэх тухай хууль”-иар төрийн байгууллагууд өгөгдлөө үнэ төлбөргүй, олон нийтэд нээлттэй хэлбэрээр түгээх үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд нээлттэй болон нээлттэй бус өгөгдлийг ялган ангилж, төрийн өгөгдлийг эдийн засгийн хөгжлийн нөөц болгон үзэж, олон төрлийн хэрэглээнд (инновац, гарааны бизнес, нийтийн үйлчилгээ) үр ашигтай ашиглаж байна.

Мөн БНСУ нь салбарын онцлогт нийцсэн өгөгдлийн ангиллын зохицуулалт боловсруулж, нарийвчилсан хандлагыг төлөвшүүлжээ. Жишээлбэл, санхүү, эрүүл мэндийн салбар тус бүр өөрийн өгөгдлийг хариуцлагатай, зөвшөөрөлд суурилсан зарчмаар ашиглах зохицуулалттай. Тухайлбал, “MyData” хэмээх шинэчлэлээр дамжуулан иргэн өөрийн санхүүгийн мэдээллийг зөвшөөрөлтэйгөөр хуваалцаж, хувийн үйлчилгээ авах боломжтой болсон нь өгөгдлийг иргэний мэдэлд байлгах, уян хатан хэрэглээг дэмжих хандлагыг илэрхийлж байна.

Энэхүү нарийвчилсан ангиллын тогтолцоо нь өгөгдөлд суурилсан инновац, ил тод байдал, хүний эрхийн хамгаалал хоорондын зохистой тэнцвэрийг хангах бодлогын ухаалаг загвар бөгөөд Монгол Улс өгөгдлийн зохицуулалтыг хөгжүүлж буй энэ үед БНСУ-ын туршлага нь оновчтой жишиг болох боломжтой юм.

**СИНГАПУР УЛС** төрийн болон хувийн хэвшлийн өгөгдлийн ангилал, хамгаалалтыг логик, эрсдэлийн үнэлгээнд суурилсан нарийн тогтолцоогоор зохицуулдаг. Төрийн мэдээллийг ангилахдаа Их Британийн эрх зүйн уламжлалаас улбаалан үндэсний болон байгууллагын ашиг сонирхолд учирч болох хохирлын хэмжээнд тулгуурладаг шаталсан системийг хэрэглэдэг. Төрийн мэдээллийг “Нээлттэй”, “Мэдрэмжтэй”, “Нууц”, “Маш нууц” гэх түвшинд хуваан, нууцлалын түвшинд тохирсон хандалт, хамгаалалтын дэглэмийг хэрэгжүүлдэг. Төрийн байгууллагуудын хүрээнд нэгдсэн ангилал, уялдаа бий болгохын тулд 2018 онд “Мэдээллийн эмзэг байдлын тогтолцоо” (ISF)-г нэвтрүүлсэн нь хувь хүн болон байгууллагад учирч болох хор хохирлоос хамааран мэдээллийг ангилж, хамгаалах арга хэмжээ (жишээлбэл, шифрлэлт, хандалтын хяналт) тодорхойлоход чиглэдэг. Мэдээллийг хамгаалах энэ тогтолцоо нь хуульчлан тогтоосон иргэний эрхийн зарчимд бус, төрийн байгууллагын дотоод бодлого, дүрэм журмаар хэрэгждэг боловч, зөрчигдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага тооцох замаар эрх зүйн баталгааг хангадаг.

Харин хувийн хэвшлийн өгөгдлийг зохицуулах үндсэн баримт бичиг болох Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (PDPA) нь бүх төрлийн хувийн мэдээлэлд нийтлэг стандарт үйлчлэх зарчмыг баримталдаг. Хэдийгээр “эмзэг хувийн мэдээлэл” гэх тодорхой заалт хуульд байхгүй ч, зохицуулагч байгууллага болох PDPC байгууллагуудад эрсдэлд суурилсан ангиллын систем хэрэглэхийг зөвлөсөн байдаг. Үүний үр дүнд олон байгууллага өгөгдлөө “Нийтэд нээлттэй”, “Дотоод”, “Нууц”, “Маш нууц” зэрэг олон улсын түгээмэл

шатлалаар ангилан ашигладаг. Түүнчлэн зарим мэдээлэлд жишээлбэл, иргэний үнэмлэхийн дугаар зэрэгт тусгайлсан удирдамжийг хэрэгжүүлдэг бөгөөд зайлшгүй шаардлагагүй тохиолдолд ийм мэдээллийг цуглуулахыг хориглосон эрх зүйн зохицуулалт ч бий.

Сүүлийн үеийн нэг онцлох өөрчлөлт бол өгөгдөл зөөвөрлөх үүрэг бөгөөд энэ нь тодорхой төрлийн хувийн мэдээллийг тухайн иргэний хүсэлтээр өөр байгууллагад дамжуулах нөхцөлийг хуульчилсан шинэ хандлагын бий болгосон. Энэ хүрээнд мэдээллийг “зөөвөрлөх боломжтой өгөгдөл” гэх шинэ төрлийн ангилалд хамруулж, зохих хамгаалалт, шилжүүлэлтийн журам тогтоох шаардлагатай болсон байна.

Мөн төрийн болон хувийн байгууллагуудын өгөгдлийг нээлттэй болон өмчийн хэлбэрээр ялгаж, нийтэд хуваалцах боломжтой өгөгдлийг нэрийг нууцалсан буюу бүлэглэсэн байдлаар нээлттэй болгодог зарчмыг баримталдаг. Харин үндэсний аюулгүй байдал, хувийн нууцад хамаарах өгөгдөл нь дотоод хэрэглээнд хязгаарлагдана. Энэ ялгаа нь зөвшөөрлийн түвшин, хандалтын эрхтэй уялдсан хандлагын дагуу хэрэгждэг. Жишээлбэл, “Нууц” зэрэглэлтэй албан хаагч нь “Нууц” болон түүнээс доош түвшний мэдээлэлд хандах эрхтэй боловч “Маш нууц” мэдээлэлд хандах боломжгүй.

Нэмж дурдахад, салбар тус бүрийн тусгай хууль тогтоомж нь мэдээллийн ангилал, хамгаалалтын түвшнийг тодорхойлдог. Жишээлбэл, банкны мэдээлэлд Банкны нууцын тухай хууль, эрүүл мэндийн мэдээлэлд Эмнэлгийн нууцын журмаар зохицуулалт хийгддэг. Харин мэдээллийн дэд бүтэцтэй холбоотойгоор, 2018 онд батлагдсан Кибер аюулгүй байдлын тухай хууль нь Чухал мэдээллийн дэд бүтцийн (CII) өгөгдөлд илүү өндөр түвшний хамгаалалт шаарддаг.

#### **6.4. Улс орны хил дамнасан өгөгдлийн бодлого, өгөгдөлд хандах зохицуулалт**

**ЕВРОПЫН ХОЛБОО** нь өгөгдлийн чөлөөт урсгалыг хангах үүднээс хувийн болон хувийн шинжгүй өгөгдлийг ялган зохицуулж, гишүүн орнууд хооронд болон гуравдагч орнууд руу мэдээлэл шилжүүлэх үйл явцыг эрх зүйн нэгдсэн үндэслэлтэйгээр зохицуулдаг.

##### **Өгөгдлийн чөлөөт урсгал:**

- GDPR-ийн дагуу хувийн мэдээлэл нь ЕХ дотор чөлөөтэй шилжих боломжтой бөгөөд гишүүн орнуудын хооронд байршлын шаардлагагүйгээр солилцдог.
- Хувийн шинжгүй өгөгдлийн тухай журам нь өгөгдлийг заавал тодорхой улсад хадгалах шаардлагыг (data localization) халж, ЕХ-ны нутаг дэвсгэрт чөлөөтэй дамжуулах, хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн<sup>8</sup>.

##### **Гуравдагч орон руу өгөгдөл шилжүүлэх зохицуулалт:**

- Зөвшөөрөгдсөн улсуудын жагсаалт (Adequacy Decisions)-д багтсан орнууд руу мэдээлэл нэмэлт хамгаалалтгүйгээр чөлөөтэй шилждэг.

<sup>8</sup> Европын Комисс. (2019). 2019/1024 тоот удирдамж — Нээлттэй өгөгдөл ба төрийн байгууллагын мэдээллийг дахин ашиглах тухай

- Стандарт гэрээний заалт (SCCs), дотоод журам (BCRs) зэрэг хамгаалалтын эрх зүйн механизм нь зөвшөөрөгдөөгүй улс руу шилжүүлэхэд шаардлагатай.
- Онцгой тохиолдолд тодорхой нөхцөлд үндэслэн хязгаарлагдмал хэлбэрээр шилжүүлэг хийхийг зөвшөөрдөг.

#### **Нээлттэй өгөгдлийн бодлого:**

- Нээлттэй өгөгдлийн тухай журам нь төрийн байгууллагын эмзэг бус өгөгдлийг олон нийтэд нээлттэй, дахин ашиглах боломжтой хэлбэрээр нийтлэхийг шаарддаг<sup>9</sup>.
- data.europa.eu зэрэг платформуудаар дамжуулан төрийн өгөгдөлд хандах боломжийг хангаж, инновац ба иргэний оролцоог дэмждэг.

#### **Хуваалцсан ба хязгаарлагдмал өгөгдөл:**

- Бүх төрлийн өгөгдөл нээлттэй биш бөгөөд дотоод хэрэглээнд зориулагдсан, хязгаарлагдмал өгөгдөл тусгай зөвшөөрөлтэй этгээдэд хуваалцагддаг.
- Өгөгдлийн засаглалын тухай хууль нь төрийн болон хувийн өгөгдлийг итгэмжлэгдсэн өгөгдлийн зуучлагчаар дамжуулан хуваалцах эрх зүйн орчныг бүрдүүлж байна<sup>10</sup>.

#### **Хувийн мэдээлэл ба хандалтын эрх:**

- GDPR нь хувь хүнд өөрийн өгөгдөлд хандах эрхийг баталгаажуулж, байгууллагуудад ил тод байдлыг хангах үүрэг оноодог. Хэрэв байгууллагууд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд торгууль, хяналтын арга хэмжээ ногдуулах зохицуулалттай.
- Нууц мэдээлэл нь тусгай хамгаалалттай байх бөгөөд ихэнх тохиолдолд дата төвүүдийн ердийн үйл ажиллагаанд хамааралгүй байдаг ч аюулгүй байдлын өндөр шаардлагыг хангасан нөхцөлд хадгалагддаг.

**ЭСТОНИ** нь ЕХ-ны гишүүн орны хувьд хувийн мэдээллийг хил дамжуулан дамжуулахад GDPR-ийн шаардлагыг бүрэн дагаж мөрддөг. Европын эдийн засгийн бүсийн хүрээнд хувийн мэдээлэл чөлөөтэй урсаж болох бөгөөд үүнээс гадуур мэдээлэл дамжуулахад “хангалттай байдлын шийдвэр” эсвэл зохих хамгаалалтын арга хэмжээ шаардагддаг. Ингэснээр Эстони олон улсын өгөгдлийн урсгалаас эдийн засгийн хувьд үр шим хүртдэг. Эстони улс Люксембургт өндөр хамгаалалт бүхий дата төвийг бүрэн эрхийн статустайгаар байгуулж, стратегийн өгөгдлийг хадгалах замаар өгөгдлийн бүрэн эрхийг хангах арга хэмжээ авсан. Энэ шийдэл нь улс орнуудын дижитал тогтвортой байдал, гамшгийн үед өгөгдлийг хамгаалах талаар урт хугацааны стратегийн бодлого боловсруулах боломжтойг харуулж байна.

Үүнээс гадна, цахим оршин суугчдын хөтөлбөрөөр дамжуулан гадаадын гарааны бизнесүүдийг дэмждэг бөгөөд өгөгдөл заавал дотооддоо хадгалахыг шаарддаггүй. “Газар

<sup>9</sup> Европын Комисс. (2022). 2022/868 тоот журам — Европын өгөгдлийн засаглалын тухай хууль (Data Governance Act)

<sup>10</sup> Европын Холбооны Зөвлөл. (он мэдэгдэхгүй). Нууц мэдээлэл

зүйн байршлаар бус, технологиор хамгаалах” зарчмыг баримталдаг нь ил тод, нээлттэй, олон улсын итгэлийг хүлээсэн орчныг бүрдүүлсэн байна.

Хил дамнасан өгөгдөл солилцооны дэд бүтцийн хувьд, X-Road дэд бүтцээр дамжуулан Эстони нь Финляндтай өгөгдөл солилцох боломж бүрдүүлсэн ба төрийн үйлчилгээг хоёр улсын иргэд хоорондоо хялбар авах нөхцөлийг бүрдүүлсэн. Эдгээр технологийн шийдэл нь GDPR болон хоёр талын хэлэлцээрт суурилсан найдвартай платформ дээр үндэслэдэг.

#### **Өгөгдөлд хандах зохицуулалт ба ил тод байдал:**

- “Нэг л удаа өгөх” зарчим: Иргэн нэг мэдээллээ төрд нэг л удаа өгөх бөгөөд төрийн байгууллагууд энэ өгөгдлийг дотроо хуваалцах эрхтэй.
- *Иргэн өгөгдлийн эзэн*: eesti.ee порталын тусламжтайгаар иргэд хэн, хэзээ, ямар мэдээлэлд хандсаныг хянах боломжтой. Энэ нь өгөгдөлд хяналттай хандалт, итгэлцлийг нэмэгдүүлдэг.

#### **Мэдээллийн шаталсан хамгаалалт:**

- Нээлттэй мэдээлэл: Иргэдэд зориулсан нээлттэй өгөгдлийн порталаар дамжуулан хүрдэг.
- Хязгаарлагдмал мэдээлэл: Дотоод хэрэглээнд хязгаарлагдаж, тодорхой хугацааны дараа нээлттэй болдог.
- Төрийн нууц: Онц чухал мэдээлэл нь тусдаа шифрлэгдсэн системд хадгалагдаж, өндөр хамгаалалттай байдаг.

Эстонийн өгөгдлийн бодлого нь ил тод байдал, хариуцлага, технологид суурилсан уян хатан байдалд тулгуурладаг. Мэдээллийг “хамтын баялаг” хэмээн үздэг соёл, төр-хувийн хэвшлийн хамтарсан гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлсэн.

**БНСУ** нь Мэдээллийн урсгал ба хандалтын бодлогын хувьд олон улсын чиг хандлага, үндэсний аюулгүй байдал, хувийн нууц хамгааллын тэнцвэрийг стратегийн түвшинд шийдвэрлэж буй туршлагатай улс юм. Өмнө нь хатуу хяналт бүхий зохицуулалтаар гадаад руу өгөгдөл шилжүүлэх бүрд хэрэглэгчийн зөвшөөрлийг заавал шаардаж байсан бол сүүлийн жилүүдэд хууль, бодлогоо үе шаттайгаар шинэчилж, илүү уян хатан, эрсдэлд суурилсан арга барил руу шилжжээ. Энэ хүрээнд “цагаан жагсаалт”-ын тогтолцоог нэвтрүүлж, Европын Холбооны “нийцлийн” зарчмыг өөрийн нөхцөлд тохируулан хэрэглэж байна. Мөн Ази–Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны хил дамнасан нууцлалын тогтолцоо (CBPR)-нд нэгдсэн нь бүс нутгийн түвшний мэдээллийн урсгалыг хөнгөвчилсөн. Ийнхүү гадагш чиглэсэн өгөгдөлд зориулсан зохицуулалтын шинэчлэл нь олон улсын бизнес, технологийн хамтын ажиллагааг дэмжиж, үүлэн үйлчилгээ, хиймэл оюун зэрэг салбарын хөгжилд түлхэц өгч байгаа юм.

Нөгөө талаар, өгөгдөлд хандах эрх, хуваалцах механизмын хүрээнд БНСУ төрийн өгөгдлийг олон нийтэд ил тод байлгахын тулд төрийн байгууллагуудын мэдээллийг портал болон API-ээр нээлттэй болгох, өгөгдөл гаргах үүргийг хуульчилжээ. Хувийн мэдээллийн хуваалцах боломжийг “нэргүй болгосон өгөгдөл”-ийн зохицуулалтаар дэмжиж, хяналттай, зорилтот хэрэглээний хүрээнд байгууллагууд хооронд солилцох эрх зүйн суурийг

бүрдүүлсэн. Төрийн байгууллагуудын хоорондын өгөгдөл солилцоог хөнгөвчлөх цахим платформыг төвлөрсөн байдлаар ажиллуулж, өгөгдлийн урсгалыг дэмжихийн зэрэгцээ хариуцлагын механизмыг боловсронгуй болгожээ.

Эдгээр бодлогын нийтлэг онцлог нь ил тод байдал, иргэний хяналт, бизнесийн дэмжлэг, аюулгүй байдлын зохистой тэнцвэрийг стратегийн түвшинд уялдуулсан явдал бөгөөд энэ нь Монгол Улсад өгөгдлийн бодлогыг боловсронгуй болгох, олон улсын мэдээллийн экосистемд хариуцлагатай, үр ашигтайгаар нэгтгэгдэхэд чухал сургамж өгч байна.

**СИНГАПУР УЛС** мэдээллийн урсгал болон өгөгдөлд хандах бодлогын хүрээнд нээлттэй, уян хатан хандлага баримталж, хил дамнасан өгөгдлийн шилжилтийг дэмжих эрх зүйн зохицуулалт болон байгууллагын зохион байгуулалтыг төлөвшүүлснээр дэлхийн дижитал төв болохыг зорьж байна. Өгөгдлийг дотооддоо хадгалах хатуу шаардлага тавьдаггүй бөгөөд харин хувийн мэдээллийг гадаад руу шилжүүлэхдээ зохих хамгаалалттай байж чадах эсэхийг баталгаажуулах үүргийг байгууллагуудад хүлээлгэдэг. Үүнийг гэрээний нөхцөл, дотоод дүрэм, зарим тохиолдолд хувь хүний зөвшөөрлөөр хангах боломжтой боловч Сингапурын зохицуулагч байгууллага (PDPC) нь гэрээний баталгааг илүүд үздэг.

Мөн Сингапур улс нь Ази–Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны хил дамнасан нууцлалын дүрэм болон Дэлхийн хил дамнасан нууцлалын дүрмийн форумд идэвхтэй оролцсоноор олон улсын зохицуулалтын тогтолцоонд итгэж байгааг харуулдаг. Гадаадаас орж ирж буй өгөгдөлд бараг хязгаарлалтгүй ханддаг бол, гадагш чиглэсэн хувийн өгөгдлийн хувьд шаардлагатай эрсдэлийн үнэлгээ, гэрээний нөхцөл, хамгаалалтын арга хэмжээг урьдчилан бүрдүүлэх үүргийг онцолжээ. Энэ нь нутаг дэвсгэрт бус, харин өгөгдлийн хамгаалалтын үр дүнд суурилсан хандлага юм.

Сингапур улс нь дотоод өгөгдөлд хандах, хуваалцах зохион байгуулалтыг төрийн бодлогын түвшинд системтэй хөгжүүлсэн. data.gov.sg нээлттэй өгөгдлийн платформоор дамжуулан олон байгууллагын мэдээллийг нийтэлдэг бөгөөд “олж болохуйц, ойлгож болохуйц, ашиглаж болохуйц” байдлаар өгөгдлийг түгээх зорилт тавьсан. Нээлттэй өгөгдөл нь ил тод байдлыг нэмэгдүүлэхийн сацуу инновац, шинэлэг үйлчилгээ хөгжүүлэх суурь болж байна.

Харин төрийн бүх өгөгдөл нийтэд нээлттэй байдаггүй. Эмзэг болон нууц мэдээлэл нь хязгаарлагдмал хандалттай бөгөөд зөвхөн төрийн байгууллагуудын хооронд хяналттайгаар хуваалцах боломжтой байдаг. Үүнийг Төрийн өгөгдлийн архитектур тогтолцоогоор зохицуулдаг бөгөөд Үнэн мэдээллийн ганц эх сурвалж (SSOT), итгэмжлэгдсэн төв зэрэг институтийн механизм ашиглан өгөгдлийн давхардал, алдагдал, хамгаалалтгүй байдал зэргийг бууруулж, бодлого боловсруулахад зориулсан нэргүй өгөгдлийн хуваарилалтыг зохион байгуулдаг.

Сингапур нь төр, хувийн хэвшлийн өгөгдөл хуваалцахыг ч дэмждэг. Нийтийн тээвэр, эрүүл мэнд зэрэг салбарт эмзэг өгөгдөлд хяналттай орчноор дамжуулан хандуулах замаар судалгаа, шинжилгээнд ашиглах боломжийг олгодог. Үүний зэрэгцээ хувь хүн өөрийн

мэдээлэлд хандах, засварлах эрхтэй бөгөөд байгууллагууд энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ PDPA-ийн удирдамжийг баримтлах үүрэгтэй.

Төрийн мэдээллийн хамгаалалт нь Төрийн нууцын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд төрийн байгууллагууд хооронд мэдээлэл хуваалцахдаа тодорхойлсон ангилал, журмыг дагах үүрэгтэй. Зарим мэдээлэл нэгдсэн байдлаар нийтэд нээлттэй байж болох ч, анхдагч өгөгдөлд хандах хүсэлт зөвшөөрөгдөхгүй нөхцөлтэйгөөр хязгаарлагддаг.

## **6.5. Улс орны өгөгдлийн чиглэлийн байгууллагын бүтэц, хуулийн хэрэгжилт**

**ЕВРОПЫН ХОЛБОО**-ны өгөгдөл хамгаалалтын тогтолцоо нь олон түвшний зохицуулалт, хяналтын бүтэцтэй байдаг. Хувийн мэдээллийг хамгаалах байгууллагууд (DPAs) нь GDPR-ийн хэрэгжилтийг гишүүн орнууд бүрд хариуцдаг бөгөөд Европын Өгөгдөл Хамгаалах Зөвлөл (EDPB) нь нийтлэг заавар, хамтын шийдвэр гаргах төв байгууллага юм. ЕХ-ны хэмжээнд European Data Protection Supervisor (EDPS) нь институтийн хэрэгжилтийг хариуцна.

“Нэг цэгийн зохицуулалт” (One-Stop-Shop) механизмаар дамжуулан олон улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд үндсэн нэг зохицуулагч байгууллагатай харилцаж, хялбаршуулсан уялдаа холбоотой хяналтын тогтолцоог хэрэгжүүлдэг.

Европын Холбооны түвшний бодлого, зохицуулалтыг Европын Комиссын холбогдох ерөнхий газрууд хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр нь өгөгдөл хамгаалалт, өгөгдөлд суурилсан эдийн засгийн бодлого, олон улсын өгөгдөл дамжуулалт зэрэг өргөн хүрээний асуудлыг хамруулан хариуцдаг. Нээлттэй өгөгдлийн зохицуулалтаар нийтлэг удирдамж баталж, хэрэгжилтийг гишүүн орнууд хариуцахын зэрэгцээ Европын өгөгдлийн портал болон өгөгдлийн багцын ангиллаар нэгдмэл зохицуулалт бий болгосон.

Хууль сахиулах механизмын хүрээнд үндэсний өгөгдөл хамгаалах байгууллагууд (DPA) нь зөрчил гаргасан байгууллагад өндөр дүнтэй торгууль ногдуулах, үйл ажиллагааг зогсоох, хууль бусаар цуглуулсан өгөгдлийг устгах зэрэг арга хэмжээ авах эрхтэй. Харин Европын Холбооны Шүүх нь холбогдох хуулийн заалтуудыг албан ёсоор тайлбарлан баталгаажуулах үүрэгтэй. Төрийн нууц мэдээлэлтэй холбоотойгоор эрүүгийн болон захиргааны хяналт зэрэгцэн үйлчилж, ажилтнуудын нэвтрэх эрхийг цуцлах зэрэг сахилгын арга хэмжээ давхар хэрэгждэг.

Европын Холбоо нь хуульд заасан шаардлага буюу нийцэл хангах үйл ажиллагааг дэмжих зорилгоор зөвлөгөө, удирдамж, аргачлал санал болгодог. Энэ хүрээнд GDPR болон холбогдох хууль тогтоомж нь өгөгдлийн салбарт өндөр нийцэл, өрсөлдөх чадвар, тогтвортой байдлыг хослуулсан орчныг бүрдүүлж, байгууллагууд хуульд нийцэхийн тулд дотоод зохион байгуулалт, чадавхдаа бодитой хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болдог.

**ЭСТОНИ**-ийн цахим засаглалын амжилт нь төвлөрсөн, уялдаа сайтай институтийн зохион байгуулалт дээр үндэслэдэг. Эдийн засаг, харилцаа холбооны яам нь төрийн мэдээлэл, цахим бодлогыг тодорхойлж, стратеги, стандартын удирдамжийг төрийн ерөнхий мэдээллийн алба хариуцдаг. Харин мэдээллийн системийн газар (ria) нь техникийн зохицуулалт болон x-road систем, кибер аюулгүй байдлын ажиллагааг хариуцан хэрэгжүүлдэг. Цахим засаглалын зөвлөл нь яамд хоорондын уялдааг хангах, салбар дамнасан зохицуулалт хийх төв байгууллагаар ажилладаг бөгөөд эдгээр нь im8 хүрээний

дагуу өгөгдлийн удирдлагын нэгдсэн бодлого, стандартын хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдүүлдэг.

Хувийн мэдээллийн хамгаалалтад бие даасан, үндэсний төвшний байгууллага болох өгөгдөл хамгаалах газар (dpi) нь gdpr-ийн хэрэгжилт, хууль зөрчсөн этгээдэд хяналт, торгууль ногдуулах эрхтэй. Dpi нь зөрчил шалгах, шүүхэд хандуулах, мөн олон нийтэд зориулсан мэдээлэл, тайлан, сургалт зэргээр нөлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлдэг бөгөөд ех-ны зохицуулалтад оролцогч үндэсний төлөөлөгчийн хувиар ажилладаг.

Хууль сахиулах механизм нь дотоодын итгэлцэл, хариуцлага, нээлттэй байдлын соёлтой уялдсан байдгаараа онцлог юм. Dpi нь мэдээлэл алдагдах, хууль бус ашиглалтын зөрчлийг торгох эрхтэй бөгөөд бодит байдал дээр торгуулийн хэмжээ бага боловч хэрэгжилт өндөр байдаг. Иргэд мэдээлэлдээ хяналт тавих, алдаатай мэдээллийг засуулах, шинэчлэх эрхээ шуурхай хэрэгжүүлдэг тогтолцоо төлөвшсөн. Мөн төрийн байгууллага мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсан тохиолдолд иргэн шүүхэд хандаж, хууль ёсоор мэдээлэл авах эрхээ хамгаалж чаддаг нь шүүх эрх мэдлийн хяналт бодитоор хэрэгжиж буйн илрэл юм.

Төрийн нууц мэдээллийн хэрэгжилтийг дотоодын аюулгүй байдлын алба (каро) хариуцдаг. Зөрчил илэрсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, шүүхээр шийдвэрлэх хүртэл арга хэмжээ авдаг. Кибер аюулгүй байдал нь зөвхөн халдлагаас хамгаалах бус, системийн тасралтгүй ажиллагааг хангах, урьдчилан сэргийлэх зарчимд суурилдаг. RIA нь мэдээллийн системд хяналт тавьж, стандарт, хуульд нийцлийг үнэлэх эрхтэй бөгөөд эстонид 2017 оноос төрийн сүлжээг тасралтгүй хянах тогтолцоог нэвтрүүлсэн.

Эстони улс дотоод хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй тайлагнах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх “зөөлөн хяналт”-ын хэлбэрийг идэвхтэй хэрэгжүүлдэг. Өгөгдөл хамгаалах газар нь тайлан, удирдамж, сургалт зохион байгуулж, засгийн газар мэдээлэл авах хүсэлтийн статистик мэдээллийг сайн дурын үндсэн дээр нийтэлдэг нь хариуцлагын соёлыг төлөвшүүлэхэд түлхэц болдог.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд эстони улс цахим засаглалын ноу-хаугаа хуваалцаж, e-governance academy, ех болон нато-ийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцдог. Энэ нь эстонийг олон улсын бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй, хүндтэй оролцогч болгож, өөрийн туршлагыг экспортлох, олон улсын зохицуулалтад нөлөө үзүүлэх чадамжийг нэмэгдүүлдэг. Эстонийн туршлагаас харахад институтийн уялдаа, төр-хувийн түншлэл, ил тод байдал, хүний эрхэд суурилсан хяналтын тогтолцоо нь амжилттай өгөгдлийн бодлогын тулгуур хүчин зүйлс болохыг харуулж байна.

**БНСУ** нь Мэдээлэл хамгаалалтын бодлогын хэрэгжилтийн институтийн зохион байгуулалт, хариуцлагын механизмын хувьд олон улсын жишигт нийцсэн, өндөр хариуцлагатай, уян хатан бүтэц бүхий загварыг бүрдүүлжээ. Эхэндээ мэдээллийн хамгаалалтын чиг үүргийг олон байгууллага хуваан гүйцэтгэж байсан ч 2020 оны хуулийн шинэчлэлээр бүх эрх мэдлийг төвлөрүүлж, Хувийн мэдээллийн хамгаалалтын хороо (PIPC)-г бие даасан төв зохицуулагч байгууллага болгон байгуулсан. PIPC нь удирдамж гаргах, хяналт шалгалт хийх, зөрчилд торгууль ногдуулах, цаашлаад эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрхтэй бөгөөд салбарын зохицуулагчидтай уялдаа холбоотой хамтран ажилладаг. Тус байгууллага нь Европын холбооны DPA-тай харьцуулахуйц чиг үүрэг бүхий байгууллага болж, технологийн компаниудад хүлээлгэх хариуцлагын механизмын үр нөлөөг хангаж байна.

Мөн салбарын онцлогт нийцүүлсэн зохицуулалтыг холбогдох байгууллагууд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа нь уян хатан байдлыг хадгалах чухал нөхцөл болж байна. Жишээлбэл, санхүүгийн салбарт FSC болон Санхүүгийн хяналтын алба, кибер аюулгүй байдлын чиглэлд KISA зэрэг байгууллагууд өгөгдөл хамгаалалттай холбоотой тусгай үүрэг гүйцэтгэж байна. Зохицуулалтын байгууллагууд хоорондын уялдааг хамтарсан шалгалт, харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хангаж байгаа нь институтийн уялдаа холбоог бэхжүүлж байна.

Төрийн мэдээллийн бодлого болон цахим засаглалыг дэмжих зохицуулалтыг Дотоод хэргийн яам, Мэдээллийн Нийгэмлэгийн Агентлаг зэрэг байгууллагууд хэрэгжүүлж, төрийн нээлттэй өгөгдөл, мэдээлэл солилцооны тогтолцоог хөгжүүлжээ. “Төрийн байгууллагын засаглалын тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлт нь байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн үндсийг бүрдүүлж, төрийн мэдээллийг үр ашигтай ашиглах боломжийг нэмэгдүүлсэн.

Зөрчил гарсан тохиолдолд PIPC, KISA, цагдаагийн байгууллага зэрэг холбогдох байгууллагууд хамтран ажиллаж, хариу арга хэмжээ авч байгаа нь хэрэгжилтийн уялдаа, хариуцлагын бодит механизмыг баталгаажуулдаг. Тухайлбал, зөрчилтэй холбоотой орлогыг үндэслэн торгууль ногдуулах шинэ аргачлалыг нэвтрүүлсэн нь илүү шударга бөгөөд пропорциональ хандлагыг хэрэгжүүлж байгааг харуулж байна. Мөн төрийн мэдээллийг хууль бусаар ашигласан албан хаагчид эрүүгийн хариуцлага хүлээж буй бодит жишээнүүд нь эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт амьдралд бодитоор хэрэгжиж буйг илтгэнэ.

БНСУ-ын өгөгдөл хамгаалалтын бодлого нь зөвхөн хууль тогтоомж төдийгүй хэрэглэгчийн оролцоог дэмжих механизм, олон улсын хамтын ажиллагаа, итгэлцэл дээр суурилсан бөгөөд Европын GDPR-тэй агуулгын хувьд дүйцэхүйц, зарим талаараа илүү шийдэмгий агуулга бүхий тогтолцоо болж хөгжсөн. PIPC нь олон улсын түвшинд ч идэвхтэй хамтарч ажилладаг бөгөөд БНСУ нь дэлхийн стандарттай нийцсэн, өгөгдөл хамгаалалтын найдвартай орчин бүрдүүлсэн гэж гадаадын хөрөнгө оруулагчид үнэлэх үндэс бий.

**СИНГАПУР** нь Мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдал болон өгөгдөлд суурилсан бодлогын хэрэгжилтийн чиглэлээр өндөр уялдаатай, нэгдмэл зохион байгуулалт бүхий институтийн тогтолцоог хөгжүүлсэн байдаг. Энэхүү загвар нь төрийн байгууллагуудын уялдаа, хувийн хэвшилтэй хамтын ажиллагаа, олон улсын стандарттай нийцсэн зохицуулалт, уян хатан хэрэгжилт дээр тулгуурладаг.

Сингапурын хувийн мэдээлэл хамгаалалтын бодлогыг Хувийн Мэдээлэл Хамгаалах Комисс (PDPC) хариуцдаг бөгөөд уг байгууллага нь зөвхөн хуулийн хэрэгжилт бус, инновац болон хиймэл оюуны зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлж, мэдээлэл хамгаалах ба хөгжлийг хослуулсан хандлагыг төлөвшүүлжээ. PDPC нь зөвлөмж, загвар баримт бичиг, урьдчилан сэргийлэх сургалт зэргээр дэмжлэг үзүүлж, зөрчилд нээлттэй бус, харин хамтран ажиллагч түншийн байр суурьтайгаар бизнесийн итгэлийг бий болгож чадсан. Гэсэн ч хариуцлага алдсан, ноцтой зөрчил гаргасан тохиолдолд торгууль ногдуулах механизм нь илүү хүчтэй хэрэгждэг бөгөөд саяхан батлагдсан хуулийн нэмэлт өөрчлөлтөөр торгуулийн дээд хэмжээг жилийн орлогын 10 хувьд хүргэсэн нь олон улсын компаниудад илүү үр дүнтэй нөлөө үзүүлэх зорилготой байв.

Кибер аюулгүй байдлын хувьд, улсын хэмжээнд онц чухал дэд бүтцийн хамгаалалтыг хариуцсан Кибер аюулгүй байдлын агентлаг нь PDPC-тай нягт уялдаа

холбоотой ажилладаг. SingHealth-ийн мэдээллийн алдагдлын жишээн дээр эдгээр байгууллагууд хэрхэн зэрэгцэн ажиллаж, техникийн болон бодлогын түвшний арга хэмжээг зэрэг авч хэрэгжүүлсэн нь ил тод харагддаг. Мөн Ерөнхий сайдын дэргэдэх Ухаалаг үндэстэн ба Дижитал Засгийн газрын алба (SNDGO) нь төрийн байгууллагуудын өгөгдлийн стратегийг чиглүүлэн уялдуулж, GovTech-тай хамтран төрийн мэдээллийн аюулгүй байдлын стандартыг тодорхойлдог. “Засгийн газрын өгөгдлийн аюулгүй байдлын бодлого”, “Өгөгдлийн засаглалын хороо” зэрэг механизм нь төрийн мэдээлэл хамгааллыг системчилсэн байдлаар хэрэгжүүлэх үндэс суурь болж байна.

Сингапурын хувьд өгөгдлийн бодлого нь дотоод зохицуулалтаас гадна олон улсын чиг хандлагатай нягт уялдаатай. Тус улс нь Ази–Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны хил дамнасан нууцлалын тогтолцоо (CBPR)-нд идэвхтэй оролцож, Дэлхийн худалдааны байгууллагын цахим худалдааны хэлэлцээ зэрэг олон улсын хэлэлцүүлгийг манлайлан оролцдог. Мөн PDPC нь гадаадын ижил төрлийн агентлагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хуулийн хэрэгжилтийн туршлага солилцох замаар хилийн чанад дахь эрх зүйн нийцлийг хөнгөвчилдөг. Энэ нь Сингапурт бизнес эрхлэгчдэд хамаарах олон улсын зохицуулалтын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах давуу тал болж байна.

Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг хөнгөн зөрчлийн үед торгуулиар бус анхааруулга, зөвлөмжөөр шийдэх, харин ноцтой зөрчлийг өндөр торгууль, түр зогсоох зэрэг хатуу арга хэмжээгээр шийдвэрлэх зарчим баримталдаг. Үүнтэй зэрэгцэн “нэг цонхны” цахим платформ, мэдээлэл хамгаалах хурал, сургалт семинар зэрэг бодит дэмжлэг үзүүлэх механизм нь хэрэгжилтийг илүү хүртээмжтэй болгож, байгууллагуудын сайн дурын нийцлийг дэмждэг.

Улсын хэмжээнд өгөгдлийн зохицуулалтын тогтолцоо нь стратеги төлөвлөлт (дээд түвшинд), бодлогын уялдуулалт (уялдуулагч агентлагуудаар дамжуулан), хэрэгжилт (салбарын агентлагуудад), хяналт-шинжилгээ, сургамж (хороо, зөвлөлдөх уулзалтын тогтолцоогоор дамжуулан) гэсэн шатлалтайгаар зохион байгуулагддаг. Энэ нь хүн ам цөөн, төвлөрсөн удирдлагатай Монгол Улсад ч уялдаатай, олон талын оролцоотой зохицуулалтын тогтолцоо бүрдүүлэх боломжтойг харуулж байна.

## **6.6. Улс орны дата төвийн бодлого, урамшуулал**

### **Дэлхийн дата төвийн тойм**

2026 оны 2 дугаар сарын байдлаар дэлхий даяар нийт 10,807 дата төв байна. Үүнээс 28% нь Enterprise дата төв, 36% нь Colocation дата төв, 37% нь Hyperscale дата төв байна. Нийт дата төвийн 6,050 буюу 51,3% нь Америк тивд, 2,773 буюу 23,5% нь Европ тивд, 1508 буюу 12,8% нь Ази номхон далайн бүсэд байна.



Зураг 2. Key Hyperscaler буюу дэлхийн томоохон hyperscale cloud үйлчилгээ үзүүлэгчид, Colocation Leaders буюу colocation дата төвийн зах зээлийн тэргүүлэгч компаниуд



Эх сурвалж: Structure Research Global Colocation & Interconnection Market Share Report 2025

Дата төвийн салбар үүссэн цагаасаа үүлэн тооцооллын эрэлт, интернэтэд холбогдсон төхөөрөмжүүдийн хэрэглээ өргөжихийн хирээр үсрэнгүй өсөж ирсэн. Хиймэл оюуны (AI) хэрэглээний өсөлтөөс хамаарсан дата төвийн салбарын дараагийн том өсөлт нь илүү их эрчим хүчний хангамжийг шаардаж байна.

- 2027 онд өгөгдөл хадгалах хэмжээ 21 ZB (2023: 10.1 ZB)
- Хадгалалтын жилийн дундаж өсөлт +18.5%
- Хиймэл оюуны шинэ дата төвийн эрчим хүчний хэрэгцээ 100+, 300+ MW

Дэлхийн хэмжээнд нийт өгөгдлийн хэмжээ 2020 онд 64 зеттабайт байсан бол 2024 онд 149 зеттабайтад хүрсэн бөгөөд 2028 онд дэлхий даяар үүсгэгдэж, хадгалагдаж буй өгөгдлийн хэмжээ 394 зеттабайтад хүрэх төлөвтэй байна. Энэ нь өгөгдөл хадгалах, боловсруулах эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, дэлхий даяар асар том дата төвүүдийг барихад хүргэсэн.




Хиймэл оюун болон үүлэн тооцооллоос үүдсэн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж, зөвхөн АНУ-д гэхэд 2030 он гэхэд энэ эрэлт гурав дахин өсөх төлөвтэй байна.

## Эрчим хүчний үр ашиг: хамгийн бага эрчим хүчний индекс (pue)

IDC-ийн тооцоолсноор дэлхий даяар өгөгдлийн төвүүдийн эрчим хүчний хэрэглээ 2023 онд 352 ТВтц байсан бөгөөд жилд 19.5% өсөх хандлагатай байгаа тул 2028 он гэхэд 857Т Втц хүрэх төлөвтэй байна.

Зураг 3. Дэлхийн дата төвүүдийн эрчим хүчний хэрэглээний өсөлт.

Global data center colocation market size by country in primary, secondary and emerging markets (in MW of built-out critical IT load capacity)



### Тэргүүлэгч зах зээл:

- Хамгийн багадаа 600 МВт эрчим хүчний хангамж (одоо олонх нь 1,000 МВт давсан).
- Цаашид бүсийн Дата төвүүд болж, өсөлт үргэлжлэхээр байна.

### Хоёрдогч зах зээл:

- Ихэвчлэн 100-600 МВт эрчим хүчний хангамж
- Өрсөлдөөн багатай, хөрөнгө оруулагчид, зээл олгогчид болон бизнес хөгжүүлэгчид анхаарлын төвд ороод байна.


### Шинээр хөгжиж буй зах зээл:

- Дата төвүүдийг хэрэглэгчдэд ойртуулах, тухайлбал, үндэсний бүрэн эрхт байдлыг хамгаалах хууль тогтоомжоор тухайн улс дотроо өгөгдлөө хадгалах шаардлага тавигдсанаар Edge нэвтрүүлэлт нэмэгдсээр байна.

Зураг 4. Дэлхийн дата төвийн колокейшн (colocation) зах зээлийн хэмжээ бүс нутгаар хэрхэн өсөж байгааг харуулсан.

### Global Data Centre Colocation Market Size by Region

in megawatts of operational critical IT load capacity (historical and projected)




Source: Structure Research 2024 Global Data Centre Colocation & Interconnection Market Share Report

Зураг 5. Дэлхийн дата төвийн колокейшн (colocation) зах зээлийн хэмжээг бүс нутгаар харуулсан.


### Global Data Centre Colocation Market Size by Region

in megawatts of operational critical IT load capacity (historical and projected)




Source: Structure Research 2024 Global Data Centre Colocation & Interconnection Market Share Report

Зураг 6. Хиймэл оюун болон уламжлалт дата төвийн эзлэх хувь



Зураг 7. Сэргээгдэх эрчим хүчний хангамж ба 2030 оны зорилт



Дата төвүүдийг ажиллуулахад шаардагдах цахилгааны ~30%-ийг нүүрс, сэргээгдэх эрчим хүчний нар, салхи, усан цахилгаан станцууд нийлээд 27%-ийг хангаж байна.

**ЕВРОПЫН ХОЛБОО** нь дата төвүүдийг хөгжүүлэх талаар нэгдсэн татварын урамшууллын бодлого баримталдаггүй ч, гишүүн орнууд үндэсний болон бүс нутгийн түвшинд төрөл бүрийн дэмжлэг, урамшуулал санал болгодог. Үүнд:

- Татварын хөнгөлөлт (жишээлбэл, цахилгааны татвар хураамж, аж ахуйн нэгжийн татварын доод хувь);
- Дэд бүтцийн давуу байршил (хүйтэн уур амьсгал, сэргээгдэх эрчим хүч, өндөр хурдны интернэт сүлжээ);
- Газар олголт, зөвшөөрөл олгох үйл явцыг хялбаршуулах;
- “Ногоон” дата төвийн тогтвортой байдлыг урамшуулах схем (байгальд ээлтэй стандартад нийцсэн байгууллагуудад нэр хүнд ба тендерт оролцох давуу эрх олгох).

Европын Холбооны түвшинд:

- Хууль эрх зүйн зохицуулалтаар дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл, "Хувийн шинжгүй өгөгдлийн чөлөөт урсгалын журам" нь дата байршуулалтын шаардлагыг халж, гишүүн орнуудын хооронд өгөгдлийг чөлөөтэй шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Сэндбокс туршилтын зохицуулалт (шинэ технологийг зохицуулагчийн хяналт дор турших уян хатан орчин) болон GAIA-X зэрэг санаачилга нь үүлэн дэд бүтцэд итгэлцлийг нэмэгдүүлж, дата төвийн хөгжлийг дэмждэг.
- Сэргэлт ба инновацын сангуудаар дамжуулан дижитал дэд бүтцэд (НРС, шилэн кабелийн холболт) хөрөнгө оруулалт хийж байна.

Европ нь өгөгдлийн өндөр хамгаалалт, нэгдсэн зах зээл дэх чөлөөт өгөгдлийн урсгал, дотоодын урамшуулал зэргийг хослуулснаар олон улсын компаниудыг дата төвөө байршуулахад таатай орчныг бүрдүүлдэг. Гэвч, нөгөө талаасаа шаардлагад нийцүүлэхтэй холбоотой зардал өндөр байдаг нь анхаарах асуудал юм.

**ЭСТОНИ УЛС** дата төвүүд болон дижитал бизнесийн хөгжлийг тусгай татаасаар бус, харин өргөн хүрээтэй, тогтвортой, бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогоор дэмждэг нь онцлог юм. Эдийн засгийн бодлогоор дамжуулан дижитал хөрөнгө оруулалтыг татах гол хөшүүрэг нь компанийн олсон ашгийг бизнесийн үйл ажиллагаандаа дахин ашиглах (өргөтгөх, шинэчлэх зэрэг) тохиолдолд татвар ногдуулдаггүй татварын тогтолцоо юм. Энэ нь дата төвүүдийн хувьд дэд бүтцэд урт хугацааны хөрөнгө оруулалт хийхэд урамшуулал болдог. Эстонид дата төвүүдэд зориулсан тусгай татварын хөнгөлөлт байхгүй ч, бага татварын орчин нь компанийн ашгийг эргэлтэд оруулахад нээлттэй боломж олгодог.

Цахим оршин суугчийн хөтөлбөр нь гаднын бизнес эрхлэгчдэд Эстонид алсын зайнаас бүртгүүлж, үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгодог бөгөөд энэ нь олон улсын дижитал бизнесүүдийг татах гол хүчин зүйл болсон. Эстонийн энэ загвар нь Монгол Улсад дижитал бизнес эрхлэгчдийг татах, дотоодын экосистемийг олон улсын урсгалтай холбох, дата төвийн үйл ажиллагааг хялбаршуулах бодлогын хувилбар болох боломжтой юм.

Дэд бүтцийн хувьд, Эстони өндөр хурдны интернэт, тогтвортой эрчим хүч, олон улсын холболт бүхий дэд бүтэцтэй бөгөөд төрийн стратегийн хөрөнгө оруулалтаар энэ суурь орчныг бүрдүүлсэн. Төр нь дата төвүүдийн үндсэн хэрэглэгч байх замаар шууд бус дэмжлэг үзүүлдэг нь хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлдэг.

Мөн Эстони мэдээллийн технологийн боловсролд эртнээс анхаарч, чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх дотоодын боловсролын систем, гадаадын авьяасыг татах уян хатан виз, шилжилтийн бодлогоор дамжуулан хүний нөөцийн орчныг өрсөлдөхүйц түвшинд хүргэсэн. Энэ нь дата төвүүд болон дижитал компаниудад ажиллах хүчний тогтвортой эх үүсвэрийг бий болгодог.

Зохицуулалтын орчны хувьд, Эстони инновацад суурилсан бодлогыг дэмжиж, сэндбокс зохицуулалтын туршилтын орчин бий болгосон нь финтек болон технологийн гарааны бизнесийн шинэ санаачилгыг бодитоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Энэ нь дата төвийн шинэ шийдлийг туршихад уян хатан, дэмжлэгтэй нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Сэргээгдэх эрчим хүчний урамшууллын хөтөлбөр нь одоогоор дата төвд шууд чиглээгүй ч, ногоон дата төвийн хөрөнгө оруулалтыг дэмжих ерөнхий бодлого хэрэгжиж байгаа нь цаашид Европын Холбооны чиг хандлагын хүрээнд өргөжих хүлээлттэй байна.

Эстонийн жишээ нь дата төв болон дижитал бизнесийн хөгжлийг татварын хөнгөлөлтөөс давсан, ил тод, тогтвортой зохицуулалт, дижитал ур чадварын суурь, инновацийн уян хатан орчин зэрэг цогц бодлогоор урамшуулах боломжтойг харуулж байна. Монгол Улс эдгээр жишигт тулгуурлан дижитал эдийн засгийн суурийг бүрдүүлэх, дата төвийн хөгжлийг дэмжихдээ зөвхөн түр зуурын татаас бус, харин системчилсэн, урт хугацааны стратеги боловсруулах шаардлагатай.

**БНСУ**-ын Мэдээллийн технологийн дэд бүтцийн стратегийн хөгжлийг эрчимжүүлж буй туршлага нь бодлого, зохицуулалт, урамшууллыг уялдуулан хэрэгжүүлж, дата төвүүд болон хиймэл оюун, үүлэн тооцооллын салбарын өсөлтийг дэмжих цогц загварыг бүрдүүлж байна. Тус улс “шинэ өсөлтийн технологи” ангилалд дата төв, үүлэн тооцооллыг багтааж, татварын хөнгөлөлтөөр дамжуулан эдгээр салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг урамшуулж байгаа бөгөөд 2023 оноос хойш хөрөнгө оруулалт, судалгаа, хөгжүүлэлтийн зардалд 20–30%-ийн татварын хөнгөлөлт үзүүлэх бодлого хэрэгжиж байна. Ийнхүү хувийн хэвшлийг дэмжсэн урамшууллыг Засгийн газрын түвшинд тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон нь бизнесийн идэвх, технологийн дэд бүтцийн өргөтгөлд нөлөөлж байна.

Хэт төвлөрлийг сааруулах зорилгоор орон нутгийг дата дэд бүтцийн гол бүсээр төлөвлөсөн нь нийслэлийн ачааллыг бууруулахын зэрэгцээ бүс нутгийн эдийн засгийн хөгжил, инновац, ажил эрхлэлтийг хөхиүлэн дэмжиж буй арга хэмжээ юм. Сөүлээс гадуур байрших дата төвүүдэд зориулсан цахилгаан холболтын зардлын хөнгөлөлт, өндөр хүчдэлийн сүлжээнд холбогдох зардлын бууралт зэрэг нь дэд бүтцийн бодит хэмнэлт авчирч, байршлын сонголтыг илүү стратегитай болгоход нөлөөлж байна. Энэхүү хандлага нь Монгол Улсад дата төвүүдийг зөвхөн нийслэлд төвлөрүүлэх бус, орон нутагт хуваарилж,

сэргээгдэх эрчим хүч, байгаль цаг уурын нөхцөлийг давуу тал болгон ашиглахад чиглэсэн бодлогын суурь загвар болж чадна.

Түүнчлэн, Чөлөөт эдийн засгийн бүсүүдээр дамжуулан гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр уян хатан урамшууллын нөхцөлийг бий болгосон нь БНСУ-ын өөр нэг онцлох туршлага юм. Эдгээр бүсэд гадаадын үүлэн үйлчилгээ үзүүлэгч компаниуд дата төв байршуулсан тохиолдолд татварын чөлөөлөлт, шууд мөнгөн дэмжлэг хүртэл авах боломжтой байдаг бөгөөд хэлэлцээрийн үндсэн дээр тохиолдол бүрд оновчтой нөхцөл тохирох механизмыг бүрдүүлжээ. Монгол Улс энэ жишээг анхаарч, бүс нутгийн урамшууллын тогтолцоог боловсруулснаар дата дэд бүтцийн гадаад хөрөнгө оруулалтыг илүү үр дүнтэй татах боломж бүрдэнэ.

Хүний нөөц, инновацын чадавхыг тасралтгүй бэхжүүлэх бодлого нь БНСУ-ын өгөгдөлд суурилсан эдийн засгийн хөгжлийн суурь тулгуур болоод байна. Техникийн ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх, хиймэл оюуны салбарын дата хангамжийг төрийн санхүүжилтээр бүрдүүлэх, гарааны бизнесүүдийг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлснээр өгөгдөл, хиймэл оюунд суурилсан хэрэглээний эрэлт өсөж, дата төвийн хэрэглээ дагаад нэмэгдэх нөхцөл бүрджээ. Энэхүү системтэй хандлага нь Монгол Улсад технологийн хүний нөөцийн төлөвлөлтийг дата төвийн хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагатайг харуулж байна.

Мөн сэндбокс зохицуулалтын орчныг идэвхтэй ашигласнаар шинэ технологийн туршилт, зохицуулалтын уян хатан байдлыг хослуулж, инновацын экосистемийг хурдасган хөгжүүлж байна. Энэ төрлийн механизм нь туршилтын үйлчилгээнд зохицуулалтын хөнгөлөлт үзүүлж, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан итгэлцлийг бүрдүүлдэг. Монгол Улс одоогоор санхүүгийн салбарт сэндбокс нэвтрүүлээд байгаа ч, технологийн салбар руу тэлэх боломж өндөр байгаа нь харагдаж байна.

Цаашлаад орон нутгийн засаг захиргааны зүгээс дата төв байршуулалтыг идэвхтэй дэмжиж, барилгын зөвшөөрөл, дэд бүтцийн холболтыг түргэвчлэх, газар хөнгөлөх зэрэг механизм нэвтрүүлж байгаа нь төв болон орон нутгийн бодлогын уялдааг хангах чухал туршлага болж байна.

Нөгөө талаас, дата төвүүдийн эрчим хүчний хэрэглээг бууруулах, тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлд БНСУ анхаарлаа хандуулж эхэлсэн. Эрчим хүчний үр ашигтай дата төвүүдэд үнэлгээ олгох, нүүрстөрөгчийн кредитийн системд хамруулах зэрэг механизм нь тогтвортой өгөгдлийн дэд бүтэц рүү шилжих эхлэл болж байна. Монгол Улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний нөөц боломжийг дата төвийн хөгжлийн хөшүүрэг болгон ашиглах нь уур амьсгалын зорилгод нийцсэн, хөрөнгө оруулагчдад сонирхолтой шийдэл байх боломжтой.

Ийнхүү БНСУ өгөгдлийн дэд бүтцийн байршил, урамшуулал, зохицуулалтын стратегийг уялдуулсан бодлого хэрэгжүүлснээр бүс нутгийн хөгжил, гадаад хөрөнгө оруулалт, технологийн инновацын хосолсон өсөлтийг хангаж байна. Монгол Улс энэхүү системтэй, уян хатан, стратегийн загвараас суралцаж, дотоод нөөц бололцоондоо

тохируулсан урамшууллын бодлого боловсруулах замаар “өгөгдөлд суурилсан хөгжил”-ийг хэрэгжүүлэх бодит боломжтой юм.

**СИНГАПУР**-ын дата төвийн бодлого сүүлийн жилүүдэд зөвхөн тоон өсөлтийг зорих хандлагаас тогтвортой, чанарт суурилсан хөгжил рүү стратегийн өөрчлөлт хийж, улс орны байршлын давуу тал, тогтвортой засаглал, бизнесийн ээлтэй орчныг үр дүнтэй уялдуулсан төлөвлөлтийн жишээ болж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар харьцангуй өндөр ч, томоохон хөрөнгө оруулагчдад зориулсан хөнгөлөлтийн багцуудаар дамжуулан татварыг мэдэгдэхүйц бууруулах боломжийг санал болгож, урамшууллыг ажлын байр бий болгох болон чадавх бэхжүүлэх нөхцөлтэй уялдуулдаг. Газар нутгийн хомс байдал, эрчим хүчний үнэ өндөр зэрэг хязгаарлалтыг засгийн газар стратегийн зохицуулалтаар нөхөж, дата төвүүдийг урт хугацаатай түрээсээр хангахын зэрэгцээ эрчим хүчний найдвартай хангамжийг баталгаажуулснаар хөрөнгө оруулалтад итгэл төрүүлдэг. Түүнчлэн дата төвүүдэд тавих экологийн шаардлагыг нарийвчилж, зөвхөн эрчим хүчний өндөр үр ашигтай, тогтвортой байдлыг хангасан шинэ байгууламжуудад зөвшөөрөл олгож буй нь шууд бус боловч чанарт суурилсан урамшууллын хэлбэр болж өгч байна.

Инновацийн түвшинд, Сингапурын төрөөс ногоон дата төвийн чиглэлээр хийгдэж буй судалгаа, технологийн шинэ шийдлүүдийг дэмжиж, хамтран хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, зөвшөөрлийг хялбаршуулах байдлаар оролцож байгаа нь хувийн хэвшлийн эрсдэлийг бууруулан хамтын хөгжлийг хөхиүлэн дэмжиж буй бодлого юм. Мөн хүний нөөцийн чиглэлээр гаднын мэргэжилтнүүдийг татах нөхцөлийг бүрдүүлж, дотоодын боловсон хүчнийг бэлтгэх, дахин сургах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй нь дата төвийн урт хугацааны хөгжлийг хангахад чиглэсэн цогц бодлогын нэг хэсэг болдог.

Сингапурын бизнесийн орчин нийтлэг журмаар ил тод, ойлгомжтой, хурдан шуурхай бөгөөд дата төвүүдэд зориулсан тусгай загварын барилга, зөвшөөрлийн хялбаршуулсан горим зэрэг нь бүтээн байгуулалтын хугацааг хурдасгаж, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн улс орны байршлын хувьд Зүүн Өмнөд Азийн стратегийн зах зээлд хялбар нэвтрэх боломжтой, улс төрийн тогтвортой байдал, оюуны өмчийн хамгаалалт зэрэг нь өөрөө чухал урамшуулал болж байна.

Иймд Сингапурын туршлага нь дата төвийн салбарт зөвхөн шууд татаасаар бус, стратегийн зохицуулалт, чанарт суурилсан бодлого, бизнес эрхлэх орчны тогтвортой байдлыг урамшуулал болгон ашиглаж болдгийг харуулж байна. Монгол Улс энэ туршлагаас сургамж авч, дата төвүүдийг татахын тулд татварын хөнгөлөлт, дэд бүтцийн хүртээмж, хүний нөөцийн хөгжлийн уялдаа бүхий бодлогын багцыг төлөвлөхөөс гадна, тогтвортой хөгжлийн зорилго, технологийн дэвшилд нийцсэн чиглэлийг давхар хэрэгжүүлэх шаардлагатай.

## VII. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дэлхий дахинд эрчимтэй өрнөж буй дижитал шилжилтийн нөлөөгөөр цаг, минут тутамд өгөгдөл үүсч, хадгалагдан, нийгэм эдийн засгийн бүхий л салбар өгөгдөл, мэдээллийн урсгал дунд үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү өгөгдөл, мэдээллийг шинжлэхэд шаардлагатай тооцооллын хүчин чадал хурдацтайгаар нэмэгдэж байгаа нь өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, цаашлаад эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, шинжлэх ухаан, технологийн инноваци шингээсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг үүсгэж, үүнтэй холбоотойгоор эдийн засгийн хүрээлэлд оролцогч талууд болох засгийн газрууд, олон улсын болон бизнесийн байгууллагууд өгөгдлийн бодлого, зохицуулалтад ихээхэн анхаарал хандуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 онд Цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг баталж, 2022 оны 5 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн нь өгөгдөлтэй холбоотой харилцааг зохицуулах суурь орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон. Эдгээр хуулиар өгөгдлийг цуглуулах, боловсруулах, дамжуулах, ашиглах, түүнчлэн мэдээллийн аюулгүй байдал, цахим үйлчилгээний үндсэн зарчим, шаардлагыг тодорхой хэмжээнд тусгасан боловч практик хэрэгжилтийн түвшинд, төрийн байгууллагуудын хооронд өгөгдөл солилцох, нэгтгэх, ашиглах, хадгалах үйл ажиллагаанд нэгдсэн бодлого, стандарт, зохицуулалт дутагдалтай, технологийн болон институцийн уялдаа хангалтгүй хэвээр байна.

Өгөгдлийн бодлого, зохицуулалтын хүрээнд тулгамдаж байгаа асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор ЦХИХХЯ-аас 2026 оны 03 дугаар сарын 23-наас 04 дүгээр сарын 25-ны хооронд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас судалгаа авч, дүн шинжилгээ хийхэд өгөгдөл солилцох, хуваалцах, ашиглах, дахин ашиглах харилцааны хууль эрх зүйн зохицуулалт дутмаг, төрийн байгууллагууд ижил төрлийн мэдээллийг давхардуулан цуглуулах, өгөгдлийг шинэчлэх давтамж зөрүүтэй, өгөгдлийн чанар болон стандартын асуудал хангалтгүй, өгөгдлийн засаглал ба хариуцлагын асуудал тодорхойгүй буюу өгөгдлийг амьдралын бүрэн мөчлөгөөр (үүсэх, цуглуулах, дамжуулах, хадгалах, ашиглах, архивлах, устгах) удирддаггүй, өгөгдлийн технологийн дэд бүтэц ба системийн найдвартай ажиллагаа сул, өгөгдлийн аюулгүй байдал хангагдсан талаар иргэд, байгууллагуудын итгэл сул, кибер халдлага болон бусад аюулд өртөх эрсдлийн удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн тогтолцоо дутмаг зэргийг онцолсон байна.

Өгөгдлийн тухай хууль, зохицуулалт хэрэгжиж буй Европын холбоо, БНЭсУ, БНСУ, Сингапур улсын жишээг сонгон судалж, зохицуулалтын хамрах хүрээ, сүүлийн үеийн чиг хандлага, үндэсний эрх зүйн тогтолцоо, анхаарах чиглэл, зохицуулалтын түвшинг судалсан судалгааг хоёрдахь ч эх үүсвэр болгон ашиглалаа. Судалгаанд хамрагдсан улс орнуудын нийтлэг онцлог нь өгөгдлийг ангилж, хамгаалж, ашиглах болон хил дамнасан урсгалыг зохицуулахдаа ил тод байдал, эрсдэлийн үнэлгээ, олон нийтэд тайлагнах хариуцлагыг хослуулсан уялдаа бүхий тогтолцоог бүрдүүлсэн байна. Европын Холбоо нь GDPR-ээр дамжуулан хүний эрхэд суурилсан, хүчтэй зохицуулалттай хандлагыг төлөвшүүлсэн бол Эстони улс нь иргэн төвтэй, технологид тулгуурласан хөнгөн бөгөөд уян хатан тогтолцоог хэрэгжүүлж байна. БНСУ нь өгөгдлийг хатуу хамгаалах уламжлалаа хадгалж, инновац болон олон улсын хамтын ажиллагааг хослуулсан тэнцвэртэй бодлого хэрэгжүүлж байна.

Харин Сингапур улс нь “зөөлөн зохицуулалт”-д суурилсан боловч өндөр үр дүнтэй бодлогын загварыг төлөвшүүлсэн, өгөгдөл хамгаалалт ба өгөгдлийн идэвхтэй хэрэглээг хослуулсан стратегийг тууштай хэрэгжүүлж байна. Улс орнуудыг судалсан судалгааны үр дүнгээс харахад өгөгдлийг зөвхөн ангилэх төдийгүй, тухайн ангилалд нийцсэн хамгаалалтын түвшин, хандалтын эрх, ашиглах болон хуваалцах нөхцөл, иргэний хяналт, технологийн шийдэл, байгууллагын уялдаа зэргийг цогцоор нь авч үзэх шаардлагатайг тодорхой илтгэж байна. Өгөгдлийн зохицуулалт нь хууль, технологи, институт, хэрэглэгчийн эрх, олон улсын хамтын ажиллагааны огтлолцол дээр байрладаг стратегийн асуудал бөгөөд үүнд чиглэсэн бодлого бүрдүүлсэн улс орнууд өгөгдөлд суурилсан эдийн засаг, инновацыг амжилттай хөгжүүлж байна.

Монгол Улсын хувьд өнөөгийн эрх зүйн орчинд өгөгдөлтэй холбоотой харилцааг хэсэгчлэн зохицуулсан хэд хэдэн хууль үйлчилж байгаа боловч эдгээр нь өгөгдлийн амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамарсан, нэгдсэн бодлого, зохицуулалтыг бүрдүүлж чадаагүй байна. Үүний улмаас өгөгдөлтэй холбоотой зохицуулалт нь салангид, давхардсан, уялдаа холбоо хангалтгүй, өгөгдлийн өмчлөл, хариуцлагын асуудал тодорхой бус, байгууллагуудын хооронд өгөгдөл солилцох эрх зүйн зохицуулалт тодорхой бус, өгөгдлийн ашиглалт, хамгаалалтын нэгдсэн стандартгүй байна.

Өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, хадгалах, хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэнээр эдийн засгийн өсөлт, бүтээмж, инновацын хөгжилд шууд нөлөө үзүүлэх ач холбогдолтой байна. Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт бий болсноор төрийн бодлого илүү оновчтой, үр ашигтай болж, төсвийн хөрөнгийн хуваарилалтыг илүү үр дүнтэй зарцуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ чанартай, хүртээмжтэй өгөгдөл нь шийдвэр гаргалтын өртөг, зардлыг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Мөн өгөгдлийн экосистем бүрдсэнээр хувийн хэвшлийн инновац, шинэ бизнес хөгжих боломж өргөжнө. Тухайлбал нээлттэй өгөгдөл болон өгөгдөлд суурилсан үйлчилгээ, платформууд бий болсноор финтек, ложистик, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжих суурь бүрдэж, улмаар ажлын байр нэмэгдэнэ.

Түүнчлэн өгөгдөлд суурилсан эдийн засгийн хөгжлийг дэмжих хүрээнд дата төв, үүлэн тооцоолол, хиймэл оюуны тооцооллын хүчин чадал бүхий дэд бүтцийг стратегийн чухал дэд бүтэц гэж үзэн урт хугацааны хямд бөгөөд найдвартай эрчим хүчний хангамж, сэргээгдэх эх үүсвэрт суурилсан ногоон санхүүжилтийн тогтолцоо, тарифын тусгай зохицуулалтаар дэмжих нь зүйтэй юм. Европын холбоо, БНЭсУ, БНСУ, Сингапур туршлагаас харахад дата төвийн хөгжлийг зөвхөн татварын хөнгөлөлтөөр бус, харин дэд бүтэц, зохицуулалт, инновац, хүний нөөц, тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулсан цогц стратегиар дэмжиж байна. Эдгээр улсуудын нийтлэг хандлага нь өгөгдлийн дэд бүтцийг үндэсний өрсөлдөх чадвар, дижитал эдийн засгийн суурь хүчин зүйл гэж үзэж, урт хугацааны тогтвортой орчныг бүрдүүлэхэд чиглэж байна. Европын Холбоо өгөгдлийн чөлөөт урсгал, өндөр түвшний өгөгдөл хамгаалалт, ногоон дата төвийн бодлогыг хослуулан олон улсын хөрөнгө оруулалтыг татах орчныг бүрдүүлж байгаа бол Эстони улс ил тод зохицуулалт, цахим засаглал, бизнесийн таатай орчин, дижитал ур чадварт суурилсан загварыг хэрэгжүүлж байна. Харин Солонгос улс татварын хөнгөлөлт, бүсчилсэн хөгжил,

хүний нөөцийн бодлого, инновацын сэндрокс орчныг хослуулсан стратеги ашиглаж байгаа нь дата төвийн экосистемийг эрчимтэй тэлэхэд нөлөөлж байна. Сингапур улсын хувьд газар нутаг, эрчим хүчний хязгаарлалтыг стратегийн зохицуулалт, өндөр үр ашигтай “ногоон дата” төвийн шаардлага, хөрөнгө оруулагчдад чиглэсэн уян хатан бодлогоор нөхөж, чанарт суурилсан хөгжлийн загварыг бүрдүүлжээ. Дээрх улс орнуудын туршлагаас харахад дата төвийн хөгжлийн амжилт нь тогтвортой, ил тод зохицуулалтын орчин, найдвартай эрчим хүч, өндөр хурдны холболт бүхий дэд бүтэц, татвар болон хөрөнгө оруулалтын урамшуулал, инновацыг дэмжсэн уян хатан бодлого, чадварлаг хүний нөөц, ногоон, тогтвортой хөгжлийн чиглэл зэрэг олон хүчин зүйлийн уялдаанд тулгуурлаж байна.

Монгол Улсын хувьд дата төвийн хөгжлийг зөвхөн түр хугацааны татварын хөнгөлөлтөөр хязгаарлах бус, харин үндэсний хэмжээний дижитал дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний давуу тал, бүсчилсэн хөгжил, хүний нөөцийн бодлого, инновацын зохицуулалтын орчинтой уялдуулсан урт хугацааны стратеги боловсруулах шаардлагатай байна. Мөн орон нутгийн байршлын давуу талыг ашиглах, гадаад хөрөнгө оруулалтыг татах уян хатан механизм бий болгох, “ногоон дата төв”-ийн чиглэлээр өрсөлдөх чадвар бүрдүүлэх нь Монгол Улсын өгөгдөлд суурилсан эдийн засгийн хөгжлийн чухал суурь болох боломжтой юм.

Цаашдын хөгжлийн чиг хандлагын хүрээнд Монгол Улс өгөгдлийн засаглалын тогтолцоог бүрдүүлэхдээ зөвхөн хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээгээр хязгаарлахгүйгээр дижитал эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегийн нэгэн тулгуур хүчин зүйл гэж үзэж, зохицуулалтын орчин болон олон талт оролцогчдын хамтын ажиллагаанд суурилсан цогц шинэчлэл хийх шаардлагатай байна. Энэ хүрээнд дараах бодлогын зөвлөмжийг гаргав. Үүнд:

1. Өгөгдлийн амьдралын мөчлөг (өгөгдөл боловсруулах, ашиглах, солилцох, хадгалах, устгах)-ийн бүхий л үе шатыг хамарсан эрх зүйн нэгдсэн орчныг бүрдүүлэх;
2. Өгөгдөлтэй холбоотой нэр томъёо, түүний ангиллыг нарийвчлан тогтоох;
3. Өгөгдлийн засаглал, өгөгдлийн харилцаанд оролцогчдийн эрх, чиг үүргийг нарийвчлан тогтоох;
4. Өгөгдлийн үндэсний дэд бүтэц, их өгөгдлийн санг үүсгэх, хаалттай, хязгаарлалттай өгөгдлийг олон нийтэд хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох;
5. Хил дамнасан өгөгдлийн зохицуулалт бий болгох, олон улсын шаардлагад нийцсэн өгөгдөл дамжуулах журам, хамгаалалтын механизм (жишээлбэл, стандарт гэрээ, зөвшөөрлийн нөхцөл)-ийг бий болгох;
6. Хүний хувийн мэдээллийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах болон зах зээлийн шударга өрсөлдөөний тэнцвэрийг хадгалах;
7. Шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн үнэн зөв, нийцтэй, найдвартай байдлыг хангах;

8. Мэдээллийг хариуцлагатай ашиглах, тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхлаас зайлсхийх.
9. Дата төв, үүлэн тооцоолол, хиймэл оюуны тооцооллын хүчин чадал бүхий дэд бүтцийг стратегийн чухал дэд бүтэц гэж үзэн урт хугацааны хямд бөгөөд найдвартай эрчим хүчний хангамж, сэргээгдэх эх үүсвэрт суурилсан ногоон санхүүжилтийн тогтолцоо, тарифын тусгай зохицуулалтаар дэмжих.

## НОМ ЗҮЙ

### Монгол хэл дээрх эх сурвалж

#### Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, 2024 он.
3. Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, 2025 он.
4. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, 2024 он.
5. Цахим технологийн шинжилгээ хийх журам, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/315, А/91 дугаар хамтарсан тушаалын хавсралт.
6. “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги”, Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 44 дүгээр тогтоолын хавсралт.
7. “Зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоол, Хавсралт 15.
8. “Цахимаар нэн тэргүүнд (Digital first)” бодлогын зөвлөмж, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралт.
9. Хиймэл оюуны ёс зүйн тухай зөвлөмж, ЮНЕСКО, 2021, [https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000381137\\_mon](https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000381137_mon)
10. Монгол Улсын Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төсөл, ЦХИХХЯ.
11. “Их өгөгдлийн (Big Data) сан үүсгэх тухай”, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны 403 дугаар тогтоол.
12. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17434151782372&showType=1>.
13. Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17434151883062&showType=1>.
14. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай, Монгол Улсын Их Хурлын 35 дугаар тогтоол, 2024.10.18, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17142247261431&sword=%D1%85%D0%B8%D0%B9%D0%BC%D1%8D%D0%BB%20%D0%BE%D1%8E%D1%83%D0%BD%20%D1%83%D1%85%D0%B0%D0%B0%D0%BD>
15. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай, Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол, 2025.05.29, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432520199262>

### **Бодлогын судалгаа**

1. Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа, 2025 он;
2. Үндэсний өгөгдлийн стратеги боловсруулах бодлогын судалгаа, 2025 он;
3. Нээлттэй өгөгдөл, түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах нь бодлогын судалгаа, зөвлөмж, 2023 он;
4. Үндэсний статистикийн хороо болон Азийн хөгжлийн банк хамтран хийсэн “Үндэсний өгөгдлийн засаглалын замын зураглал, 2024 он;
5. Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн байдлын үнэлгээний тайлан, 2024 он;
6. Их өгөгдлийн сан (Big data) үүсэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох судалгаа, ЦХХХЯ, 2024 он.
7. Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, 2025 он, [https://www.undp.org/sites/g/files/zskgqe326/files/2025-08/aila\\_eng-final.pdf](https://www.undp.org/sites/g/files/zskgqe326/files/2025-08/aila_eng-final.pdf);
8. Үндэсний статистик сэтгүүл, 2024 он;
9. Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний судалгаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яам Үндэсний статистикийн хороо, 2021 он, <https://mddic.gov.mn/mn/2022/02/4940/>;
10. Монгол улс дахь хуурамч мэдээллийн зураглалын судалгаа, “Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь” төсөл, IRIM Монгол улсын бие даасан судалгааны хүрээлэн, 2025.12 сар, [https://resource4.sodonsolution.org/irim/File/2026/01/14/r9h9d5pe2xqosxpt/IRIM-EU-Mapping%20Report-Mon-Final.pdf?utm\\_source=lemonpressnewsletter.beehiiv.com&utm\\_medium=newsletter&utm\\_campaign=k-pop-300&bhlid=64bc615618b744acdf7b8cb52a65f749a25d5277](https://resource4.sodonsolution.org/irim/File/2026/01/14/r9h9d5pe2xqosxpt/IRIM-EU-Mapping%20Report-Mon-Final.pdf?utm_source=lemonpressnewsletter.beehiiv.com&utm_medium=newsletter&utm_campaign=k-pop-300&bhlid=64bc615618b744acdf7b8cb52a65f749a25d5277).

### **Бусад**

1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2025 он, [https://nhrcm.gov.mn/pdf/KHUNII\\_ERKHI\\_24\\_deh\\_iltgel.pdf](https://nhrcm.gov.mn/pdf/KHUNII_ERKHI_24_deh_iltgel.pdf)
2. ЦХИХХЯ-ны цахим хуудас, <https://www.facebook.com/photo/?fbid=1310531744447091&set=a.252522460248030>
3. Мэдээ: Эстони болон Монгол Улсын цахим хөгжлийн харьцуулалт, Б.Даваабазар, 2019.12.04 <https://ikon.mn/n/1qit>.
4. Мэдээ: Далайд гарцгүй Монгол Улсын Цахим Үндэстэн болох замнал: Ахиц дэвшил, сорилтууд, 2024.10.07, <https://mongolia.un.org/mn/280629-%D0%B1%D0%BB%D0%BE%D0%B3-%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B0%D0%B9%D0%B4-%D0%B3%D0%B0%D1%80%D1%86%D0%B3%D2%AF%D0%B9-%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-%D1%86%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D1%82%D1%8D%D0%BD-%D0%B1%D0%BE%D0%BB%D0%BE%D1%85->

[%D0%B7%D0%B0%D0%BC%D0%BD%D0%B0%D0%BB-%D0%B0%D1%85%D0%B8%D1%86-%D0%B4%D1%8D%D0%B2%D1%88%D0%B8%D0%BB-%D1%81%D0%BE%D1%80%D0%B8%D0%BB%D1%82%D1%83%D1%83%D0%B4](https://www.facebook.com/emongolia.academy/posts/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-18-%D1%81-%D0%B4%D1%8D%D1%8D%D1%88-%D0%BD%D0%B0%D1%81%D1%82%D0%B0%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-872-%D0%BD%D1%8C-%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%86%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%81%D0%B8%D1%81%D1%82%D0%B5%D0%BC-e/634150246042093/)

5. Мэдээ: И-Монгол академи, 2025.03.31,

<https://www.facebook.com/emongolia.academy/posts/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-18-%D1%81-%D0%B4%D1%8D%D1%8D%D1%88-%D0%BD%D0%B0%D1%81%D1%82%D0%B0%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-872-%D0%BD%D1%8C-%D1%82%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%86%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%81%D0%B8%D1%81%D1%82%D0%B5%D0%BC-e/634150246042093/>

## Гадаад хэл дээрх эх сурвалж

### Эрх зүйн эх сурвалж

1. Европын парламент ба Европын холбооны зөвлөл. (2016). Европын парламент болон зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн (EX) 2016/679 журам — Хувийн өгөгдлийг боловсруулахтай холбоотой хувь хүний хамгаалал болон эдгээр өгөгдлийг чөлөөтэй шилжүүлэх тухай (Өгөгдөл хамгаалах ерөнхий журам), EUR-Lex. <https://eur-lex.europa.eu/eli/reg/2016/679/oj>;
2. Европын парламент ба Европын холбооны зөвлөл. (2018). Европын парламент болон зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн (EX) 2018/1807 журам — Европын Холбооны хүрээнд хувийн шинжгүй өгөгдлийн чөлөөтэй урсгалын үндсэн зохицуулалт, EUR-Lex, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32018R1807>;
3. Европын Комисс. (2019). 2019/1024 тоот удирдамж — Нээлттэй өгөгдөл ба төрийн байгууллагын мэдээллийг дахин ашиглах тухай (EX), EUR-Lex <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32019L1024>;
4. Европын Комисс. (2022). 2022/868 тоот журам — Европын өгөгдлийн засаглалын тухай хууль (Data Governance Act), EUR-Lex; <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32022R0868>;
5. Эстони улсын Засгийн газар. (2000). Олон нийтийн мэдээллийн тухай хууль. Riigi Teataja (Төрийн сонин), <https://www.riigiteataja.ee/en/eli/529032019012/consolide>;
6. БНСУ-ын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн. (2020). Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (PIPA). e-Law Korea [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=53044&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53044&lang=ENG);
7. Сингапурын Хувийн Мэдээлэл Хамгаалах Комисс. (2020), Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (PDPA), 2012 он. <https://www.pdpc.gov.sg/overview-of-pdpa/the-legislation/personal-data-protection-act>;

## ХАВСРАЛТ

### ӨГӨГДЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУМЖ

1. Монгол Улс Өгөгдлийн засаглалын талаар бие даасан хуультай болох шаардлагатай юу?  
*Санал:*.....
2. Өгөгдөл, өгөгдлийн сантай холбоотой нэр томъёоны толь шаардлагатай юу?  
*Санал:*.....
3. Өгөгдлийг стандартчилах шаардлагатай юу?  
*Санал:*.....
4. Өгөгдлийг цуглуулахад тулгамдаж байгаа, шийдвэрлэх шаардлагатай ямар асуудлууд байна гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
5. Өгөгдлийг боловсруулахад тулгамдаж байгаа, шийдвэрлэх шаардлагатай ямар асуудлууд байна гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
6. Өгөгдлийг ашиглахад тулгамдаж байгаа, шийдвэрлэх шаардлагатай ямар асуудлууд байна гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
7. Өгөгдлийг хамгаалахад тулгамдаж байгаа, шийдвэрлэх шаардлагатай ямар асуудлууд байна гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
8. Өгөгдөл солилцохтой холбоотой салбар хоорондын үйл ажиллагаа, уялдаа холбоо ямар байна вэ?  
*Санал:*.....
9. Өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцоход гарч болзошгүй эрсдэлээс хамгаалахад ямар зохицуулалт байх шаардлагатай вэ?  
*Санал:*.....
10. Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад төрөөс ямар зохицуулалт шаардлагатай вэ?  
*Санал:*.....
11. Өгөгдөл шинжлэл, өгөгдлийн сангийн чиглэлээр ажиллах хүний нөөц хүрэлцээтэй байна уу?  
*Санал:*.....
12. Салбарууд өгөгдлөө тусдаа бүрдүүлээд хоорондоо солилцох эсвэл нэгдсэн санд төвлөрүүлээд өгөгдлөө солилцох хоёрын аль нь хэрэгцээтэй гэж үзэж байна вэ? Яагаад?  
*Санал:*.....

13. Үндэсний их өгөгдлийг тусгайлан хариуцсан байгууллага байх хэрэгтэй гэж үзэж байна уу? Хэрвээ хэрэгтэй бол тогтолцоог нь ямар байх талаар саналаа илэрхийлнэ үү.  
*Санал:*.....
14. Гадаад улс орон, олон улсын байгууллагаас гаргасан Өгөгдлийн тухай хууль тогтоомжид тусгасан тэргүүн туршлагын талаар саналаа илэрхийлнэ үү.  
*Санал:*.....
15. Өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, хамгаалахад хүний эрхэд үзүүлэх нөлөөг та юу гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
16. Өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, хамгаалахад эдийн засагт үзүүлэх нөлөөг та юу гэж үзэж байна вэ?
17. Өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, хамгаалахад нийгмийн үр нөлөөг та юу гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
18. Өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, хамгаалахад байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг та юу гэж үзэж байна вэ?  
*Санал:*.....
19. Нэмэлт санал:.....